“Барилгын ажлын төлөөлөгч” гэж энэхүү Гэрээний 23.2.3 дах хэсэг (Концессын зүйлийн сайжруулалт)-т заасны дагуу Концессын зүйлийн сайжруулалт болон Концессын талбайд хийгдэж буй бусад барилгын ажлыг хянах үүрэгтэйгээр Эрх бүхий этгээд болон/эсхүл Концесс эзэмшигчээс томилогдсон, зохих шалгуур хангасан этгээдийг;

“Гэрээгээр газар ашиглуулах эрхийн тухай гэрээ” гэж Концесс эзэмшигчид Концессын талбайг ашиглуулах эрх олгох талаар Засгийн газрын 2017 оны 298 дугаар тогтоолын дагуу Концесс эзэмшигч болон холбогдох Төрийн эрх бүхий байгууллагын хооронд байгуулагдах гэрээг;

“Хяналт” гэж аливаа этгээдийн хувьд:

- (а) тухайн этгээдийн саналын эрхтэй хувьцааны тавин хувь (50%)-аас дээш хувийг (шууд ба шууд бусаар)-өмчлөх;
- (б) тухайн этгээдийн төлөөлөн удирдах зөвлөл болон хувьцаа эзэмшигчдийн хуралд хэрэгжүүлэх боломжтой саналын тавин хувь (50%)-аас дээш хувийг удирдах, чиглүүлэх чадвар; эсхүл
- (в) тухайн этгээдийн бодлого, менежментийн чиглэлийг гэрээгээр эсхүл бусад хэлбэрээр удирдах, түүнд нөлөөлөх чадварыг ойлгох ба

хяналт/Хяналт хэрэгжүүлэх эсхүл хяналтад/Хяналтад байх гэдгийг дээрх тодорхойлолтод нийцүүлэн тайлбарлана.



"ХҮИ" гэж Монгол Улсын Үндэсний статистикийн газраас нийтлэсэн Монгол Улсын хэрэглээний үнийн индексийг;

"Доголдол арилгах баталгаат хугацаа" гэж Барилгын ажил гүйцэтгэх гэрээтэй холбоотой аливаа баталгаат буюу доголдол арилгах баталгаат хугацааг;

"Хойшлуулах нөхцөл" гэж Үйл ажиллагаа эхлэх өдрийг Үйл ажиллагаа эхлэх төлөвлөгөөт өдрөөс хойш тохиолдоход хүргэж байгаа аливаа үйл явдал, үйлдэл болон эс үйлдэхүйг;

"Хойшлуулж байгаа тал" гэж энэхүү Гэрээний 17.1.1 дэх хэсэг (Хойшлуулах нөхцөлийн тухай мэдэгдэл)-т заасныг;

"Шууд хохирол" гэж ашгийн алдагдал (Концессын төлбөрийн хэмжээ буурсан зөрүүг үүнд хамааруулна), ашиглалтын алдагдал, бизнесийн алдагдал, бизнесийн боломжийн алдагдал болон үр дагаврын буюу шууд бус шинжтэй алдагдлаас үүдэлтэй аливаа шаардлагаас бусад аливаа Хохирлыг;

"Дотоодын агаарын тээвэрлэгч" гэж Монгол Улсын хуулийн дагуу үүсгэн байгуулагдсан, Монгол Улсад бүртгэлтэй Агаарын тээвэрлэгч компанийг;

"Гэрээ хүчин төгөлдөр болох өдөр" гэж энэхүү Гэрээний 7.2 дах хэсэг (Гэрээ хүчин төгөлдөр болох өдөр)-т заасныг;


"Онцгой нөхцөл байдал" гэж Нисэх буудлын онцгой байдлын төлөвлөгөөнд заасан хүний эрүүл мэнд, аюулгүй байдал болон УБХОУНОШБ-ын эд хөрөнгөд шууд аюул, занал учруулж байгаа эсхүл УБХОУНОШБ-ын аюулгүй байдлыг зөрчиж буй нөхцөл байдал, төлөв, тохиолдлыг;

"Сайжруулах санал" гэж Концессыг сайжруулах санал, энэхүү Гэрээний 20.2 дах хэсэг (Нисэх буудлыг хөгжүүлэх санал)-т заасны дагуу гаргасан Нисэх буудлыг хөгжүүлэх санал эсхүл Концесс эзэмшигчийн хариу саналыг;

"Концессын хугацаа дуусгавар болох өдөр" гэж энэхүү Гэрээний 6 дугаар зүйл (Концессын хугацаа)-д заасан Концессын хугацааны сүүлийн өдрийг;

"Эд хөрөнгө хураах, дайчлан авах" гэж

- (а) холбогдох Төрийн эрх бүхий байгууллагаас Нисэх буудлын бизнесийг бүхэлд нь буюу түүний аливаа хэсгийг, эсхүл түүнд хамаарах эд хөрөнгийг, Концесс эзэмшигчийн эд хөрөнгө, эрхийг



эсхүл Концесс эзэмшигчийн хувьцааг төрийн өмчид авах, хураан авах, тусгаарлах, улсын өмч болгох эсхүл бусад байдлаар дайчлан авах ажиллагааг; эсхүл

- (б) Концесс эзэмшигчийн зүгээс Нисэх буудлын бизнесийн үйл ажиллагаа (эсхүл түүний аль нэг хэсгийг) энэхүү Гэрээний дагуу эрхлэн явуулахад холбогдох Төрийн эрх бүхий байгууллагаас саад учруулах (Концесс эзэмшигч үүргийн зөрчил гаргасантай холбоотойгоос бусдаар)-ыг

тус тус ойлгох ба аль ч тохиолдлын хувьд нэг удаагийн эсхүл дээрх үр дагаварт хүргэсэн хэд хэдэн удаагийн үйлдэл эсэх нь хамааралгүй байна.

"Концесс эзэмшигчийн эцсийн тайлан" гэж энэхүү Гэрээний 41.7 дэх хэсэг (Гэрээ дуусгавар болох эсхүл Гэрээ цуцлах үед Концессын зүйл болон Концесс эзэмшигчийн хөрөнгөөр бий болсон эд хөрөнгийг буцаан шилжүүлэх)-т заасныг;

"Санхүүгийн төлөвлөгөө" гэж жилийн үйл ажиллагааны төсөв, ирээдүйн орлого, эд хөрөнгийн үнэлгээ, зарлагын төлөвлөгөө зэргийг урьдчилан тооцоолох зорилгоор тухайн үед мэдэгдэж байгаа хувьсагчдыг ашиглан, жилийн зорчигч болон ачаа тээврийн төлөвлөгөө, бизнесийн үндсэн үйл ажиллагаа, маркетингийн стратеги болон Нисэх буудлын бизнесийн бодлого гэх мэт мэдэгдэж буй хүчин зүйлсийг мөн тусган гурав (3)-аас доошгүй Концессын жилийн хугацааг хамруулан Концесс эзэмшигчээс боловсруулсан дэлгэрэнгүй, нарийвчилсан санхүүгийн төлөвлөгөөг;

"Санхүүгийн тайлан" гэж Монгол Улсын Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 3 дугаар бүлэгт заасныг;

"Давагдашгүй хүчин зүйл" гэж энэхүү Гэрээний 45.1 дэх хэсэг (Давагдашгүй хүчин зүйл)-т заасныг;

"Давагдашгүй хүчин зүйлийн мэдэгдэл" гэж энэхүү Гэрээний 45.3 дах хэсэг (Давагдашгүй хүчин зүйлийн мэдэгдэл)-т заасныг;

"Төлөвлөгдөж буй байгууламжууд" гэж энэхүү Гэрээний Хавсралт 4 (Удирдлага, зохион байгуулалтын нарийвчилсан хуваарь)-т "ЗТХЯ-ны Мастер төлөвлөгөөнд суурилан Төлөвлөгдөж буй байгууламжууд (Концессын бус зүйл)" гэж ногоон өнгөөр тэмдэглэгдсэн зүйл тус бүрийг;

"Салбарын сайн туршлага" гэж ижил эсхүл төсөөтэй нөхцөл байдалд, ижил үйл ажиллагаа эрхэлж буй ур чадвар, туршлагатай этгээдийн зүгээс гэрээгээр хүлээсэн үүрэг болон холбогдох хууль тогтоомжид заасан шаардлагыг шударгаар биелүүлэхийн тулд хэрэгжүүлэхтэй

холбоотойгоор зүй ёсоор хүлээгдэх түвшний ур чадвар, хичээл зүтгэл, хянуур болгоомж, урьдчилан таамаглах чадвар хэрэгжүүлэхийг;

“Засгийн газрын хувьцаа эзэмшигч” гэж Монгол Улс, Сүхбаатар дүүрэг, 1 дүгээр хороо, Нарны зам 91, Нарны зам барилга, 801 тоот хаягт бүртгэлтэй, Монгол Улсын төрийн өмчит “Хөшигийн хөндий нисэх буудал” ХХК-г;

“Засгийн газар” гэж Монгол Улсын Засгийн газрыг;

“Эрх бүхий этгээд” гэж Монгол Улсын Засгийн газрыг төлөөлж буй Үндэсний хөгжлийн газар эсхүл Хууль тогтоомжийн дагуу энэхүү Гэрээнд заасан Эрх бүхий этгээдийн эрх, үүргийг хүлээн авсан концессын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагыг;

“Эрх бүхий этгээдийн урьдчилсан нөхцөлүүд” гэж Урьдчилсан нөхцөлүүд хангагдахад шаардлагатай, энэхүү Гэрээний 16.4 дэх хэсэг (Эрх бүхий этгээдийн урьдчилсан нөхцөл)-т заасан урьдчилсан нөхцөлүүдийг;

“Эрх бүхий этгээдийн үүргийн зөрчил” гэж энэхүү Гэрээний 38.1 дэх хэсэг (Эрх бүхий этгээдийн үүргийн зөрчлийн улмаас гэрээ цуцлах)-т заасныг;

“Эрх бүхий этгээд үүргийн зөрчил гаргасан тухай мэдэгдэл” гэж энэхүү Гэрээний 38.2 дах хэсэг (Эрх бүхий этгээдийн үүргийн зөрчлийн улмаас гэрээ цуцлах)-т заасныг;

“Эрх бүхий этгээдийн хойшлуулах нөхцөлийн зардал” гэж энэхүү Гэрээний 17.4 дэх хэсэг (Эрх бүхий этгээдийн хойшлуулах нөхцөлийн нөхөн төлбөр)-т заасныг;

“Эрх бүхий этгээдийн чиг үүрэг” гэж энэхүү Гэрээний 9.1 дэх хэсэг (Эрх бүхий этгээдийн чиг үүрэг)-т заасныг;

“Эрх бүхий этгээд засвар үйлчилгээг нь хариуцах зүйл” гэж энэхүү Гэрээний Хавсралт 4 (Удирдлага, зохион байгуулалтын нарийвчилсан хуваарь)-т “Засвар үйлчилгээг хариуцах” гэсэн мөрөнд “Эрх бүхий этгээд” гэж тэмдэглэсэн барилга байгууламжуудыг;

“Эрх бүхий этгээд үйл ажиллагааг нь эрхлэх зүйл” гэж энэхүү Гэрээний Хавсралт 4 (Удирдлага, зохион байгуулалтын нарийвчилсан хуваарь)-т “Үйл ажиллагааг эрхлэх” гэсэн мөрөнд “Эрх бүхий этгээд” гэж тэмдэглэсэн барилга байгууламжуудыг;

“Эрх бүхий этгээдтэй хамаарал бүхий этгээд” гэж

- (а) Эрх бүхий этгээдийн аливаа албан тушаалтан, албан хаагч, итгэмжлэгдсэн этгээд болон ажилтныг;
- (б) бусад концесс эзэмшигч, туслан гүйцэтгэгч, ханган нийлүүлэгчид гэх мэт УБХОУНОШБ-ын үйл ажиллагаатай холбоотойгоор Эрх бүхий этгээд эсхүл Төрийн эрх байгууллагаас томилогдсон аливаа гуравдагч этгээдийг;
- (в) аливаа Төрийн эрх бүхий аливаа байгууллага эсхүл уг байгууллагын албан тушаалтан, албан хаагч, итгэмжлэгдсэн этгээд болон ажилтан.

“Эрх бүхий этгээдийн гэрээ цуцлах тухай мэдэгдэл” гэж энэхүү Гэрээний 37.3 дах хэсэг (Концесс эзэмшигчийн үүргийн зөрчлийн улмаас гэрээ цуцлах)-т заасныг;

“Газрын үйлчилгээний тоног төхөөрөмж” гэж энэхүү Гэрээний Хавсралт 4 (Удирдлага, зохион байгуулалтын нарийвчилсан хуваарь)-т 4 дэх зүйл гэж тэмдэглэгдсэн “Газрын үйлчилгээний тоног төхөөрөмжийн засвар үйлчилгээний барилга”-д хамаарах Концессын зүйлийг;

“Буцаан шилжүүлэх комисс” гэж батлагдсан Буцаан шилжүүлэх төлөвлөгөө болон Буцаан шилжүүлэхэд тавигдах шаардлагын дагуу Нисэх буудлын бизнес, Концессын зүйл, Концесс эзэмшигчийн хөрөнгөөр бий болсон эд хөрөнгө болон шинээр бий болсон эд хөрөнгө (үүнд энэхүү Гэрээний 19 дүгээр зүйл (Сайжруулах санал)-ийн дагуу Концессын зүйлд хийгдсэн хөгжүүлэлт, сайжруулалт, өргөтгөл зэрэг хамаарна)-ийг буцаан шилжүүлэх ажлыг хариуцах, Эрх бүхий этгээд, ЗТХЯ, Иргэний нисэхийн ерөнхий газар болон Концесс эзэмшигч нараас бүрдсэн ажлын хэсгийг;

“Буцаан шилжүүлэх төлөвлөгөө” гэж Нисэх буудлын бизнесийг Концесс эзэмшигчээс Эрх бүхий этгээдэд буцаан шилжүүлэхтэй холбоотойгоор энэхүү Гэрээний 41.3 дах хэсэг (Гэрээ дуусгавар болох эсхүл Гэрээ цуцлах үед Концессын зүйл болон Концесс эзэмшигчийн хөрөнгөөр бий болсон эд хөрөнгийг буцаан шилжүүлэх)-т заасны дагуу Талуудын харилцан тохиролцох төлөвлөгөөг;

“Буцаан шилжүүлэхэд тавигдах шаардлага” гэж Нисэх буудлын бизнесийг Концесс эзэмшигчээс Эрх бүхий этгээдэд буцаан шилжүүлэхтэй холбоотойгоор энэхүү Гэрээний 41.3 дах хэсэг (Гэрээ дуусгавар болох эсхүл Гэрээ цуцлах үед Концессын зүйл болон Концесс эзэмшигчийн хөрөнгөөр бий болсон эд хөрөнгийг буцаан шилжүүлэх)-т заасны дагуу Талуудын харилцан тохиролцох шаардлагуудыг;

"ОУАТХ" гэж Олон Улсын Агаарын Тээврийн Холбоог;

"ОУИНБ" гэж Олон улсын иргэний нисэхийн тухай 1944 оны 12 дугаар сарын 7-ны өдөр Чикаго хотноо батлагдсан олон улсын конвенцоор байгуулагдсан Олон Улсын Иргэний Нисэхийн Байгууллагыг;

"Сайжруулалт" гэж Концессын зүйлийг солих, шинэчлэх, засварлах томоохон хэмжээний ажил (үүнд өдөр тутмын засвар үйлчилгээтэй холбоотой солих, шинэчлэх, засварлах ажил хамаарахгүй)-ыг;

"Нөхөн төлбөр авах тал" гэж энэхүү Гэрээний 35.1 дэх хэсэг (Нөхөн төлбөр төлүүлэх шаардлага гаргах)-т заасныг;

"Нөхөн төлбөр төлөх тал" гэж энэхүү Гэрээний 35.1 дэх хэсэг (Нөхөн төлбөр төлүүлэх шаардлага гаргах)-т заасныг;

"Эхлэлтийн хөрөнгө оруулалт" гэж (1) Хувьцаа эзэмшигчийн гэрээнд заасны дагуу Концесс эзэмшигчийн энгийн хувьцааны захиалгын үнийн дүн болох 36.6 сая ам.доллар болон (2) Нисэх буудлын үйл ажиллагааг эхлүүлэх бэлтгэл үе шатанд Концессын зүйлийн Засварын ажилд бодитоор зарцуулсан ба таван сая (5,000,000) ам.доллараас хэтрэхгүй зардлын үнийн дүн (Нисэх буудлын үйл ажиллагааг эхлүүлэх бэлтгэл үе шатны төгсгөлд тооцоолно)-г ойлгох ба энэхүү үнийн дүнгийн нийлбэрийг ойлгоно. Үүнд:

"Оюуны өмч" гэж патент, зохиогчийн эрх, барааны тэмдэг болон Хууль тогтоомжоор зөвшөөрсөн бусад оюуны өмчийн эрхийг;

"ЖЭЛЮКС" гэж Япон Улс, Токио хот, Минато-ку, Конан, 1-2-70, Шинагава Сийзон Тэррэйс хаягт бүртгэлтэй ЖЭЛЮКС Инк-ийг;

"ЖЭТКО" гэж Япон Улс, Токио хот, 144-0041, Ота-ку, 3cho-me, Ханэда Нисэх буудал, 3-2 хаягт бүртгэлтэй Жапан Эйрпорт Терминал Ко., Лтд-ийг;

"Терминал, түүнд хамаарах байгууламжууд" гэж энэхүү Гэрээний Хавсралт 4 (Удирдлага, зохион байгуулалтын нарийвчилсан хуваарь)-т "Терминал, түүнд хамаарах байгууламжууд" гэх багананд зааж, Шилжилтийн төлөвлөгөөнд дэлгэрүүлж тодорхойлсон Концессын зүйлийг;

"Хууль тогтоомж" гэж Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээ, хууль, журам, стандартууд болон Монгол Улсын их хурал эсхүл захиргааны байгууллагаас гаргасан хэм хэмжээний актыг;

"Урт хугацаат зогсолтын өдөр" гэж Үйл ажиллагаа эхлэх төлөвлөгөөт өдрөөс хойш зургаан (6) сарын дараах өдөр эсхүл түүнээс хойшхи Талуудын тохирсон өдрийг;

"Хохирол" гэж аливаа төлбөр, хохирол, зардал, торгууль, алданги, эд хөрөнгийн алдагдал буюу гэмтлийг;

"Засвар үйлчилгээний зүйл" гэж энэхүү Гэрээний Хавсралт 4 (Удирдлага, зохион байгуулалтын нарийвчилсан хуваарь)-т "Засвар үйлчилгээг хариуцах" (гэхдээ үйл ажиллагааг нь эрхлэхгүйгээр) гэсэн мөрөнд Концесс эзэмшигч гэж заасан барилга байгууламжууд болон Сайжруулах саналын дагуу Концесс эзэмшигч засвар үйлчилгээг нь хариуцах (гэхдээ үйл ажиллагааг нь эрхлэхгүйгээр)-аар Талуудын харилцан тохиролцсон бусад барилга байгууламжуудыг;

"Зам, тээврийн хөгжлийн яам эсхүл ЗТХЯ" гэж Монгол Улсын Зам, тээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагыг;

"Мицубиши" гэж Япон Улс, Токио хот, Чиёода-ку, Маруноучи 2- Хомэ, 3-1 хаягт бүртгэлтэй Мицубиши Корпорацийг;


"НИЭК" гэж Япон Улс, 282-8601, Чиба аймаг, Нарита хот, Фуругоме, Фуругоме Аза 1-1 хаягт бүртгэлтэй НАРИТА ИНТЕРНЭЙШНЛ ЭЙРПОРТ КОРПОРАЙШН-ийг;

"Зохицуулалтгүй төлбөр, хураамж" гэж энэхүү Гэрээний Хавсралт 2 (Төлбөр, хураамж)-ийн 2 дугаар хэсэгт заасан зохицуулалтгүй төлбөр, хураамжуудыг;

"Концессын бус зүйл" гэж энэхүү Гэрээний 3.2 дах хэсэг (Концессын бус зүйл)-т заасныг;

"УБХОУНОШБ" гэж Монгол Улс, Төв аймаг 41090, Сэргэлэн сум, 4 дүгээр баг хаягт бүртгэлтэй, Монгол Улсын Иргэний нисэхийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.18 дах заалтад заасны дагуу аэродром болон агаарын тээврийн үйлчилгээний барилга, байгууламжийн цогцолбор бүхий Улаанбаатар хотын Олон улсын нисэх онгоцны шинэ буудлыг;

"Үйл ажиллагаа ба Засвар үйлчилгээний зүйл эсхүл ҮАЗҮ" гэж энэхүү Гэрээний Хавсралт 4 (Удирдлага, зохион байгуулалтын нарийвчилсан хуваарь)-т "Үйл ажиллагааг эрхлэх" болон "Засвар үйлчилгээг хариуцах" гэсэн мөрөнд Концесс эзэмшигч гэж заасан барилга байгууламжууд болон Сайжруулах саналын дагуу Концесс эзэмшигч үйл ажиллагааг нь эрхэлж, засвар үйлчилгээг нь хариуцахаар Талуудын харилцан тохиролцсон бусад барилга байгууламжуудыг;



“ҮАЗҮ-ний тайлан” гэж энэхүү Гэрээний 29.1 дэх хэсэг (Тайлан)-т заасны дагуу Концесс эзэмшигчээс Эрх бүхий этгээд болон Иргэний нисэхийн ерөнхий газарт улирал бүр хүргүүлэх үйл ажиллагаа ба засвар үйлчилгээний тайлан;

“ОУАТХ-ны Үйлчилгээний түвшний Оптимум түвшин” гэж ОУАТХ-оос баталсан Нисэх буудлын заавар боловсруулах гарын авлагад заасан Нисэх буудлын хэрэглэгчийн сэтгэл ханамжийн түвшинг (өмнө нь “С” түвшин гэдэг байсан);

“Зорчигч терминалын барилга” гэж терминалын зам, терминалын гүүр, захиргааны барилгыг холбох хонгил болон эдгээрт хамаарах бүх туслах байгууламж, тэмдэг, тэмдэглэгээ, гэрэлтүүлэг, тоног төхөөрөмж болон хилийн хяналт, хорио цээр/мэргэжлийн хяналтын байгууллагуудын барилга байгууламжууд зэргийг хамарсан, Нисэх буудлын талбайн зургийн 22 дугаар зүйлд харуулсан зорчигч терминалын барилгыг;

“Гүйцэтгэлийн тайлан” гэж энэхүү Гэрээгээр хүлээсэн үүргийн биелэлтийн талаар Концесс эзэмшигчээс Эрх бүхий этгээд болон Иргэний нисэхийн ерөнхий газарт хүргүүлэх гурван (3) Концессын жилийг хамарсан тайланг;

“Үйл ажиллагаа эхлэх төлөвлөгөөт өдөр” гэж Гэрээ хүчин төгөлдөр болох өдрөөс хойш арван (10) сарын дараах өдөр эсвэл түүнээс хойшхи:

- (а) энэхүү Гэрээний 17 дугаар зүйл (Үйл ажиллагаа эхлэх өдрийг сунгах, нөхөн төлбөр төлөх, хойшлуулсны улмаас гэрээ цуцлах)-д заасны дагуу тодорхойлсон өдрийг; эсхүл
- (б) Талууд Шилжилтийн төлөвлөгөөний дагуу харилцан тохиролцсон өдрийг.

“Нисэх буудлын үйл ажиллагааг эхлүүлэх бэлтгэл үе шат” гэж Гэрээ хүчин төгөлдөр болох өдрөөс Үйл ажиллагаа эхлэх өдөр хүртэлх хугацааг;

“Төлөвлөсөн ХОДӨ” энэхүү Гэрээний 28.1 дэх хэсэг (Хөрөнгө оруулалтын дотоод өгөөж)-т заасныг;

“Саналын баталгаа” гэж энэхүү Гэрээний дагуу олгож буй концессын онцгой эрхтэй холбоотойгоор Консерциумын гишүүдээс Эрх бүхий этгээдэд гаргасан баталгааг;

“Төрийн эрх бүхий байгууллага” гэж Нисэх буудлын бизнес, Нисэх буудлын үйлчилгээний аливаа хэсгийн хувьд эрх хэмжээ бүхий эсхүл бусад байдлаар холбоотой аливаа төрийн эрх бүхий байгууллага (үүнд

Эрх бүхий этгээд хамаарахгүй), агентлаг, яам болон газрыг ойлгох ба үүнд дараах этгээд хамаарна:

(а) ЗТХЯ болон

(б) Иргэний нисэхийн ерөнхий газар.

“Төрийн эрх бүхий байгууллагын авах зөвшөөрлүүд” гэж энэхүү Гэрээнд заасан Эрх бүхий этгээдийн чиг үүрэг болон Эрх бүхий этгээдийн аливаа бусад үүргийг хэрэгжүүлэхэд шаардлагатай аливаа Төрийн эрх бүхий байгууллагын зүгээс холбогдох эрх бүхий байгууллагаас авах бүх зөвшөөрөл, эрх, лиценз, эрх олголт, гэрчилгээ, хуульд заасан гэрээг болон Төрийн эрх бүхий байгууллагын зүгээс гуравдагч этгээдээс авах бүх зөвшөөрөл болон гэрээг;

“Зохицуулалттай төлбөр, хураамж” гэж энэхүү Гэрээний Хавсралт 2 (Төлбөр хураамж)-ийн 1 дүгээр хэсэгт заасан зохицуулалттай төлбөр, хураамжийг;

“Хувьцаа эзэмшигчдийн гэрээ” гэж Засгийн газрын хувьцаа эзэмшигч болон Консерциум ТЗК нарын хооронд 2019 оны 6 дугаар сарын 25-ны өдөр байгуулагдсан хувьцаа эзэмшигчдийн гэрээг;

“Улсын мэргэжлийн хяналтын комисс” гэж Хууль тогтоомжид заасан Монгол Улсын мэргэжлийн хяналтын улсын комиссыг;

“Барилгын бүтцийн алдаа” гэж Улсын мэргэжлийн хяналтын комиссыг оролцуулаад холбогдох Төрийн эрх бүхий байгууллагаас албан ёсоор тогтоосны дагуу Нисэх буудлын бизнесийг бүхэлд нь хаахад хүргэсэн, шилжүүлэх үйл явцын үеэр илрүүлэх боломжгүй байсан (Концесс эзэмшигч болон/эсхүл түүний аль нэг Нэгдмэл сонирхолтой этгээд мэдэж байснаас бусдаар) барилга байгууламжийн буюу барилгын ажлын аливаа доголдлыг;

“Зорилтот ХОДӨ” гэж Гэрээний 28.3 дах хэсэг (Хөрөнгө оруулалтын дотоод өгөөж)-т заасныг;

“Татвар” гэж Монгол Улсын Татварын ерөнхий хуулийн 7 дугаар зүйлд заасан төрлийн татвар (бүх татвар, хураамж, ногдол)-ыг;

“Түр шилжүүлэн авах” гэж энэхүү Гэрээний 37.4 дэх хэсэг (Концесс эзэмшигчийн үүргийн зөрчлийн улмаас гэрээ цуцлах)-т заасныг;

“Гэрээ цуцлах өдөр” гэж энэхүү Гэрээнд заасны дагуу Концессын хугацаа дуусгавар болох өдрөөс өмнө Гэрээ цуцалсан өдрийг;

“Гуравдагч этгээдийн нисэх буудлыг хөгжүүлэх санал” гэж энэхүү Гэрээний 20.3 дах хэсэг (Гуравдагч этгээдийн нисэх буудлыг хөгжүүлэх санал)-т заасны дагуу Нисэх буудлыг хөгжүүлэх бүсэд аливаа хөгжүүлэлт, сайжруулалт, өргөтгөл хийх талаар гуравдагч этгээдийн гаргасан саналыг;

“Шилжүүлэх Комисс” гэж Концессын зүйлийг Шилжилтийн төлөвлөгөө болон Эрх бүхий этгээд, ЗТХЯ, ИНЕГ, Концесс эзэмшигч нарын хамтран баталсан зааварчилгааны дагуу шилжүүлэх ажлыг хариуцах ажлын хэсгийг;

“Шилжүүлэг дууссан тухай гэрчилгээ” гэж Концессын зүйл тус бүрийг Шилжилтийн төлөвлөгөөний дагуу шилжүүлж дууссаныг баталгаажуулан Шилжүүлэх комиссын төлөөллүүдийн үйлдсэн гэрчилгээг;

“Шилжүүлсэн ажилтан” гэж энэхүү Гэрээний 13 дугаар зүйл (Ажилтан ба сургалт)-д заасны дагуу Иргэний нисэхийн ерөнхий газар болон ЧХОУНБ-аас шилжүүлэн, Концесс эзэмшигч хүлээн авсан ажилтан тус бүрийг;

“Шилжилтийн төлөвлөгөө” гэж Концессын зүйл болон Шилжүүлсэн ажилтнуудыг Концесс эзэмшигчид шилжүүлэх, нисэх буудлын үйл ажиллагааг ЧХОУНБ-аас УБХОУНОШБ-руу шилжүүлэх талаарх Шилжилтийн төлөвлөгөөний тоймд үндэслэн энэхүү Гэрээний 16.1.1 болон 16.2.5 дах хэсгүүдэд заасны дагуу Талуудын харилцан тохиролцож, боловсруулсан нарийвчилсан шилжилтийн төлөвлөгөөг;

“Шилжилтийн төлөвлөгөөний тойм” гэж энэхүү Гэрээний Хавсралт 1 (Шилжилтийн төлөвлөгөөний тойм)-т заасан Шилжилтийн төлөвлөгөөний тоймыг;

“Нийтлэг үйлчилгээний хангамжийн байгууламж” гэж энэхүү Гэрээний 22.1.1 дэх хэсэг (Нийтлэг үйлчилгээний хангамжийн байгууламжтай холбоотой Концесс эзэмшигчийн үүрэг)-т заасныг;


“Нийтлэг үйлчилгээний хангамжийн тасалдал” гэж энэхүү Гэрээний 22.4.1 (Нийтлэг үйлчилгээний хангамжийн тасалдал)-т заасныг;

“Засварын ажил” гэж Концессын зүйлд илэрсэн харилцан тохиролцсон доголдлыг арилгах болон Концессын зүйлд засвар үйлчилгээ, сайжруулалт, хөгжүүлэлт болон өргөтгөл хийхээр тохиролцсоны дагуу Эрх бүхий этгээд эсхүл Концесс эзэмшигчийн зүгээс хийж гүйцэтгэх (үүнд туслан гүйцэтгэгчээр гүйцэтгүүлэх ажил хамаарна) ажлуудыг тус тус ойлгоно.

1.2 ТАЙЛБАР

Энэхүү Гэрээний агуулга эсхүл шууд заалтад өөрөөр заагаагүй бол энэхүү Гэрээг дараах байдлаар тайлбарлана. Үүнд:

- 1.2.1 эр үг эм үгийн, эм үг эр үгийн утгыг агуулна;
- 1.2.2 ганц тоо олон тоог, олон тоо ганц тоог илэрхийлнэ;
- 1.2.3 аливаа зүйл, заалт, хавсралт, хэсэг, догол мөр, нэмэлт, хавсралт, өмнөтгөл зэргийг ишлэсэн нь энэхүү Гэрээний тухайн зүйл, заалт, хавсралт, хэсэг, догол мөр, нэмэлт, хавсралт, өмнөтгөлийг заана;
- 1.2.4 энэхүү Гэрээ болон бусад баримт бичг бичгийг иш татсан нь тухайн баримт бичигт оруулсан өөрчлөлт, нэмэлт өөрчлөлт, нэмэлтийг болон тухайн баримт бичиг орлуулагдсан, шинэчлэгдсэн, шилжсэнийг мөн багтаана;
- 1.2.5 тушаал, шийдвэр, журам, бусад ижил төстэй баримт бичгийг иш татсан нь тухайн баримт бичигт нэмэлт, өөрчлөлт орсон, түүнийг орлуулан баталсан, нэгтгэсэн, дахин баталсныг мөн багтаана;
- 1.2.6 “харилцан тохиролцсон хэлбэр” бүхий баримт бичиг гэж иш татсан нь тухайн баримт бичгийг таних зорилгоор Талууд өөрсдөө болон тэдний нэрийн өмнөөс гарын үсгийн эхний үсгээр тэмдэглэл хийснийг ойлгоно;
- 1.2.7 “этгээд” гэж иш татсан нь фирм, нөхөрлөл, корпораци, хувь хүн, траст, засгийн газар, засгийн газрын эрх бүхий байгууллага, төрийн эрх бүхий байгууллага, агентлагийг багтаана;
- 1.2.8 аливаа этгээд гэж иш татсан нь тухайн этгээдийн эрх залгамжлагч, эрх, үүрэг шилжүүлэн авагч, хүлээн авагчийг мөн багтаана;
- 1.2.9 энэхүү Гэрээний хавсралтууд нь Гэрээний салшгүй хэсэг болох ба Гэрээг иш татсан нь түүний Хавсралтыг мөн багтаана;
- 1.2.10 зүйл, заалтын гарчигууд нь зөвхөн хялбар болгоход зориулагдсан ба Гэрээг тайлбарлахад болон Гэрээний бүтцэд хамааралгүй болно;
- 1.2.11 “хамаарна” “зэрэг” “оролцуулан” гэсэн үгийн өмнөх үг эдгээр үгийн дараа орж буй үгсийн утгаар хязгаарлагдахгүй болно;



- 1.2.12 илэрхий өөрөөр зааснаас бусад тохиолдолд аль нэг талын хүлээсэн аливаа үйлдэл хийх аливаа зүйлийг гүйцэлдүүлэх үүрэг нь тухайн үйлдлийг хийлгэх, тухайн зүйлийг гүйцэлдүүлсэн байх үүргийг мөн багтаана.

1.3 Зөрчилдөөн үүсэх

Энэхүү Гэрээний үндсэн хэсэгт байгаа аливаа заалт нь аль нэг хавсралтад байгаа заалттай зөрчилдвөл гэрээний үндсэн хэсгийн заалтыг баримтална.

2. КОНЦЕССЫН ТӨРӨЛ

- 2.1 Энэхүү төслийг "ХӨРӨНГӨ ОРУУЛАХ – АШИГЛАХ – ШИЛЖҮҮЛЭХ" концессын төрлөөр хэрэгжүүлнэ.

- 2.2 "ХӨРӨНГӨ ОРУУЛАХ – АШИГЛАХ – ШИЛЖҮҮЛЭХ" концессын төрөл дараах ерөнхий утгыг агуулна:

2.2.1 Энэхүү төслийг хэрэгжүүлэх зорилгоор Концесс эзэмшигч нь Нисэх буудлын үйлчилгээний ноу-хау, тэргүүн туршлагыг сургалт, дадлагажуулалт, удирдлагаар дамжуулан, Салбарын сайн туршлага, олон улсын стандарт болон шинэ технологийг ашиглах, нэвтрүүлэх замаар хэрэгжүүлэх бөгөөд ингэснээр энэхүү Гэрээ дуусгавар болсны дараа дотоодын ажиллах хүч ноу-хау, тэргүүн туршлагыг үргэлжлүүлэн хэрэгжүүлэх чадвар, туршлагатай болсон байна.

2.2.2 Энэхүү төслийг хэрэгжүүлэх, Нисэх буудлын бизнес эрхлэх зорилгоор Концесс эзэмшигч нь Нисэх буудлын үйлчилгээ үзүүлэх, Нисэх буудлын бизнес эрхлэх, Концессын зүйлийг ашиглах, засвар үйлчилгээ хийх, Концессын талбайн удирдлагыг хэрэгжүүлэхэд шаардлагатай хөрөнгө оруулалтыг хийнэ. Талууд Концесс эзэмшигчийн оруулсан хөрөнгө оруулалтын талаар бүртгэл хөтөлнө.

2.2.3 Энэхүү төслийг хэрэгжүүлэх зорилгоор, Концесс эзэмшигч нь ОУАТХ-ны Үйлчилгээний түвшний Оптимум түвшнийг нэвтрүүлэх бөгөөд гурав (3) дах Концессын жилийн эцсээс эхлэн Концессын хугацааны туршид ОУАТХ-ны Үйлчилгээний түвшний Оптимум түвшнийг байнга хангаж ажиллана. Концесс эзэмшигч энэхүү Гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэхдээ Нисэх буудлын бизнес, Концессын зүйл болон Концессын талбайтай холбоотой эрсдлийг бууруулж, Нисэх буудлын бизнесийн орлого болон ашгийн хэмжээг нэмэгдүүлэхийн тулд дээд хүчин чармайлт гарган ажиллана.

- 2.2.4 Концесс эзэмшигч нь Нисэх буудлын бизнес эрхлэхдээ Улсын Их Хурлын 2016 оны 19 дүгээр тогтоолоор баталсан “Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030”, Засгийн газрын 2015 оны 324 дүгээр тогтоолоор баталсан “Аялал жуулчлалыг хөгжүүлэх үндэсний хөтөлбөр” болон хот байгуулалт, тээвэр, ложистикийн талаарх бусад холбогдох хэм хэмжээ, стандарт, бусад төрөөс баримтлах бодлого, төсөл хөтөлбөрүүдийг харгалзан үзнэ.
- 2.2.5 Энэхүү Гэрээ дуусгавар болох үед Концесс эзэмшигч нь Концессын зүйл, Концесс эзэмшигчийн хөрөнгөөр бий болсон эд хөрөнгө (үүнд оюуны өмч болон ноу-хау хамаарна), Концессын талбай болон Нисэх буудлын бизнесийг Эрх бүхий этгээд эсхүл түүний хууль ёсны төлөөлөгчид аливаа барьцаа, сөрөг шаардлага, хугацаа хэтэрсэн өргүйгээр үнэ төлбөргүй буцаан шилжүүлнэ. Мөн Концесс эзэмшигч нь буцаан шилжүүлэх ажиллагааг Талуудын хооронд аливаа маргаан, зөрүүтэй байр суурь бий болсон нөхцөлд ч Нисэх буудлын бизнест аливаа тасалдал, саад учруулахгүйгээр, аль болох богино хугацаанд өртөг багатай байдлаар хэрэгжүүлэх асуудлыг хангана.

3. КОНЦЕССЫН ЗҮЙЛ

- 3.1 Эрх бүхий этгээд нь Концесс эзэмшигчийн зүгээс Нисэх буудлын бизнес эрхлэх болон Нисэх буудлын үйлчилгээ үзүүлэхэд шаардлагатай Концессын зүйлийг энэхүү Гэрээний хугацааны туршид ашиглах эрхийг өөрөө олгох эсхүл ЗТХЯ, ИНЕГ-аас уг эрхийг Концесс эзэмшигчид олгуулах асуудлыг хариуцна.
- 3.2 Агаарын навигацийн үйлчилгээ болон түүнтэй холбоотой үйлчилгээний барилга байгууламж болон энэхүү Гэрээний Хавсралт 4 (Удирдлага, зохион байгуулалтын нарийвчилсан хуваарь)-т “Концессын бус зүйл” гэж цэнхэр өнгөөр тэмдэглэсэн бусад зүйлс Концессын зүйлд хамаарахгүй (“**Концессын бус зүйл**”) бөгөөд Концесс эзэмшигч тэдгээрийг ашиглах, тэдгээрт үйл ажиллагаа явуулах эрхгүй.
- 3.3 Эрх бүхий этгээд нь дор дурдсан баримт бичгийг оролцуулан Концесс эзэмшигчийн зүгээс Нисэх буудлын үйлчилгээ үзүүлэх, Нисэх буудлын бизнес эрхлэхэд шаардлагатай байж болох Концессын зүйл болон ЧХОУНБ-тай холбоотой бүх зураг төслийн загвар зураг, техникийн бичиг баримт, холбогдох бусад баримт бичиг, бүртгэлүүдийг Концесс эзэмшигчид гаргаж өгөх асуудлыг хариуцна. Үүнд:
- 3.3.1 Гэрээний 21.2 дах хэсэг (Баригдсан байдлын зураг төсөл, заавар)-т заасны дагуу Барилгын ажил гүйцэтгэгчээс гарган өгөх

баригдсан байдлын зураг төсөл болон үйл ажиллагаа, засвар үйлчилгээний талаарх гарын авлага; болон

3.3.2 Гэрээний 24.2 дах хэсэг (Бүртгэл)-т заасан ЧХОУНБ-тай холбоотой Эрх бүхий этгээдийн бүртгэл/тэмдэглэлүүд.

4. КОНЦЕССЫН ТАЛБАЙ БОЛОН НИСЭХ БУУДЛЫГ ХӨГЖҮҮЛЭХ БҮС

4.1 Энэхүү Гэрээний 8.2 дах хэсэг (Урьдчилсан нөхцөл), 16.3 дах хэсэг (Концесс эзэмшигчийн урьдчилсан нөхцөл), 16.4 дэх хэсэг (Эрх бүхий этгээдийн урьдчилсан нөхцөл)-т тус тус заасан урьдчилсан нөхцөл болох Концессын талбайг ашиглах эрхийг Концесс эзэмшигчид холбогдох газрын тухай хууль тогтоомж, дүрэм журамд нийцүүлэн Концесс эзэмшигч болон холбогдох Төрийн эрх бүхий байгууллагын хооронд Үйл ажиллагаа эхлэх өдрөөс өмнө байгуулагдах Гэрээгээр газар ашиглуулах эрхийн тухай гэрээний үндсэн дээр олгоно.

4.2 Концессын талбай нь Концессын зүйлийн бүрэлдэхүүн хэсэгт тооцогдохгүй ба Концесс эзэмшигчид Концессын талбайг ашиглах эрхийг холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн Гэрээгээр газар ашиглуулах эрхийн тухай гэрээний дагуу олгохыг Талууд зөвшилцөж, хүлээн зөвшөөрсөн болно.

4.3 Энэхүү Гэрээ дуусгавар болсон эсхүл цуцлагдсан тохиолдолд Концесс эзэмшигчийн хөрөнгөөр бий болсон эд хөрөнгийн бүрдэл хэсэг болох аливаа барилга, үл хөдлөх хөрөнгийг энэхүү Гэрээний 41 дүгээр зүйл (Гэрээ дуусгавар болох эсхүл Гэрээ цуцлах үед Концессын зүйл болон Концесс эзэмшигчийн хөрөнгөөр бий болсон хөрөнгийг буцаан шилжүүлэх)-д заасны дагуу Эрх бүхий этгээд эсхүл түүний нэр заасан этгээдэд Концессын зүйлийн хамт буцаан шилжүүлнэ.

4.4 Эрх бүхий этгээд нь Гуравдагч этгээдийн нисэх буудлыг хөгжүүлэх саналтай холбоотой энэхүү Гэрээний 20.3 дах хэсэг (Гуравдагч этгээдийн нисэх буудлыг хөгжүүлэх санал)-т заасан процедурын журам хангагдсанаас бусад тохиолдолд гуравдагч этгээдэд Нисэх буудлыг хөгжүүлэх бүсийг ашиглах, тухайн бүсэд өөр бусад байдлаар үйл ажиллагаа явуулах эрхийг өөрөө олгохгүй бөгөөд мөн аль ч Төрийн эрх бүхий байгууллагаас ийм эрх олгохгүй байх баталгааг хангана.

4.5 Эрх бүхий этгээд Нисэх буудлыг хөгжүүлэх бүсэд УБХОУНОШБ-ын аюулгүй ажиллагаанд сөргөөр нөлөөлж болох аливаа үйл ажиллагаа явуулахгүй ба аливаа Төрийн эрх бүхий байгууллага мөн ийм үйл ажиллагаа явуулахгүй байх баталгааг хангана.

4.6 Концесс эзэмшигч нь аливаа гуравдагч этгээд Концессын талбайд нэвтрэх, Нисэх буудлын үйлчилгээнд хөндлөнгөөс оролцох болон өөр

бусад байдлаар Концессын талбайд саад хийх, аюул учруулах аливаа үйл ажиллагаанаас урьдчилан сэргийлэхэд шаардлагатай арга хэмжээг авах зэргээр Концессын талбайн өдөр тутмын хамгаалалт, аюулгүй байдлыг хариуцна.

4.7 Эрх бүхий этгээд нь аливаа гуравдагч этгээд Нисэх буудлыг хөгжүүлэх бүсэд нэвтрэх, өөр бусад байдлаар Нисэх буудлыг хөгжүүлэх бүсэд хөндлөнгөөс саад хийх, аюул учруулах аливаа үйл ажиллагаанаас урьдчилан сэргийлэхэд шаардлагатай арга хэмжээг авах зэргээр Нисэх буудлыг хөгжүүлэх бүсийн өдөр тутмын хамгаалалт, аюулгүй байдлыг хангах эсхүл уг асуудлыг ИНЕГ-аас хангах асуудлыг хариуцна.

4.8 Хэрэв Концесс эзэмшигч аливаа гуравдагч этгээд Нисэх буудлыг хөгжүүлэх бүсэд байнгын давтагдах шинжтэй байдлаар саад хийсэн болон аюул учруулсан талаар мэдсэн бол энэ талаар Эрх бүхий этгээд болон ИНЕГ-т нэн даруй мэдэгдэнэ.

5. КОНЦЕСС ЭЗЭМШИГЧИЙН УДИРДЛАГА БОЛОН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ТАВИГДАХ ШААРДЛАГА

5.1 Концесс эзэмшигч нь энэхүү Гэрээгээр хүлээсэн эрх, үүргээ хэрэгжүүлэхдээ Нисэх буудлын бизнесийн орлого, ашгийн хэмжээг нэмэгдүүлэх болон Монгол Улсын үндэсний брэндийг сурталчлахын төлөө дээд хүчин чармайлт гарган ажиллана.

5.2 Концесс эзэмшигч нь Нисэх буудлын үйлчилгээ үзүүлэхдээ дор дурдсан үүрэг хүлээнэ. Үүнд:

5.2.1 Аэродромын үйл ажиллагааны зааврыг дагаж мөрдөх;

5.2.2 холбогдох хууль тогтоомжийг дагаж мөрдөх;

5.2.3 Салбарын сайн туршлагыг дагаж мөрдөх;

5.2.4 олон улсын стандартыг дагаж мөрдөх;

5.2.5 ОУАТХ-ны Үйлчилгээний түвшний Оптимум түвшнийг нэвтрүүлэх бөгөөд гурав (3) дах Концессын жилийн эцсээс Концессын хугацааны туршид ОУАТХ-ны Үйлчилгээний түвшний Оптимум түвшнийг байнга хангаж ажиллах;

5.2.6 Гүйцэтгэх удирдлагын багийн гишүүнээр дор хаяж дараах шаардлагыг хангасан этгээдийг томилох. Үүнд:

(1) удирдлагын түвшинтэй дүйх туршлага, удирдах ур чадвартай;

(2) англи хэлний бичгийн болон ярианы чадвартай;

- (3) нисэх буудал, нисэх хүчин болон/эсхүл санхүүгийн салбартай холбоотой бизнест хамгийн багадаа таван (5) жил ажилласан туршлагатай;
- (4) Салбарын сайн туршлагын талаар мэдлэгтэй;
- (5) Монгол Улсад нисэх буудлын бизнесийг хөгжүүлэхэд хувь нэмэр оруулах өндөр хүсэл тэмүүлэлтэй байх.

5.2.7 Нисэх буудлын үйлчилгээний ноу-хау, шилдэг туршлагыг сургалт, дадлагажуулалт, удирдлагаар дамжуулан, Салбарын сайн туршлага, олон улсын стандарт болон шинэ технологийг ашиглах, нэвтрүүлэх замаар хэрэгжүүлэх бөгөөд ингэснээр энэхүү Гэрээ дуусгавар болсны дараа дотоодын ажиллах хүч ноу-хау, тэргүүн туршлагыг үргэлжлүүлэн хэрэгжүүлэх чадвар, туршлагатай болсон байх.

6. КОНЦЕССЫН ХУГАЦАА

6.1 Энэхүү Гэрээ нь Үйл ажиллагаа эхлэх өдрөөс хойш арван таван (15) жилийн хугацаанд (энэхүү Гэрээний 6.2 дах хэсэг (Концессын хугацаа) эсхүл 45.6 дах хэсэг (Давагдашгүй хүчин зүйл)-т заасны дагуу хугацаа сунгагдсан бол уг хугацаа нэмэгдэнэ) хүчин төгөлдөр үйлчилнэ ("Концессын хугацаа").

6.2 Энэхүү 6.1 дэх хэсэг (Концессын хугацаа)-т заасан Концессын хугацааг дараах байдлаар сунгаж болно. Үүнд:

6.2.1 Эрх бүхий этгээд, Концесс эзэмшигч нар харилцан тохиролцсоны дагуу арван (10) жилээс хэтрэхгүй хугацаагаар сунгаж болох ба ийнхүү сунгахдаа Эрх бүхий этгээд, Концесс эзэмшигч нарын харилцан тохиролцсон нөхцөлд үндэслэнэ;

6.2.2 Энэхүү Гэрээний 28.4 дэх хэсэг (Хөрөнгө оруулалтын дотоод өгөөж)-ийг харгалзан, Арван дөрөв (14) дэх Концессын жилийн эцэст энэхүү Гэрээний 28.2 дах хэсэг (Хөрөнгө оруулалтын дотоод өгөөж)-т заасны дагуу тооцоолсон Концесс эзэмшигчийн Төсөөлсөн ХОДӨ нь Зорилтот ХОДӨ-өөс бага байх тохиолдолд Концессын хугацаа дуусгавар болох өдрөөс найман (8) сараас доошгүй хугацааны өмнө бичгээр мэдэгдэл хүргүүлж, Талууд харилцан тохиролцсоны үндсэн дээр Концессын хугацааг арван (10) жил хүртэл хугацаагаар нэг удаа сунгах ба ийнхүү сунгасан хугацаанд энэхүү Гэрээнд заасан нөхцөлүүд хэвээр хадгалагдана.

7. ГЭРЭЭ ХҮЧИН ТӨГӨЛДӨР БОЛОХ

- 7.1 Энэхүү Гэрээний 1 дүгээр зүйл (Нэр томьёоны тодорхойлолт ба тайлбар), 5.2.2, 5.2.6 дах хэсгүүд (Концесс эзэмшигчийн удирдлага болон үйл ажиллагаанд тавигдах шаардлага), 6 дугаар зүйл (Концессын хугацаа), 7 дугаар зүйл (Гэрээ хүчин төгөлдөр болох), 12 дугаар зүйл (Оюуны өмч), 43 дугаар зүйл (Баталгаа, мэдэгдэл), 48 дугаар зүйл (Маргаан шийдвэрлэх), 50 дугаар зүйл (Баримтлах хууль), 51 дүгээр зүйл (Нууцлал), 52 дугаар зүйл (Гэрээний нэмэлт, өөрчлөлт болон татгалзал хүчин төгөлдөр болох), 53 дугаар зүйл (Гэрээний цогц байдал), 54 дүгээр зүйл (Гэрээний хувь), 55 дугаар зүйл (Гуравдагч тал эрх эдлэхгүй), 56 дугаар зүйл (Харилцах хаяг), 57 дугаар зүйл (Гэрээний хэл) Талууд гэрээнд гарын үсэг зурсан даруй хүчин төгөлдөр болох ба энэ үеэс Талуудын хувьд заавал биелэгдэх хүчин чадалтайд тооцогдоно.
- 7.2 Дээр дурдсанаас бусад Энэхүү Гэрээний зүйл, заалт нь дор дурдсан нөхцөлүүдийг Талуудын үндэслэл бүхий шаардлагад нийцүүлэн биелүүлсэн эсхүл Талууд тэдгээрийн биелэлтийг шаардах эрхээсээ харилцан татгалзсан өдөр хүчин төгөлдөр болох ба энэ үеэс Талуудын хувьд заавал биелэгдэх хүчин чадалтайд тооцогдоно (**“Гэрээ хүчин төгөлдөр болох өдөр”**). Талууд Гэрээ байгуулсан өдрөөс хойш нэг (1) сарын дотор дараах нөхцөлүүдийг биелүүлэхийн төлөө дээд хүчин чармайлт гаргаж ажиллана. Үүнд:
- 7.2.1 Засгийн газрын хувьцаа эзэмшигч болон Консорциум ТЗК нарын гарын үсэг зурсан “Хувьцаа эзэмшигчдийн гэрээ” болон Концесс эзэмшигчийн улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбарыг тус тус хүргүүлсэн;
- 7.2.2 Хувьцаа эзэмшигчдийн гэрээнд заасан нөхцлийн дагуу Засгийн газрын хувьцаа эзэмшигч болон Консорциум SPV нар Элэлтийн хөрөнгө оруулалтын эхний хэсэг болох хорин долоон сая (27,000,000) ам.доллартай тэнцэх хөрөнгө оруулалтыг хийсэн;
- 7.2.3 Нисэх буудлын үйл ажиллагааг эхлүүлэх бэлтгэл үе шатны үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх зорилгоор ЧХОУНБ болон ИНЕГ-аас Концесс эзэмшигчид тодорхой тооны ажилтан шилжүүлэх ажлын хүрээнд Концесс эзэмшигч болон ИНЕГ-ийн хооронд үйлчилгээ үзүүлэх гэрээ байгуулагдсан; болон
- 7.2.4 холбогдох Төрийн эрх бүхий байгууллагууд болон Агаарын тээвэрлэгчдийг шилжүүлэх тухай ЗТХЯ-аас баталсан нарийвчилсан шилжүүлэх төлөвлөгөөг Эрх бүхий этгээдээс Концесс эзэмшигчид хүргүүлсэн байх.

8. УРЬДЧИЛСАН НӨХЦӨЛҮҮД

8.1 Нисэх буудлын үйл ажиллагааг эхлүүлэх бэлтгэл үе шатан дах үүрэг

Гэрээ хүчин төгөлдөр болох өдрөөс эхлэн, Концесс эзэмшигч нь энэхүү Гэрээний 16.1 дэх хэсэг (Нисэх буудлын үйл ажиллагааг эхлүүлэх бэлтгэл үе шатан дах Концесс эзэмшигчийн үүрэг)-т заасан үүргийг, Эрх бүхий этгээд нь энэхүү Гэрээний 16.2 дах хэсэг (Нисэх буудлын үйл ажиллагааг эхлүүлэх бэлтгэл үе шатан дах Эрх бүхий этгээдийн үүрэг)-т заасан тус тусын үүргийг болон Шилжилтийн төлөвлөгөөнд заасан нөхцөл, хөтөлбөрийг гүйцэтгэн хэрэгжүүлнэ.

8.2 Урьдчилсан нөхцөл

8.2.1 Концесс эзэмшигч нь Концесс эзэмшигчийн урьдчилсан нөхцөлийг, Эрх бүхий этгээд нь Эрх бүхий этгээдийн урьдчилсан нөхцөлийг энэхүү Гэрээний 16 дугаар зүйл (Нисэх буудлын үйл ажиллагааг эхлүүлэх бэлтгэл үе шат ба Урьдчилсан нөхцөл) болон Шилжилтийн төлөвлөгөөнд заасны дагуу тус тус биелүүлнэ.

8.2.2 Талууд Концесс эзэмшигчийн урьдчилсан нөхцөл болон Эрх бүхий этгээдийн урьдчилсан нөхцөлийг тус тус нөгөө талын шаардлагад нийцэхүйц байдлаар биелүүлсэн эсхүл тэдгээрийн биелэлтийг шаардах эрхээсээ татгалзсан өдөр Урьдчилсан нөхцөл хангагдсанд тооцно. Талууд бичгээр харилцан тохиролцож баталгаажуулснаас бусад тохиолдолд аливаа урьдчилсан нөхцөлийн биелэлтээс татгалзсан үйлдлийг хүчингүй гэж үзнэ.

8.2.3 Талууд Үйл ажиллагаа эхлэх төлөвлөгөөт өдрөөс нэг (1)-ээс доошгүй өдрийн өмнө Урьдчилсан нөхцөлүүд хангагдах явдлыг баталгаажуулахын тулд бүхий л үндэслэл бүхий арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.

8.2.4 Талууд нөгөө талын Урьдчилсан нөхцөл биелснийг хүлээн зөвшөөрөхөөс үндэслэлгүйгээр татгалзах, түүнийг хойшлуулах эрхгүй байна.

8.3 Үйл ажиллагаа эхлэх өдөр

“Үйл ажиллагаа эхлэх өдөр” нь энэхүү Гэрээний 8.2 дах хэсэг (Урьдчилсан нөхцөл)-т заасны дагуу Урьдчилсан нөхцөлүүд хангагдсан өдрийн дараагийн өдөр байна.

ХОЁРДУГААР БҮЛЭГ. ТАЛУУДЫН ЭРХ, ҮҮРЭГ

9. ЭРХ БҮХИЙ ЭТГЭЭДИЙН ЭРХ, ҮҮРЭГ

9.1 Эрх бүхий этгээдийн чиг үүрэг

Эрх бүхий этгээд болон/эсхүл холбогдох Төрийн эрх бүхий байгууллага нь дор дурдсан чиг үүргийг өөрөө хэрэгжүүлэх эсхүл холбогдох Төрийн эрх бүхий байгууллагаар гүйцэтгүүлэх ажлыг хариуцна (**“Эрх бүхий этгээдийн чиг үүрэг”**). Үүнд:

- 9.1.1 Эрх бүхий этгээд үйл ажиллагааг нь эрхлэх зүйлийн үйл ажиллагаа;
- 9.1.2 Эрх бүхий этгээд засвар үйлчилгээг нь хариуцах зүйлийн засвар, үйлчилгээ;
- 9.1.3 Нисэх буудлыг хөгжүүлэх бүсийн удирдлага;
- 9.1.4 Нисэх буудлын бизнес эрхлэх, Нисэх буудлын үйлчилгээ үзүүлэхэд ихээхэн хэмжээгээр нөлөө үзүүлэх Засгийн газар болон ЗТХЯ-ны баримтлах бодлогод орсон өөрчлөлтийн талаар Концесс эзэмшигчид нэн даруй мэдэгдэх;
- 9.1.5 Гадаад улсын иргэний нисэхийн албан тушаалтнууд болон олон улсын иргэний нисэхийн байгууллагууд (үүнд ОУАТХ болон ОУИНБ хамаарна)-тай харилцах, хэлэлцээ хийх;
- 9.1.6 Нисэх буудлыг хөгжүүлэх бүсийн аюулгүй ажиллагааг хангах зорилгоор холбогдох Төрийн эрх бүхий байгууллагууд болон гуравдагч этгээдүүд ОУИНБ-ын холбогдох стандартуудыг мөрдөх явдлыг хангахад шаардлагатай бүх хүчин чармайлтыг гаргах.

9.2 Төрийн эрх бүхий байгууллагууд болон Нийтлэг үйлчилгээгээр хангагч гуравдагч этгээдтэй хамтран ажиллах, шаардлагатай зөвшөөрөл авах

- 9.2.1 Эрх бүхий этгээд нь энэхүү Гэрээг Эрх бүхий этгээд болон Төрийн эрх бүхий байгууллагын зүгээс холбогдох Хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлэхтэй холбоотойгоор Концесс эзэмшигчийн авах зөвшөөрлүүдээс бусад бүх шаардлагатай зөвшөөрлүүдийг авах, түүнийг хүчин төгөлдөр хэвээр хадгалах эсхүл холбогдох Төрийн эрх бүхий байгууллага уг зөвшөөрлүүдийг авах, хүчин төгөлдөр хэвээр хадгалах явдлыг хариуцна.

9.2.2 Эрх бүхий этгээд нь Концесс эзэмшигчид Төрийн эрх бүхий байгууллагууд болон нийтлэг үйлчилгээгээр хангагч гуравдагч этгээдтэй харилцахад бүх талаар дэмжлэг үзүүлнэ.

9.2.3 Эрх бүхий этгээд нь:

- (1) Концесс эзэмшигчийн зүгээс аливаа Концесс эзэмшигчийн зөвшөөрөл авах, хэвээр хадгалах, зөвшөөрлийг шинэчлэхэд тухайн асуудал хариуцсан Төрийн эрх бүхий байгууллагатай холбож өгөх, харилцах зэргээр Концесс эзэмшигчид туслалцаа үзүүлнэ;
- (2) Концесс эзэмшигчийн авах зөвшөөрлүүдийг Эрх бүхий этгээд олгох, сунгах, шинэчлэх тохиолдолд уг асуудлыг үндэслэлгүйгээр хойшлуулж, татгалзахгүй;
- (3) Концесс эзэмшигч Хууль тогтоомжид заасан бүх шаардлагыг хангасан тохиолдолд ИНЕГ (эсхүл холбогдох Төрийн эрх бүхий байгууллага)-аас олгох, сунгах, шинэчлэх Концесс эзэмшигчийн авах зөвшөөрлүүдийг тус газар (эсхүл холбогдох Төрийн эрх бүхий байгууллага)-аас олгох, сунгах, шинэчлэх явдлыг хангана.

9.2.4 Эрх бүхий этгээд бүх Төрийн эрх бүхий байгууллагуудтай Хууль тогтоомжийн хүрээнд хамтран ажиллаж, Концесс эзэмшигчээс гаргасан хүсэлт, лавлагааг шийдвэрлэхэд бүх талын туслалцаа үзүүлнэ.

9.2.5 Эрх бүхий этгээд нь энэхүү Гэрээний 9.2 дах хэсэг (Төрийн эрх бүхий байгууллагууд болон Нийтлэг үйлчилгээгээр хангагч гуравдагч этгээдтэй хамтран ажиллах, шаардлагатай зөвшөөрөл авах)-т заасан үүргээ биелүүлсэн боловч Концесс эзэмшигчийн авах зөвшөөрлүүдийг Концесс эзэмшигч авч чадаагүйгээс үүсэх эрсдлийг Эрх бүхий этгээд хариуцахгүй.

9.3 Хяналт ба үнэлгээ

Эрх бүхий этгээд нь энэхүү Гэрээний хэрэгжилтэд хяналт тавьж, үнэлгээ хийх эрхтэй. Эрх бүхий этгээд нь дээрх эрхээ хэрэгжүүлэхийн тулд ИНЕГ зэрэг холбогдох Төрийн эрх бүхий байгууллага эсхүл зөвлөх үйлчилгээ үзүүлдэг хувь хүн, хуулийн этгээдийг томилох, тэдгээрт өөрийн эрх, үүргээ шилжүүлж болох бөгөөд энэ талаар Концесс эзэмшигчид бичгээр мэдэгдэнэ.

9.4 Үл тасалдалт

- 9.4.1 Онцгой нөхцөл байдал үүссэн (энэ тохиолдолд Гэрээний 44 дүгээр зүйл (Онцгой нөхцөл байдал)-ийг баримтална) эсхүл холбогдох Хууль, тогтоомжид өөрөөр зааснаас бусад тохиолдолд Эрх бүхий этгээд, эсхүл аливаа Төрийн эрх бүхий байгууллага нь Нисэх буудлын үйлчилгээ, Нисэх буудлын бизнест хөндлөнгөөс оролцохгүй, түүнд ноцтой сөрөг нөлөө үзүүлэхүйц аливаа үйл ажиллагаа явуулахгүй байх явдлыг Эрх бүхий этгээд хариуцна.
- 9.4.2 Концесс эзэмшигчээс шалтгаалснаас бусад тохиолдолд Концессын талбайд Нисэх буудлын бизнес эрхлэхтэй холбоотой ажил хаялт, олон нийтийг хамарсан арга хэмжээ, эсэргүүцлийн шинжтэй аливаа үйл ажиллагаа гарахаас урьдчилан сэргийлэхэд холбогдох Төрийн эрх бүхий байгууллагаас дээд зэргийн хүчин чармайлт гарган ажиллах явдлыг Эрх бүхий этгээд хариуцна.

9.5 Маркетинг

Эрх бүхий этгээд эсхүл ИНЕГ зэрэг холбогдох Төрийн эрх бүхий байгууллагын зүгээс Концесс эзэмшигчид Нисэх буудлын бизнесийг Агаарын тээвэрлэгчид болон бусад Нисэх буудлын хэрэглэгчдэд сурталчлах, танилцуулахад дэмжлэг үзүүлнэ.

9.6 Өрсөлдөх нисэх буудал болон арилжааны боломжуудыг хязгаарлах

- 9.6.1 Эрх бүхий этгээд эсхүл Төрийн эрх бүхий байгууллагын зүгээс Концессын хугацаанд Концесс эзэмшигчээс бусад этгээдэд УБХОУНОШБ-тай холбоотой аливаа Нисэх буудлын төлбөр, хураамж ногдуулах, хураан авах эрх олгохгүй байх явдлыг Эрх бүхий этгээд хариуцна.
- 9.6.2 Эрх бүхий этгээд эсхүл Төрийн эрх бүхий байгууллагын зүгээс Концессын хугацаанд Концесс эзэмшигчээс бусад этгээдэд Концессын зүйлтэй холбоотой арилжааны боломжуудыг ашиглах эрх олгохгүй байх явдлыг Эрх бүхий этгээд хариуцна.
- 9.6.3 Энэхүү Гэрээний 9.1 дэх хэсэг (Эрх бүхий этгээдийн чиг үүрэг)-т заасан Эрх бүхий этгээдийн чиг үүрэг болон/эсхүл Төрийн эрх бүхий байгууллагын хүлээсэн үүргийг хэрэгжүүлэхтэй холбоотойгоор аливаа Төрийн эрх бүхий байгууллагад эрх олгохоос бусад тохиолдолд Эрх бүхий этгээд эсхүл Төрийн эрх бүхий байгууллагаас Концессын хугацаанд Концессын талбай

болон Концессын зүйлийг ашиглах эрхийг аливаа этгээдэд олгохгүй байх явдлыг Эрх бүхий этгээд хариуцна.

9.6.4 Концессын хугацаанд УБХОУНОШБ-аас нэг зуун тавин (150) километрийн дотор байрлах аливаа нисэх буудлаас эсхүл нисэх буудал руу хуваарьт/хуваарьт бус Арилжааны нислэг үйлдэх зөвшөөрлийг Эрх бүхий этгээд эсхүл Төрийн эрх бүхий байгууллагаас аливаа бусад этгээдэд олгохгүй байх явдлыг Эрх бүхий этгээд хариуцна.

9.7 Саадын хязгаарлалтын техникийн шаардлагыг хангах

9.7.1 Эрх бүхий этгээд болон Төрийн эрх бүхий байгууллага нь Концессын хугацааны туршид ОУИНБ-аас гаргасан Аэродромын заавар зөвлөмж болон стандарт (Олон улсын Иргэний нисэхийн тухай конвенцийн 1 дүгээр боть, 4 дүгээр бүлэг, 14 дүгээр хавсралт)-д заасан саадын хязгаарлалтын техникийн шаардлагыг зөрчих эсхүл бусад байдлаар УБХОУНОШБ-ын аюулгүй ажиллагаанд сөргөөр нөлөөлөхүйц аливаа барилга, байгууламж, бусад цогцолборыг Нисэх буудлын ойр орчимд барьж байгуулах зөвшөөрөл олгохгүй байх явдлыг Эрх бүхий этгээд хариуцна.

9.7.2 Эрх бүхий этгээд нь энэхүү 9.7 дах хэсэг (Саадын хязгаарын техникийн шаардлагыг хангах)-ийг дагаж мөрдөхтэй холбоотойгоор холбогдох бүх Төрийн эрх бүхий байгууллага болон гуравдагч этгээдтэй харилцаж ажиллана.

9.8 Хүрээлэн буй орчин, эрүүл мэнд, аюулгүй ажиллагаа болон аюулгүй байдлын тухай хууль тогтоомжийг биелүүлэх

Эрх бүхий этгээд нь энэхүү Гэрээнд заасан Эрх бүхий этгээдийн чиг үүргээ хэрэгжүүлэх болон Гэрээгээр хүлээсэн бусад эрх, үүргээ гүйцэтгэхдээ хүрээлэн буй орчин, эрүүл мэнд, эрүүл ахуй, галын аюулгүй байдал, ажлын байрны эрүүл ахуй ба аюулгүй ажиллагаа, нисэхийн аюулгүй ажиллагаа болон аюулгүй байдалтай холбоотой бүхий л Хууль тогтоомж, дүрэм журам, стандартыг дагаж мөрдөх ба мөн эдгээр шаардлагуудыг Төрийн эрх бүхий байгууллага бүрээс дагаж мөрдөх явдлыг хариуцна.

10. ТӨРИЙН ЭРХ БҮХИЙ БАЙГУУЛЛАГА

10.1 ИНЕГ нь Концессын зүйл болон Монгол Улсын иргэний нисэхийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага болохын хувьд Хууль тогтоомжоор түүнд олгогдсон бүх эрх хэмжээ, эрх, үүргээ хэрэгжүүлэх явдлыг Эрх бүхий этгээд хариуцна.

10.2 Холбогдох Төрийн эрх бүхий байгууллага нь Концесс эзэмшигчээс холбогдох Хууль тогтоомжийн дагуу ирүүлсэн Зохицуулалттай төлбөр, хураамжийн саналыг хянаж, батлахтай холбоотой Хууль тогтоомжоор түүнд олгосон бүх эрх хэмжээ, эрх, үүргээ хэрэгжүүлэх явдлыг Эрх бүхий этгээд хариуцна.

10.3 ЗТХЯ, ИНЕГ, ЧХОУНБ зэрэг холбогдох Төрийн эрх бүхий байгууллагууд Үйл ажиллагаа эхлэх төлөвлөгөөт өдрөөс өмнө Шилжилтийн төлөвлөгөөний дагуу өөрсдийн хийж гүйцэтгэх шаардлагатай бүх арга хэмжээг авч хэрэгжүүлэх явдлыг Эрх бүхий этгээд хариуцна.

10.4 ЗТХЯ, ИНЕГ, ЧХОУНБ зэрэг холбогдох Төрийн эрх бүхий байгууллагууд энэхүү Гэрээний 10.3 дах хэсэг (Төрийн эрх бүхий байгууллага)-т заасны дагуу Шилжилтийн төлөвлөгөөг хэрэгжүүлэхтэй холбоотой өөрт учирсан зардлыг тус бүр хариуцах явдлыг Эрх бүхий этгээд хариуцна.

10.5 Эрх бүхий этгээд болон/эсхүл холбогдох Төрийн эрх бүхий байгууллагууд нь энэхүү Гэрээг хэрэгжүүлэхтэй холбоотой өөрсдөөс хамаарах аливаа асуудлыг Хууль тогтоомжид заасны дагуу шийдвэрлэх үүрэгтэй.

10.6 ИНЕГ болон холбогдох Төрийн эрх бүхий байгууллага Концесс эзэмшигчийн авах зөвшөөрлүүд болон/эсхүл Төрийн эрх бүхий байгууллагын авах зөвшөөрлүүдийг олгохдоо үндэслэлгүйгээр хойшлуулж, татгалзахгүй байх явдлыг Эрх бүхий этгээд хариуцна.

10.7 Нисэх буудлын талбайн дуу чимээтэй холбоотой аливаа гуравдагч этгээдийн гаргасан бүхий л гомдол болон бусад асуудлыг холбогдох Төрийн эрх бүхий байгууллага хариуцан шийдвэрлэх явдлыг Эрх бүхий этгээд хариуцна.

10.8 Концессын талбай

10.8.1 Холбогдох Төрийн эрх бүхий байгууллага (үүнд ЗТХЯ, ИНЕГ хамаарна)-ын зүгээс дараах шаардлагыг биелүүлэх явдлыг Эрх бүхий этгээд хариуцна. Үүнд:

- (1) Концессын талбай болон/эсхүл Концессын зүйлийг зөвхөн Эрх бүхий этгээдийн зүгээс энэхүү Гэрээний 9.1 дэх хэсэг (Эрх бүхий этгээдийн чиг үүрэг)-т заасан Эрх бүхий этгээдийн чиг үүргээ хэрэгжүүлэхэд шаардагдах хэмжээгээр эзэмшиж, ашиглах;
- (2) Концесс эзэмшигчийн зөвшөөрөлгүйгээр Концессын талбайг эзэмших, ашиглах эрхийг аливаа бусад Төрийн эрх бүхий байгууллага эсхүл гуравдагч этгээдэд олгохгүй байх;

- (3) Концесс эзэмшигчийн Нисэх буудлын бизнес эрхлэх болон Нисэх буудлын үйлчилгээ явуулах эрхэд аливаа бусад Төрийн эрх бүхий байгууллага, гуравдагч этгээдийн зүгээс саад учруулах, тасалдуулах явдлаас урьдчилан сэргийлэх бүх талын боломжит арга хэмжээг авах.

10.8.2 Эрх бүхий этгээд нь энэхүү Гэрээний 10.8.1 дэх хэсэг (Концессын талбай)-ийг зөрчсөний улмаас эсхүл түүний үр дагавраас үүсэх бүх Хохирлыг бүрэн хариуцаж, Концесс эзэмшигчийг түүнтэй холбоотой аливаа хариуцлагаас ангид байлгаж, хохирлыг нөхөн төлнө.

10.9 Аюулгүй ажиллагаа болон аюулгүй байдалтай холбоотойгоор Хууль тогтоомжоор шаардсанаас бусад тохиолдолд холбогдох Төрийн эрх бүхий байгууллагын зүгээс УБХОУНОШБ-ыг хаах эсхүл УБХОУНОШБ-ын ашиглалтад хязгаарлалт тавих (үүнд Нисэх буудлын талбайд санамсаргүй бий болсон эвдрэл, хохирлын үр дагаврын улмаас эдгээрийг хэрэгжүүлэх явдал хамаарна) асуудал үүсгэхгүй байх явдлыг Эрх бүхий этгээд хариуцна.

10.10 Концессын хугацаанд нийтлэг үйлчилгээгээр тогтвортой хангах талаар холбогдох Төрийн эрх бүхий байгууллагын зүгээс дээд зэргийн хүчин чармайлт гаргах явдлыг Эрх бүхий этгээд хариуцна. Нийтлэг үйлчилгээгээр хангаагүй буюу хангамж тасалдсан тохиолдолд (тухайн саатал, тасалдал нь Концесс эзэмшигчийн үүргийн зөрчлөөс шалтгаалаагүй бол) Төрийн эрх бүхий байгууллага уг хангамжийг буцаан сэргээхийн тулд дээд зэргийн хүчин чармайлт гаргах ба энэ тохиолдолд энэхүү Гэрээний 22.4 дэх хэсэг (Нийтлэг үйлчилгээний хангамжийн тасалдал)-ийн заалтууд үйлчилнэ.

11. КОНЦЕСС ЭЗЭМШИГЧИЙН ЭРХ, ҮҮРЭГ

11.1 Концесс

11.1.1 Концесс эзэмшигч дор дурдсан чиг үүрэг (“Концесс эзэмшигчийн чиг үүрэг”)-ийг хариуцаж хэрэгжүүлнэ. Үүнд:

- (1) Нисэх буудлын бизнес эрхлэн явуулах;
- (2) Нисэх буудлын үйлчилгээ (үүнд Концессын зүйлийн үйл ажиллагаа болон/эсхүл засвар үйлчилгээ хамаарна) үзүүлэх;
- (3) Концессын талбайн удирдлага;

(4) энэхүү Гэрээний 25.2 дах хэсэг (Санхүүгийн төлөвлөгөө)-т заасан Санхүүгийн төлөвлөгөө болон 24.2 дах хэсэг (Тайлан)-т заасан тайлангуудыг хүргүүлэх.

11.1.2 Концесс эзэмшигч нь Концессын хугацааны туршид Нисэх буудлын бизнесийн үйл ажиллагааг эрхлэн явуулах онцгой эрхтэй байна.

11.1.3 Концесс эзэмшигч нь Нисэх буудлын бизнесийн үйл ажиллагааг эрхлэн явуулах явцад бий болгосон эсхүл олж авсан Концесс эзэмшигчийн хөрөнгөөр бий болсон эд хөрөнгийг өмчлөх ба Эрх бүхий этгээдтэй өөрөөр тохиролцсоноос бусад тохиолдолд Концессын хугацааны сүүлийн нэг (1) жилийн хугацаанд Концесс эзэмшигчийн хөрөнгөөр бий болсон эд хөрөнгийн өмчлөлийг гуравдагч этгээдэд шилжүүлэхгүй.

11.1.4 Концессын зүйлд хийсэн аливаа засвар, орлуулалт, өөрчлөлт, шинэчлэлт нь Гэрээ дуусгавар болох эсхүл цуцлагдах үед Концессын зүйлийн хамт Эрх бүхий этгээдэд шилжих зорилгоор Концессын зүйлийн бүрдэл хэсэгт тооцогдоно (өмчлөлийн хувьд Концессын зүйл гэж бүртгэгдэнэ).

11.1.5 Концесс эзэмшигч нь Концессын хугацаа дуусгавар болох үед Концессын зүйл, Концесс эзэмшигчийн хөрөнгөөр бий болсон эд хөрөнгө, Концессын талбай болон Нисэх буудлын бизнесийг Эрх бүхий этгээд эсхүл түүний нэр заасан этгээдэд үнэ төлбөргүй шилжүүлнэ.

11.2 Үйл ажиллагаа ба засвар үйлчилгээ

Энэхүү Гэрээний зүйл, заалтуудыг харгалзан (үүнд энэхүү Гэрээний Хавсралт 4 (Удирдлага, зохион байгуулалтын нарийвчилсан хуваарь) хамаарна), түүний дагуу Концесс эзэмшигч нь Концессын хугацаанд дараах асуудлыг хариуцна. Үүнд:

11.2.1 Дор дурдсан зүйлсийн үйл ажиллагаа ба засвар үйлчилгээ:

(1) ҮАЗҮ зүйл; болон

(2) энэхүү Гэрээний 20 дугаар зүйл (Сайжруулах санал)-д заасны дагуу үйл ажиллагаа болон засвар үйлчилгээг нь Концесс эзэмшигч хариуцахаар Талуудын харилцан тохиролцсон аливаа бусад барилга байгууламж.

11.2.2 Дор дурдсан зүйлсийн засвар үйлчилгээ:

- (1) Засвар үйлчилгээний зүйл; болон
- (2) энэхүү Гэрээний 20 дугаар зүйл (Сайжруулах санал)-д заасны дагуу засвар үйлчилгээг нь Концесс эзэмшигч (ашиглахгүйгээр) хариуцахаар Талуудын харилцан тохиролцсон аливаа бусад барилга байгууламж.

11.3 Хүрээлэн буй орчин, эрүүл мэнд, аюулгүй ажиллагаа болон аюулгүй байдлын тухай хууль тогтоомжийг биелүүлэх

Концесс эзэмшигч нь энэхүү Гэрээнд заасан Концесс эзэмшигчийн чиг үүргээ хэрэгжүүлэх болон Гэрээгээр хүлээсэн бусад эрх, үүргээ гүйцэтгэхдээ хүрээлэн буй орчин, эрүүл мэнд, эрүүл ахуй, галын аюулгүй байдал, ажлын байрны эрүүл ахуй ба аюулгүй ажиллагаа, нисэхийн аюулгүй ажиллагаа болон аюулгүй байдалтай холбоотой бүхий л Хууль тогтоомж, дүрэм журам, стандартыг дагаж мөрдөнө.

11.4 Орлого

- 11.4.1 Концесс эзэмшигч нь энэхүү Гэрээний Хавсралт 2 (Төлбөр, хураамж)-ийн 2 дугаар хэсэгт заасан Зохицуулалтгүй төлбөр, хураамжийн хувь хэмжээг Өрсөлдөөний тухай хууль тогтоомжид нийцүүлэн, өөрийн үзэмжээр тогтоох эрхтэй.
- 11.4.2 Холбогдох Төрийн эрх бүхий байгууллагаас баталсан Зохицуулалттай төлбөр, хураамжийн анхны хувь хэмжээг Гэрээний Хавсралт 2 (Төлбөр, хураамж)-ийн 1 дүгээр хэсэгт заасан болно. Концесс эзэмшигч нь Зохицуулалттай төлбөр, хураамжийн хувь хэмжээнд оруулах аливаа өөрчлөлтийг энэхүү Гэрээний 26.1 дэх хэсэг (Нисэх буудлын төлбөр, хураамж) болон холбогдох Хууль тогтоомжид заасны дагуу ИНЕГ зэрэг холбогдох Төрийн эрх бүхий байгууллагаар батлуулахаар хүргүүлнэ.
- 11.4.3 Орлого нь дараах зүйлсээс бүрдэнэ. Үүнд:
 - (1) энэхүү Гэрээний 11.4.2 дах хэсэг (Орлого)-т заасан Зохицуулалттай төлбөр, хураамж;
 - (2) энэхүү Гэрээний 11.4.1 дэх хэсэг (Орлого)-т заасан Зохицуулалтгүй төлбөр, хураамж;
 - (3) энэхүү Гэрээний 14 дүгээр зүйл (Арилжааны боломжуудыг ашиглах эрх)-д заасны дагуу Концесс эзэмшигчийн олсон аливаа бусад орлого.

11.5 Гуравдагч этгээд ба Туслан гүйцэтгэгч

- 11.5.1 Концесс эзэмшигч нь Нисэх буудлын үйлчилгээ үзүүлэх болон Нисэх буудлын бизнес эрхлэх зорилгоор Хууль тогтоомж болон энэхүү Гэрээнд заасан нөхцөлүүдэд нийцүүлэн гуравдагч этгээдтэй гэрээ байгуулж болно. Гэрээ байгуулагч нь (i) Концесс эзэмшигчийн худалдан авах ажиллагааны шаардлага, стандартыг хангаж байгаа бөгөөд (ii) өрсөлдөхүйц үнэ санал болгосон тохиолдолд Концесс эзэмшигч нь холбогдох Хууль тогтоомж, гэрээ хэлэлцээрийн дагуу дотоодын хуулийн этгээдүүдтэй тэргүүн ээлжинд гэрээ байгуулахыг эрмэлзэж ажиллана.
- 11.5.2 Концесс эзэмшигч нь Нисэх буудлын бизнес эрхлэхтэй холбоотойгоор туслан гүйцэтгэгчтэй гэрээ байгуулсан тохиолдолд Эрх бүхий этгээдийн өмнө хүлээсэн аливаа үүргээсээ чөлөөлөгдөхгүй бөгөөд Гэрээний 32 дугаар зүйл (Концесс эзэмшигчийн хохирол нөхөн төлөх баталгаа)-д заасны дагуу туслан гүйцэтгэгчийн бүхий л үйлдлийн хувьд Эрх бүхий этгээдийн өмнө хариуцлага хүлээнэ.
- 11.5.3 Концесс эзэмшигч нь Нисэх буудлын бизнес эрхлэхтэй холбоотойгоор гуравдагч этгээдтэй гэрээ байгуулж болно. Концесс эзэмшигч нь Агаарын тээвэрлэгчидтэй нислэгийн талаар тохиролцоо хийхдээ холбогдох Хууль тогтоомжийг баримтлан ажиллана.
- 11.5.4 Концесс эзэмшигч нь Концессын талбайд нийтлэг үйлчилгээний хангамжийн байгууламжийн ашиглалттай холбоотойгоор гуравдагч этгээдтэй гэрээ байгуулах тохиолдолд тэрээр (i) Концесс эзэмшигчийн худалдан авах ажиллагааны шаардлага, стандартыг хангаж байгаа, (ii) өрсөлдөхүйц үнэ санал болгосон дотоодын хуулийн этгээдтэй холбогдох Хууль тогтоомж, гэрээ хэлэлцээрийн дагуу гэрээ байгуулна.

11.6 Энэхүү Гэрээтэй холбоотой бусад эрх, үүрэг

- 11.6.1 Концесс эзэмшигч нь ЧХОУНБ болон Эрх бүхий этгээдээс энэхүү Гэрээгээр хүлээсэн үүргээ гүйцэтгэхийг болон холбогдох Төрийн эрх бүхий байгууллагаар гүйцэтгүүлэх явдлыг хангахыг шаардах эрхтэй.
- 11.6.2 Концесс эзэмшигч нь энэхүү Гэрээ болон Хууль тогтоомжоор хориглосноос бусад асуудлыг бие даан шийдвэрлэж, арилжааны үйл ажиллагаа чөлөөтэй эрхлэн явуулах эрхтэй.

- 11.6.3 Концесс эзэмшигч нь бүх Концесс эзэмшигчийн авах зөвшөөрлүүдийг авна.
- 11.6.4 Концесс эзэмшигч нь Нисэх буудлын бизнесийн үйл ажиллагааг эрхлэн явуулахдаа Нисэх буудлын аюулгүй ажиллагааг хангахын тулд Аэродромын үйл ажиллагааны заавар, олон улсын болон дотоодын стандарт, шаардлагад нийцсэн дүрмийг баримтлан ажиллана.
- 11.6.5 Концесс эзэмшигч нь Концессын хугацаанд (энэхүү Гэрээний 44 дүгээр зүйл (Онцгой нөхцөл байдал)-ийг баримтлах Онцгой нөхцөл байдал үүссэнээс бусад тохиолдолд) Нисэх буудлын бизнесийн аюулгүй, тасралтгүй, тогтвортой ажиллагааг хангахаар онцгой хүчин чармайлт гарган ажиллана.
- 11.6.6 Концесс эзэмшигч нь Концессын хугацаанд УБХОУНОШБ-д Концесс эзэмшигчийн авч ажиллуулж буй Монгол ажилтнуудыг менежмент, Салбарын сайн туршлага, ноу-хауд сургаж, дадлагажуулна.
- ~~11.6.7 Концесс эзэмшигч нь Хууль тогтоомжийн дагуу татвар төлөх үүрэгтэй.~~
- 11.6.8 Концесс эзэмшигч нь Концессын зүйл болон бусад асуудлаар ИНЕГ зэрэг холбогдох Төрийн эрх бүхий байгууллагатай тусдаа гэрээ байгуулж болно.
- 11.6.9 Концесс эзэмшигч нь Шилжилтийн төлөвлөгөөг цаг хугацаанд нь хэрэгжүүлэх асуудлаар Эрх бүхий этгээд, холбогдох Төрийн эрх бүхий байгууллагууд болон ЧХОУНБ-тай хамтран ажиллах бөгөөд Шилжүүлэх комисс өөрөөр шийдсэнээс бусад тохиолдолд Шилжилтийн төлөвлөгөөнд заасан хуваарийн дагуу Концессын зүйлийг Эрх бүхий этгээд эсхүл холбогдох Төрийн эрх бүхий байгууллагаас хугацаа хойшлуулахгүйгээр шилжүүлэн хүлээн авна.
- 11.6.10 Концесс эзэмшигч нь энэхүү Гэрээнд заасан өөрийн эрх, үүрэг болон бусад хариуцсан асуудлыг үнэнч шударгаар, хянуур болгоомжтой байдлаар хийж гүйцэтгэнэ.

11.7 Буцаан шилжүүлэх үүрэг

- 11.7.1 Энэхүү Гэрээ дуусгавар болох эсхүл Гэрээ цуцлах үед Концесс эзэмшигч нь Концессын зүйл болон Концесс эзэмшигчийн хөрөнгөөр бий болсон эд хөрөнгийг Эрх бүхий этгээд эсхүл түүний нэр заасан этгээдэд буцаан шилжүүлнэ. Гэрээ дуусгавар

болох эсхүл Гэрээ цуцлах үед Концессын зүйл болон Концесс эзэмшигчийн хөрөнгөөр бий болсон эд хөрөнгө нь өөрийн ашиглалтын хугацаанд хэвийн нөхцөлд бүрэн ажиллагаатай байх ёстой бөгөөд ингэхдээ ердийн ашиглалтын явцад үүссэн элэгдэл, хорогдол болон насжилтаас шалтгаалсан эвдрэлийг харгалзан үзнэ. Давагдашгүй хүчин зүйл эсхүл Гэрээг цуцлахад хүргэсэн Эрх бүхий этгээдийн үйлдлийн улмаас Концессын зүйл болон Концесс эзэмшигчийн хөрөнгөөр бий болсон эд хөрөнгөд бүхэлд нь эсхүл хэсэгчлэн үйл ажиллагааны доголдол үүссэн бөгөөд уг эрсдлийг хамарсан даатгал хийгдээгүй бол Концесс эзэмшигч тэдгээрийг байгаа байдлаар нь буцаан шилжүүлнэ.

11.7.2 Концессын талбайг Гэрээгээр газар ашиглуулах эрхийн тухай гэрээнд заасан нөхцөлийн дагуу уг гэрээг дуусгавар болгох эсхүл цуцлах замаар Эрх бүхий этгээдэд буцаан шилжүүлнэ.

11.7.3 Концессын зүйл болон Концесс эзэмшигчийн хөрөнгөөр бий болсон хөрөнгө нь Эрх бүхий этгээдэд буцаан шилжүүлэх үед хэвийн нөхцөлд бүрэн ажиллах боломжгүй (энэхүү Гэрээний 11.7.1 дэх хэсэг (Буцаан шилжүүлэх үүрэг)-т заасны дагуу) бол шаардлагатай хэсгийг засах, солих, шинэчлэх, худалдан авахтай холбоотой Эрх бүхий этгээдэд учирсан үнэ болон зардлыг Концесс эзэмшигч хариуцаж, Эрх бүхий этгээдэд төлнө.

11.7.4 Концессын зүйл болон Концесс эзэмшигчийн хөрөнгөөр бий болсон эд хөрөнгийг Эрх бүхий этгээдэд буцаан шилжүүлэх үед тэдгээр нь бүрэн ажиллагаатай байх (энэхүү Гэрээний 11.7.1 дэх хэсэг (Буцаан шилжүүлэх үүрэг)-т заасны дагуу) явдлыг хангах зорилгоор Концесс эзэмшигч нь Концессын зүйл болон Концесс эзэмшигчийн хөрөнгөөр бий болсон эд хөрөнгийн шаардлагатай засвар, шинэчлэлт, худалдан авалтад зориулсан томоохон засвар үйлчилгээний нөөц сан байгуулан ажиллана. Түүнчлэн, энэхүү томоохон засвар үйлчилгээний нөөц санг энэхүү 11.7.4 дэх хэсэг (Буцаан шилжүүлэх үүрэг)-ийг харгалзан, Концесс эзэмшигчийн санхүүгийн хэвийн нөхцөл байдлыг тогтвортой байлгах зорилгоор байгуулан ажиллана.

11.8 Маркетинг

Концесс эзэмшигч нь Нисэх буудлын бизнесийн үйл ажиллагаа эрхлэхдээ нислэгийн тоог нэмэгдүүлэх, шинэ нислэгийн чиглэл бий болгох зорилгоор Концесс эзэмшигчийн маркетингийн стратеги (Санхүүгийн төлөвлөгөөнд заасан)-д нийцүүлэн УБХОУНОШБ-ыг гадаадын агаарын тээвэрлэгчдэд сурталчлах зэргээр УБХОУНОШБ-ыг Агаарын

тээвэрлэгчид болон бусад Нисэх буудлын хэрэглэгчдэд сурталчлах маркетингийн үйл ажиллагаа явуулна.


11.9 Хувьцаа шилжүүлэхтэй холбоотой Эрх бүхий этгээдийн зөвшөөрөл

11.9.1 Концесс эзэмшигч нь Үйл ажиллагаа эхлэх өдрөөс хойш зургаан (6) жил хүртэл хугацаанд дор дурдсан асуудлыг хангаж ажиллана. Үүнд:

- (1) Засгийн газрын хувьцаа эзэмшигч болон Консерциум ТЗК нар нь Концесс эзэмшигчийн аливаа хувьцааг бие биедээ эсвэл Хувьцаа эзэмшигчдийн гэрээний зөрчил бий болсны улмаас уг гэрээнд заасан нөхцөлийн дагуу шилжүүлж байгаагаас бусад тохиолдолд шилжүүлэхгүй; ба
- (2) Консерциумын гишүүдийн хооронд байгуулагдсан хувьцаа эзэмшигчдийн гэрээ ("Консерциум ТЗК-ийн хувьцаа эзэмшигчдийн гэрээ")-д заасан зөрчлийн тохиолдол бий болсны улмаас уг Консерциум ТЗК-ийн хувьцаа эзэмшигчдийн гэрээнд заасан нөхцөлийн дагуу Консерциумын бусад гишүүдэд шилжүүлэхээс бусад тохиолдолд Консерциумын гишүүд Консерциумд ТЗК-ийн аливаа хувьцааг шилжүүлэхгүй.

11.9.2 Үйл ажиллагаа эхэлсэн өдрөөс хойш зургаан (6) жилийн дараах өдрөөс хойш дор дурдсан тохиолдлын аль нэг нь бий болсон тохиолдолд Концесс эзэмшигч нь хувьцаа шилжүүлэх талаар Эрх бүхий этгээдээс зөвшөөрөл авахаар бичгээр хүсэлт гаргана. Үүнд:

- (1) Засгийн газрын хувьцаа эзэмшигч болон Консерциум ТЗК нар нь Концесс эзэмшигчийн аливаа хувьцааг Хувьцаа эзэмшигчдийн гэрээний дагуу гуравдагч этгээд (Засгийн газрын хувьцаа эзэмшигч, Консерциум ТЗК, Консерциумын аль нэг гишүүн эсхүл тэдгээрийн аливаа Нэгдмэл сонирхолтой этгээд биш байна)-д шилжүүлэхийг санал болгосон; эсхүл
- (2) Консерциумын гишүүд Консерциумд ТЗК-д эзэмшиж буй аливаа хувьцааг Консерциум ТЗК-ийн хувьцаа эзэмшигчдийн гэрээний дагуу гуравдагч этгээд (Засгийн газрын хувьцаа эзэмшигч, Консерциум ТЗК, Консерциумын аль нэг гишүүн эсхүл тэдгээрийн аливаа Нэгдмэл сонирхолтой этгээд биш байна)-д шилжүүлэхийг санал болгосон.



11.9.3 Концесс эзэмшигч нь энэхүү 11.9.2 дах хэсэг (Хувьцаа шилжүүлэхтэй холбоотой Эрх бүхий этгээдийн зөвшөөрөл)-т заасан зөвшөөрлийг авахаар Эрх бүхий этгээдэд хүсэлт гаргасан тохиолдолд Эрх бүхий этгээд нь дор дурдсан аль нэг эсхүл хэд хэдэн үндэслэлээр хувьцаа шилжүүлэх зөвшөөрөл олгохоос татгалзаж болно. Үүнд:

- (1) хувьцаа эзэмшигч нь Концесс эзэмшигчийн эсхүл Консерциум ТЗК-ийн хувьцаа эзэмшигч байх нь Монгол Улсын Хууль тогтоомжийн дагуу зөвшөөрөгдөхгүй; эсхүл
- (2) хувьцаа шилжүүлэн авахаар санал болгосон этгээд нь өөрийн эзэмшлийн хувьцааг шилжүүлж байгаа Консерциумын гишүүн, Засгийн газрын хувьцаа эзэмшигчээс техникийн болон/эсхүл санхүүгийн чадвар, туршлага болон техникийн ур чадварын хувьд эн тэнцүү эсхүл түүнээс дээш байх шаардлага хангахгүй эсхүл эсхүл Концесс эзэмшигч болон Консерциум ТЗК-ийн хувьцаа эзэмшигчийн эрх, үүргийг хэрэгжүүлэх хангалттай нөөц, бололцоогүй; эсхүл
- (3) хувьцаа шилжүүлэн авахаар санал болгосон этгээд нь гадаадын төрийн өмчийн эсхүл гадаадын төрийн өмчийн ямар нэгэн оролцоотой этгээд бол.

11.9.4 Эрх бүхий этгээд нь энэхүү Гэрээний 11.9.2 дах хэсэг (Хувьцаа шилжүүлэхтэй холбоотой Эрх бүхий этгээдийн зөвшөөрөл)-т заасан мэдэгдлийг хүлээн авснаас хойш хорин (20) Ажлын өдрийн дотор (i) хувьцаа шилжүүлэх зөвшөөрөл олгох эсхүл (ii) энэхүү Гэрээний 11.9.3 дах хэсэг (Хувьцаа шилжүүлэхтэй холбоотой Эрх бүхий этгээдийн зөвшөөрөл)-т заасан аль нэг үндэслэлээр хувьцаа шилжүүлэх зөвшөөрөл олгохоос татгалзсан эсэхийг мэдэгдэнэ. Эрх бүхий этгээд заасан хугацаанд хариу мэдэгдээгүй тохиолдолд хувьцаа шилжүүлэх зөвшөөрлийг олгосонд тооцно. Эрх бүхий этгээд зөвшөөрөл олгохоос татгалзсан бөгөөд Концесс эзэмшигч нь Эрх бүхий этгээдийн татгалзсан үндэслэлтэй санал нийлэхгүй тохиолдолд Концесс эзэмшигч асуудлыг энэхүү Гэрээний 48 дугаар зүйл (Маргаан шийдвэрлэх)-д зааснаар шийдвэрлүүлнэ.

12. ОЮУНЫ ӨМЧ

12.1 Оюуны өмчийн эрх шилжүүлэх

Энэхүү Гэрээний 12.3 дах хэсгийн дагуу олгосон лицензийн хариуд Концесс эзэмшигч нь дор дурдсан ирээдүйд бий болох бүх Оюуны өмчийг

Эрх бүхий этгээдийн зүгээс энэ Гэрээгээр хүлээсэн эрх, үүргээ гүйцэтгэх болон УБХОУНОШБ-тай холбоотой шаардлагатай чиг үүргийг энэ Гэрээний 10 дугаар бүлэг (Концессын зүйлийг буцаан шилжүүлэх)-т заасан үйл явдлыг багтаагаад Концессын хугацаанд болон түүний дараа хэрэгжүүлэхэд зориулж Эрх бүхий этгээдэд үнэ төлбөргүйгээр, аливаа эрхийн шаардлагаас ангид байдлаар шилжүүлнэ. Үүнд:

12.1.1 Концессын хугацаанд Концесс эзэмшигчид бий болсон эсхүл түүний эзэмшиж байгаа; мөн

12.1.2 УБХОУНОШБ-ын үйл ажиллагаа болон/эсхүл Нисэх буудлын бизнестэй шууд хамааралтай болон зайлшгүй шаардлагатай.

12.2 Концесс эзэмшигч нь УБХОУНОШБ-ын үйл ажиллагаа болон Нисэх буудлын бизнесийг эрхлэн явуулахад шаардлагатай Оюуны өмчийг өмчлөх эсхүл ашиглах эрхтэй байх, уг эрхээ хэвээр хадгалах явдлыг хариуцах ба үүнд дор дурдсан арга хэмжээ хамаарах боловч эдгээрээр хязгаарлагдахгүй болно. Үүнд:

12.2.1 аливаа барааны тэмдэг болон/эсхүл дэлхийн хаана ч гаргасан патентийн өргөдөл болон/эсхүл бүртгэлийг хэвээр хадгалах болон шинэчлэх;

12.2.2 энэхүү Гэрээний дагуу Эрх бүхий этгээдээс Концесс эзэмшигчид дамжуулан лизенц олгосон гуравдагч этгээдийн Оюуны өмчийн лицензийн төлбөрийг төлөх;

12.2.3 аливаа лиценз болон Концессын хугацаанд шинээр бий болсон, холбогдох Төрийн эрх бүхий байгууллагад бүртгүүлэх шаардлагатай Оюуны өмчийг Хууль тогтоомжид заасан хугацаанд бүртгүүлэх.

12.3 Оюуны өмчийн лиценз

12.3.1 Эрх бүхий этгээд нь Концесс эзэмшигчийн зүгээс энэхүү Гэрээгээр хүлээсэн эрх, үүргээ гүйцэтгэх болон УБХОУНОШБ-тай холбоотой шаардлагатай чиг үүргийг Концессын хугацааны туршид хэрэгжүүлэхэд зориулж, энэхүү Гэрээг байгуулах үед бий болсон байгаа эсхүл Концессын хугацаанд бий болсон дор дурдсан, шаардлагатай Оюуны өмчийн Талууд тусдаа гэрээгээр өөрөөр тохиролцсоноос бусад тохиолдолд дамжуулан ашиглуулах боломжтой лицензийг Концесс эзэмшигчид үнэ төлбөргүйгээр олгоно. Үүнд:

(1) Эрх бүхий этгээд өмчилдөг эсхүл ашиглах эрхтэй;



- (2) УБХОУНОШБ-ын үйл ажиллагаа болон/эсхүл Нисэх буудлын бизнестэй шууд хамааралтай болон зайлшгүй шаардлагатай.

12.3.2 Лицензийн тусгай гэрээ байгуулан өөрөөр тохиролцсоноос бусад тохиолдолд энэхүү Гэрээний 12.3.1 дэх хэсэг (Оюуны өмчийн лиценз)-т заасны дагуу Эрх бүхий этгээдээс Концесс эзэмшигчид олгосон Оюуны өмчийн лиценз нь энэхүү Гэрээний хугацаа дуусгавар болох эсхүл Гэрээг хугацаанаас нь өмнө цуцалснаар дуусгавар болно.

12.3.3 Эрх бүхий этгээд нь УБХОУНОШБ-ын үйл ажиллагаа болон Нисэх буудлын үйлчилгээнд шаардлагатай гэж Концесс эзэмшигчийн үзсэн бөгөөд энэхүү Гэрээний 12.3.1 дэх хэсэг (Оюуны өмчийн лиценз)-т заасны дагуу Концесс эзэмшигчид лиценз олгосон Оюуны өмчийг Төрийн эрх бүхий байгууллага болон ЧХОУНБ-ын зүгээс Концесс эзэмшигчийн зардлаар олж авах, хэвээр хадгалах явдлыг хариуцах ба үүнд дор дурдсан арга хэмжээ хамаарах боловч эдгээрээр хязгаарлагдахгүй болно. Үүнд:

- (1) Оюуны өмчийг хамгаалахад шаардлагатай барааны тэмдэг болон/эсхүл патентийн өргөдөл болон/эсхүл бүртгэлийг хэвээр хадгалах, шинэчлэх;
- (2) энэхүү Гэрээний дагуу Эрх бүхий этгээдээс Концесс эзэмшигчид дамжуулан лиценз олгосон гуравдагч этгээдийн Оюуны өмчийн лицензийн үндэслэл бүхий төлбөрийг төлөх; болон
- (3) энэхүү Гэрээний дагуу олгосон лицензийг аль болох боломжит хугацаанд гэхдээ Хууль тогтоомжид заасан хугацаанаас хэтрүүлэхгүйгээр холбогдох Төрийн эрх бүхий байгууллагад бүртгүүлэх.

12.3.4 Концесс эзэмшигч нь Эрх бүхий этгээдийн чиг үүргийг хэрэгжүүлэхэд шаардлагатай гэж Эрх бүхий этгээдийн үзсэн бөгөөд энэхүү Гэрээний дагуу Эрх бүхий этгээдэд лиценз олгосон Оюуны өмчийг Эрх бүхий этгээдийн зардлаар олж авах, хэвээр хадгалан хамгаалах болон энэ Гэрээний 12 дугаар зүйл (Оюуны өмч)-д заасан бусад үүргээ хариуцан биелүүлэх ба үүнд дор дурдсан арга хэмжээ хамаарах боловч эдгээрээр язгаарлагдахгүй болно. Үүнд:

- (1) Оюуны өмчийг хамгаалахад шаардлагатай барааны тэмдэг болон/эсхүл патентын өргөдөл болон/эсхүл бүртгэлийг хэвээр хадгалах, шинэчлэх;
- (2) энэхүү Гэрээний дагуу Концесс эзэмшигчээс Эрх бүхий этгээдэд дамжуулан лиценз олгосон гуравдагч этгээдийн Оюуны өмчийн үндэслэл бүхий лицензийн төлбөрийг төлөх; болон
- (3) энэхүү Гэрээний дагуу олгосон лицензийг аль болох боломжит хугацаанд гэхдээ Хууль тогтоомжид заасан хугацаанаас хэтрүүлэхгүйгээр холбогдох Төрийн эрх бүхий байгууллагад бүртгүүлэх.

13. АЖИЛТАН БОЛОН СУРГАЛТ

13.1 Шилжүүлсэн ажилтнуудын тооны дээд хязгаар

Концесс эзэмшигч нь энэхүү 13 дугаар зүйл (Ажилтан болон сургалт)-д заасны дагуу ИНЕГ болон ЧХОУНБ-аас ажилтнууд хүлээн авна. ИНЕГ болон ЧХОУНБ-аас Шилжүүлсэн ажилтнуудын тоо 770-аас хэтрэхгүй байна.

13.2 Шилжүүлэх журам

- 13.2.1 Эрх бүхий этгээд нь ИНЕГ болон ЧХОУНБ-аас шилжүүлэхээр санал болгож буй ажилтан тус бүрийн хувийн хэргийг, түүний ажил үүрэг, цалин, нийгмийн хангамж болон хөдөлмөрийн нөхцөлийн хамт тусгасан мэдэгдлийг энэхүү Гэрээнд гарын үсэг зурахын өмнө эсхүл түүний дараа нэн даруй Концесс эзэмшигчид хүргүүлнэ;
- 13.2.2 Концесс эзэмшигч нь Шилжүүлсэн ажилтнуудтай холбоотойгоор ИНЕГ болон үйлдвэрчний эвлэл (эсхүл холбогдох ажилтнуудын бусад төлөөлөл)-тэй Хамтын гэрээ байгуулах ба Концесс эзэмшигч нь (i) Хамтын гэрээний дагуу хүлээн авах ажилтнууд болон (ii) Шилжүүлсэн ажилтан тус бүрт санал болгох ажлын чиг үүрэг, цалин хөлс, нийгмийн хангамж, хөдөлмөрийн нөхцөлийн талаар Эрх бүхий этгээдэд мэдэгдэнэ. Хамтын гэрээний агуулга, түүнийг байгуулах журам нь Монгол Улсын Хөдөлмөрийн тухай хуульд нийцсэн байна.
- 13.2.3 Шилжүүлсэн ажилтнуудыг шилжүүлэх нарийвчилсан журмыг Шилжилтийн төлөвлөгөөнд заана.

13.3 Ажилтнуудын нийгмийн хангамж болон хөдөлмөрийн нөхцөл

Концесс эзэмшигч нь энэхүү Гэрээний 13.2.2 дах хэсэг (Шилжүүлэх журам)-т заасны дагуу Шилжүүлсэн ажилтан тус бүрийн албан тушаал, цалин хөлс, нийгмийн хангамж болон хөдөлмөрийн нөхцөлийг тодорхойлохдоо Нисэх буудлын үйл ажиллагааг эхлүүлэх бэлтгэл үе шатанд боловсруулж, Санхүүгийн төлөвлөгөөнд тусгасан Нисэх буудлын бизнесийн бодлогод заасан байгууллагын зохион байгуулалтын бүтэц болон хүний нөөцийн бодлогыг удирдлага болгоно. Зарчмын хувьд Концесс эзэмшигчийн хүний нөөцийн бодлого нь Шилжүүлсэн ажилтнууд өмнө нь ЧХОУНБ, ИНЕГ-аас авч байсан хөдөлмөрийн нөхцөл, нийгмийн хангамжийг дордуулсан, түүнээс дор нөхцөлтэй байж болохгүй.

13.4 Сургалт

Концесс эзэмшигч нь Шилжүүлсэн ажилтнуудыг Шилжилтийн төлөвлөгөөний дагуу сургалтад хамруулна.

13.5 Концесс эзэмшигчид шилжүүлээгүй ажилтнаас гаргах аливаа шаардлагыг багтаагаад Эрх бүхий этгээд, ИНЕГ, ЧХОУНБ эсхүл аливаа Эрх бүхий этгээдтэй хамаарал бүхий этгээдээс зарим ажилтнуудыг Концесс эзэмшигчид шилжүүлээгүйтэй холбоотой аливаа нэхэмжлэл, шаардлагыг Эрх бүхий этгээд дангаар хариуцах бөгөөд дээр дурдсан аливаа шаардлага, нэхэмжлэлээс Концесс эзэмшигчийг ангид, хохиролгүй байлгана.

14. АРИЛЖААНЫ БОЛОМЖУУДЫГ АШИГЛАХ ЭРХ

14.1 Концесс эзэмшигч нь Концессын хугацаанд өөрөө шууд эсхүл гуравдагч этгээдтэй гэрээ байгуулах замаар Концессын талбай болон Концессын зүйлийн арилжааны аливаа боломжийг Хууль тогтоомжийн хүрээнд ашиглах онцгой эрхтэй байх ба үүнд дараах арилжааны боломжууд багтана. Үүнд:

14.1.1 Нисэх буудлын талбайн зургийн 23 дугаар зүйлд харуулсан, туслах байгууламжууд, тэмдэг тэмдэглээ, гэрэлтүүлэг болон тоног төхөөрөмж зэргийг багтаасан ачааны терминалын барилгыг ажиллуулах болон/эсхүл түрээслүүлэх гэрээ байгуулах;

14.1.2 Нисэх буудлын талбайн зургийн 28 дугаар зүйлд харуулсан Захиргааны барилгыг ашиглах болон/эсхүл түүнийг түрээслүүлэх талаар гэрээ байгуулах;

14.1.3 Нисэх буудлын талбайн зургийн 24 дүгээр зүйлд харуулсан төлбөр хураах цэг, дулаан гараж, туслах зам, терминалын зам

болон бүхий л туслах байгууламж, тоног төхөөрөмж бүхий Автомашины зогсоолын талбайд автомашины зогсоол ажиллуулах;

14.1.4 Зорчигч терминалын барилгад автомашин хөлслөх болон ачаа хадгалуулах, ачаа хүргэлтийн үйлчилгээ ажиллуулах;

14.1.5 Зорчигч терминалын барилгын Концессын бус зүйл болох VIP лоунжийн хэсгээс бусад хэсэгт жижиглэнгийн худалдаа, хоол хүнс болон уух зүйлс (үүнд татваргүй бараа хамаарна) борлуулах эрхийн түрээсийн талаар гэрээ байгуулах; болон

14.1.6 Концессын зүйлийн сурталчилгааны талбайг түрээслүүлэх талаар гэрээ байгуулах.

14.2 Концесс эзэмшигч нь энэхүү гэрээний 11 дүгээр зүйл (Концесс эзэмшигчийн эрх, үүрэг)-д заасан эрхээ хэрэгжүүлэхдээ дээрх 14.1 дэх хэсэг (Арилжааны боломжуудыг ашиглах эрх)-т заасан арилжааны боломжуудын хувьд хураамж, төлбөр, түрээс болон бусад орлогыг энэхүү Гэрээний Хавсралт 2 (Төлбөр, хураамж)-т заасны дагуу хураах, ногдуулах онцгой эрх эдэлнэ.

14.3 Концесс эзэмшигч нь энэхүү Гэрээний 14.1 дэх хэсэг (Арилжааны боломжуудыг ашиглах эрх)-т заасан арилжааны боломжуудыг ашиглан үйл ажиллагаа явуулахдаа өөрөө болон гэрээ байгуулан ажиллаж байгаа гуравдагч этгээд нь бүхий л холбогдох Хууль тогтоомж болон холбогдох Концесс эзэмшигчийн авах зөвшөөрлүүд болон Төрийн эрх бүхий байгууллагын авах зөвшөөрлүүдийг дагаж мөрдөж ажиллах явдлыг хангана.

14.4 Газрын үйлчилгээ

14.4.1 Концесс эзэмшигч нь Концессын зүйл болон Концессын талбайд өөрөө шууд эсхүл гуравдагч этгээдтэй гэрээ байгуулах замаар газрын үйлчилгээ үзүүлэх эрхтэй. Концесс эзэмшигч нь өөрийн үзүүлсэн газрын үйлчилгээний хувьд Газрын үйлчилгээний төлбөр, хураамж (энэхүү Гэрээний Хавсралт 2 (Төлбөр хураамж)-ийн 2 дугаар хэсэгт заасан) өөрөө ногдуулах, хураан авах эрхтэй.

14.4.2 Концесс эзэмшигч нь Дотоодын агаарын тээвэрлэгчид Концессын зүйл болон Концессын талбайд өөрийн агаарын нислэгт болон бусад Агаарын тээвэрлэгчтэй гэрээ байгуулсны дагуу тэдгээрийн нислэгт газрын үйлчилгээ үзүүлэх эрхтэйг хүлээн зөвшөөрч байгаа болно. Үүнтэй холбоотойгоор Концесс эзэмшигч нь холбогдох Дотоодын агаарын тээвэрлэгчид

Концессын зүйл болон Концессын талбайд нэвтрэх зөвшөөрөл олгох ба ингэхдээ тухайн Дотоодын агаарын тээвэрлэгч нь Аэродромын үйл ажиллагааны зааврын дагуу Концесс эзэмшигчийн боловсруулсан холбогдох дүрэм, журмыг багтаагаад Концесс эзэмшигчийн үйл ажиллагааны бүхий л үндэслэл бүхий шаардлагыг биелүүлж ажиллах шаардлагатай. Дотоодын агаарын тээвэрлэгчдээс өөр гуравдагч этгээд Концессын талбайд газрын үйлчилгээ эрхлэхийг хүсэх тохиолдолд Концесс эзэмшигчээс зөвшөөрөл авна.

- 14.5 Концесс эзэмшигч нь Нисэх буудлын бизнес эрхлэхдээ энэхүү Гэрээний 14 дүгээр зүйл (Бизнесийн боломжуудыг ашиглах эрх)-д заасан арилжааны боломжуудыг Концесс эзэмшигч өөрөө нэн тэргүүнд ашиглахын төлөө онцгой хүчин чармайлт гаргаж ажиллана.

15. КОНЦЕСС ЭЗЭМШИГЧИД ХОРИГЛОХ ЗҮЙЛ

- 15.1 Концесс эзэмшигч нь дор дурдсан үйл ажиллагаа явуулахыг хориглоно. Үүнд:

15.1.1 Концессын зүйлийг барьцаалах эсхүл түүнд бусад хэлбэрээр барьцаа үүсгэх;

15.1.2 Энэхүү Гэрээгээр олгогдсон эрх, үүргээ шилжүүлэх;

15.1.3 Хувьцаагаа нээлттэй болон хаалттай хэлбэрээр худалдах, шинээр үнэт цаас гаргах;

15.1.4 Концессын талбайд Нисэх буудлын бизнес болон Нисэх буудлын үйлчилгээнээс өөр төрлийн үйл ажиллагаа эрхлэх; эсхүл

15.1.5 Хувьцаагаа барьцаалах.

ГУРАВДУГААР БҮЛЭГ. НИСЭХ БУУДЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГААГ ЭХЛҮҮЛЭХ БЭЛТГЭЛ ҮЕ ШАТАН ДАХ ҮҮРЭГ БА ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

16. НИСЭХ БУУДЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГААГ ЭХЛҮҮЛЭХ БЭЛТГЭЛ ҮЕ ШАТ БА УРЬДЧИЛСАН НӨХЦӨЛ

16.1 Нисэх буудлын үйл ажиллагааг эхлүүлэх бэлтгэл үе шатан дах Концесс эзэмшигчийн үүрэг

Нисэх буудлын үйл ажиллагааг эхлүүлэх бэлтгэл үе шатанд Концесс эзэмшигч дор дурдсан ажлыг хийж гүйцэтгэнэ. Үүнд:

16.1.1 Эрх бүхий этгээд болон Шилжүүлэх Комисстой харилцан зөвшилцөж, хамтран ажиллах замаар энэхүү Гэрээний Хавсралт

2 (Шилжилтийн төлөвлөгөөний тойм)-т заасан Шилжилтийн төлөвлөгөөний тоймд үндэслэн Шилжилтийн төлөвлөгөө боловсруулан тохиролцож, уг төлөвлөгөөг хэрэгжүүлэх;

16.1.2 Шилжилтийн төлөвлөгөөнд заасан нөхцөлийн дагуу Шилжүүлсэн ажилтнуудад сургалт зохион байгуулах;

16.1.3 Санхүүгийн төлөвлөгөө боловсруулан хүргүүлэх;

16.1.4 Нисэх буудлын онцгой байдлын төлөвлөгөө, Нисэх буудлын аюулгүй байдлын хөтөлбөр, Аэродромын үйл ажиллагааны зааврыг тус тус боловсруулж, холбогдох хууль, журмын дагуу зөвшөөрөл авах;

16.1.5 Нисэх буудлын үйлчилгээний бүх тоног төхөөрөмжийг худалдан авах;

16.1.6 Зорчигч терминалын барилгад ажиллах жижиглэн худалдаа, хоол хүнс, уух зүйлс борлуулах эрх бүхий түрээслэгчдийг сонгох;

16.1.7 Нисэх буудлын бизнес болон Нисэх буудлын талбайтай холбоотой аливаа чухал ач холбогдол бүхий асуудлын талаар Эрх бүхий этгээдийг мэдээллээр бүрэн хангах;

16.2 Нисэх буудлын үйл ажиллагааг эхлүүлэх бэлтгэл үе шатан дах Эрх бүхий этгээдийн үүрэг

Нисэх буудлын үйл ажиллагааг эхлүүлэх бэлтгэл үе шатанд Эрх бүхий этгээд дор дурдсан ажлыг хийж гүйцэтгэнэ. Үүнд:

16.2.1 Концесс эзэмшигчээс урьдчилан бичгээр авсан зөвшөөрөлгүйгээр УБХОУНОШБ-ын Нисэх буудлын бизнестэй холбоотой аливаа гэрээ хэлцэл байгуулах, цуцлах, чөлөөлөх, татгалзах болон өөрчлөх үйлдэл хийхгүй байх;

16.2.2 Нисэх буудлын бизнес болон Нисэх буудлын талбайтай холбоотой аливаа чухал ач холбогдол бүхий асуудлын талаар Концесс эзэмшигчийг мэдээллээр бүрэн хангах;

16.2.3 Концесс эзэмшигчийг Эрх бүхий этгээд болон бусад Төрийн эрх бүхий байгууллага, ЧХОУНБ, Нисэх буудлын талбайд нэвтрэх болон Нисэх буудлын үйлчилгээг алгуур, үр дүнтэй эхлүүлэхэд үндэслэлтэйгээр шаардагдах бүхий л мэдээлэл, бичиг баримтыг олж авах боломжоор хангах;

16.2.4 Шилжүүлсэн ажилтнуудыг энэхүү Гэрээний 16.1.2 дах хэсэг (Нисэх буудлын үйл ажиллагааг эхлүүлэх бэлтгэл үе шатан дах

Концесс эзэмшигчийн үүрэг)-т заасны дагуу Концесс эзэмшигчийн зохион байгуулсан сургалтад оролцуулах явдлыг ЧХОУНБ эсхүл ИНЕГ-ын зүгээс хангах асуудлыг хариуцах;

- 16.2.5 Концесс эзэмшигч, Шилжүүлэх комисс болон ИНЕГ зэрэг холбогдох бүх Төрийн эрх бүхий байгууллагууд, ЧХОУНБ-тай харилцан зөвшилцөж, хамтран ажиллах замаар энэхүү Гэрээний Хавсралт 2 (Шилжилтийн төлөвлөгөөний тойм)-т заасан Шилжилтийн төлөвлөгөөний тоймд үндэслэн Шилжилтийн төлөвлөгөө боловсруулан тохиролцож, уг төлөвлөгөөг хэрэгжүүлэх;
- 16.2.6 Концесс эзэмшигч болон ИНЕГ зэрэг холбогдох Төрийн эрх бүхий байгууллагатай харилцан зөвшилцөх, хамтран ажиллах замаар Концесс эзэмшигчийн зүгээс Санхүүгийн төлөвлөгөө, Нисэх буудлын онцгой байдлын төлөвлөгөө, Нисэх буудлын аюулгүй байдлын хөтөлбөр, Аэродромын үйл ажиллагааны зааврыг тус тус боловсруулахад туслалцаа үзүүлэх;
- 16.2.7 УБХОУНОШБ-д хүрэх замыг тэмдэглэсэн мэдээллийн самбарыг оролцуулан Нисэх буудлын талбайд хүрэх зам барих болон Нисэх буудлын үйл ажиллагаанд шаардлагатай нийтлэг үйлчилгээний хангамжийн асуудлыг хариуцах;
- 16.2.8 Гааль, хилийн хяналт болон гадаадын иргэн харьяатын газар, цагдаа, Агаарын тээвэрлэгчид болон бусад Төрийн эрх бүхий байгууллагатай хамтран ажиллах замаар Нисэх буудлын талбайн (Концесс эзэмшигчид шилжүүлсэн Концессын зүйл болон Концессын талбай үүнд хамаарахгүй) аюулгүй байдал болон хамгаалалтыг хариуцах;
- 16.2.9 Аливаа этгээд Нисэх буудлын талбайг бүхэлд нь эсхүл хэсэгчлэн хууль бусаар эзэмшилдээ аваагүй байх явдлыг хариуцах;
- 16.2.10 Нисэх буудлын үйл ажиллагаа эхлэх өдрөөс 56 (тавин зургаа)-аас доошгүй хоногийн өмнө ЧХОУНБ-ын үйл ажиллагааг УБХОУНОШБ руу шилжих талаар Агаарын навигацийн мэдээллийн товхимол (ОУАТХ-оос тодорхойлсон)-д нийтлэх; болон
- 16.2.11 Концесс эзэмшигчээс холбогдох Хууль тогтоомжийн дагуу боловсруулан ирүүлсэн Зохицуулалттай төлбөр, хураамжийг холбогдох Төрийн эрх бүхий байгууллага хянаж, батлах явдлыг хариуцах.

16.3 Концесс эзэмшигчийн урьдчилсан нөхцөл

Концесс эзэмшигч нь дор дурдсан Концесс эзэмшигчийн урьдчилсан нөхцөлүүд-ийг хангана. Үүнд:

16.3.1 Заавар болон Төлөвлөгөө

- (1) Эрх бүхий этгээдэд Санхүүгийн төлөвлөгөө хүргүүлсэн байх;
- (2) Хууль тогтоомжийн дагуу холбогдох Төрийн эрх бүхий байгууллагаас зөвшөөрч баталгаажуулсан Нисэх буудлын онцгой байдлын төлөвлөгөөг Эрх бүхий этгээдэд хүргүүлсэн байх;
- (3) Хууль тогтоомжийн дагуу Төрийн эрх бүхий байгууллагаас зөвшөөрч баталгаажуулсан Аэродромын зааврыг Эрх бүхий этгээдэд хүргүүлсэн байх;
- (4) Нисэх буудлын аюулгүй байдлын хөтөлбөрийг баталж, Эрх бүхий этгээдэд хүргүүлсэн байх.

16.3.2 Даатгал

Концесс эзэмшигчийн даатгал энэхүү Гэрээний 47 дугаар зүйл (Даатгал)-ийн дагуу хүчин төгөлдөр болсон байх.

16.3.3 Худалдан авалт

Арилжааны үйл ажиллагааг эхлүүлэхэд шаардлагатай Нисэх буудлын үйлчилгээний тоног төхөөрөмжийг худалдан авч дууссан байх.

16.3.4 Агаарын тээвэрлэгчийн гэрээ

Концесс эзэмшигч Агаарын тээвэрлэгчидтэй гэрээ байгуулсан байх.

16.3.5 Гэрээгээр газар ашиглуулах эрхийн тухай гэрээ

Концесс эзэмшигч Гэрээгээр газар ашиглуулах эрхийн тухай гэрээг байгуулсан байх.

16.3.6 Шилжүүлсэн ажилтнуудын сургалт дууссан байх

Шилжилтийн төлөвлөгөөний дагуу Шилжүүлсэн ажилтнуудын сургалтыг зохион байгуулж дууссан байх.

16.3.7 Концесс эзэмшигчийн авах зөвшөөрлүүд

Концесс эзэмшигчийн авах зөвшөөрлүүдийг авсан байх.

16.3.8 Шилжилт

Шилжилтийн төлөвлөгөөний дагуу Шилжүүлэг дууссан тухай гэрчилгээ тус бүр үйлдэгдсэн, Хамтын гэрээ байгуулагдсан байх.

16.3.9 Засал, шинэчлэлт

Нисэх буудлын аюулгүй байдалд шаардлагатай Концессын зүйлийн засал, шинэчлэлтийн ажил дууссан байх.

16.4 Эрх бүхий этгээдийн урьдчилсан нөхцөл


Эрх бүхий этгээд нь дор дурдсан Эрх бүхий этгээдийн урьдчилсан нөхцөлүүд-ийг хангана. Үүнд:

16.4.1 Нисэх буудлын талбай

- (1) Нисэх буудлын талбайн газрыг Зам, тээврийн хөгжлийн яамнаас удирдлага хэрэгжүүлэх улсын тусгай хэрэгцээний газар гэж тогтоосон байх.
- (2) Аливаа этгээд (энэхүү Гэрээний 9.6.3 дах хэсэг (Өрсөлдөх нисэх буудал болон арилжааны боломжуудыг хязгаарлах)-т заасны дагуу Концессын зүйлийг ашиглах зөвшөөрөл авсан Төрийн эрх бүхий байгууллагаас бусад) Концесс эзэмшигчийн урьдчилан бичгээр олгосон зөвшөөрөлгүйгээр Концессын талбайг бүхэлд нь эсхүл хэсэгчлэн эзэмшилдээ аваагүй байх.

16.4.2 Барилга

- (1) Концесс эзэмшигчийн зүгээс Нисэх буудлын бизнесийн үйл ажиллагаа болон Нисэх буудлын үйлчилгээг эхлүүлэхэд шаардлагатай Концессын зүйл, эрчим хүчний нөөц хангамж, шатахуун хангамжийн байгууламж, туслах зам, ангарын барилга болон катерингийн барилга зэргийг барьж байгуулахтай холбоотой ажлууд болон Барилгын ажил гүйцэтгэх гэрээнд заасан Засварын ажлыг хийж дууссан байх.
- (2) Улсын мэргэжлийн хяналтын комиссоос хяналт, шалгалтаар баталгаажуулж, Концессын зүйлийг үйл



ажиллагаанд ашиглах эрх олгосон Үйл ажиллагаа
эхлүүлэх гэрчилгээ гарсан байх.

16.4.3 Саналын баталгаа

Саналын баталгааг энэхүү Гэрээнд гарын үсэг зурмагц
Консерциумд нэн даруй буцаан өгсөн байна.

16.4.4 Концессын зүйл болон ажилтан шилжүүлэх

- (1) ЧХОУНБ эсхүл Эрх бүхий этгээдээс Концессын зүйлийг Шилжилтийн төлөвлөгөөний дагуу Концесс эзэмшигчид шилжүүлж дууссан байх.
- (2) ЧХОУНБ эсхүл Эрх бүхий этгээдээс Шилжүүлсэн ажилтнуудыг Шилжилтийн төлөвлөгөөний дагуу Концесс эзэмшигчид шилжүүлж дууссан байх.

16.4.5 Арилжааны нислэг болон үйлчилгээг шилжүүлэх

- (1) Арилжааны бүх нислэгийг ЧХОУНБ-аас УБХОУНОШБ-д шилжүүлсэн байх;
- (2) Холбогдох Төрийн эрх бүхий байгууллагаас ЧХОУНБ-ын үйл ажиллагааг УБХОУНОШБ руу шилжүүлж буй талаар Агаарын навигацийн мэдээллийн товхимол (ОУАТХ-оос тодорхойлсон)-д нийтэлсэн (энэхүү Гэрээний 16.2.10 дах хэсэг (Нисэх буудлын үйл ажиллагааг эхлүүлэх бэлтгэл үе шатан дах Эрх бүхий этгээдийн хүлээх үүрэг)-т заасны дагуу) байх;
- (3) Холбогдох Төрийн эрх бүхий байгууллагаас Зохицуулалттай төлбөр, хураамжийн анхны хувь хэмжээний талаар Агаарын тээвэрлэгчдэд мэдэгдсэн байх;
- (4) Дор дурдсан чиг үүргийг УБХОУНОШБ-д хэрэгжүүлэхтэй холбоотой бүх ажилтнууд, шаардлагатай тоног төхөөрөмжийг УБХОУНОШБ-руу шилжүүлж дууссан байх. Үүнд:
 - (i) гааль;
 - (ii) гадаадын иргэн, харьяат;
 - (iii) хорио цээр/улсын мэргэжлийн хяналт;

- (iv) хил хамгаалалт;
- (v) нислэгийн хөдөлгөөний удирдлага;
- (vi) харилцаа холбоо, навигацийн үйлчилгээ;
- (vii) цаг уурын үйлчилгээ;
- (viii) агаарын навигацийн мэдээллийн үйлчилгээ; болон
- (ix) нисэх буудлын цагдаа.

16.4.6 Гэрээгээр газар ашиглуулах эрхийн тухай гэрээ

Холбогдох Төрийн эрх бүхий байгууллага(ууд):

- (1) Энэхүү гэрээний Хавсралт 3 (Нисэх буудлын талбайн зураг)-ын 2 дугаар хэсэгт заасан Нисэх буудлын талбайн зурагт харуулсан Концессын талбайг бүхэлд нь ашиглах эрх бүхий байх; болон
- (2) Холбогдох Төрийн эрх бүхий байгууллагаас уг Концессын талбайтай холбоотойгоор Гэрээгээр газар ашиглуулах эрхийн тухай гэрээ байгуулсан байх;

16.4.7 Шилжилт

Шилжилтийн төлөвлөгөөний дагуу Шилжүүлэг дууссан тухай гэрчилгээ тус бүр үйлдэгдсэн, Хамтын гэрээ байгуулагдсан байх.

16.4.8 Монгол Улсын Иргэний нисэхийн дүрэм

Монгол Улсын Иргэний нисэхийн дүрэм (үүнд Төлбөр, хураамжтай холбоотой дүрэм хамаарна)-ийг Хууль зүй, дотоод хэргийн яаманд бүртгүүлсэн байх.

17. ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭХЛЭХ ӨДРИЙГ СУНГАХ, НӨХӨН ТӨЛБӨР ТӨЛӨХ, ХОЙШЛУУЛСНЫ УЛМААС ГЭРЭЭ ЦУЦЛАХ

17.1 Хойшлуулах нөхцөлийн тухай мэдэгдэл

- 17.1.1 Гэрээний аль нэг тал нь (i) Давагдашгүй хүчин зүйлийн нөлөөгөөр эсхүл (ii) тухайн талд хамаарах Урьдчилсан нөхцөлийг хангаж чадаагүйгээс Хойшлуулах нөхцөл үүснэ гэж таамаглаж байгаа бол тухайн тал (цаашид **“Хойшлуулж буй тал”** гэх) нь нөгөө талдаа Хойшлуулах нөхцөлийн талаар мэдэгдэх ба дараах мэдээллийг тусгасан байна. Үүнд:

- (1) Хойшлуулах нөхцөл бий болсон шалтгаан;
- (2) Хойшлуулах нөхцөлийн улмаас үүсэх эсхүл үүсч болзошгүй үр дагавар;
- (3) Хойшлуулах нөхцөлийн улмаас үүсэх нөлөөллийг бууруулах талаар авсан эсхүл авахаар санал болгож буй арга хэмжээ.

17.1.2 Хойшлуулж буй тал нь Хойшлуулах нөхцөлтэй холбоотой гарсан өөрчлөлтийн талаар нөгөө талдаа долоо хоногт нэгээс доошгүй удаа тогтмол мэдээлэх ба энэхүү мэдэгдэл нь дээрх 17.1.1 дэх хэсэг (Хойшлуулах нөхцөлийн тухай мэдэгдэл)-ийн (1)-ээс (3) дах зүйлд заасан мэдээллийг агуулсан байна.

17.2 Хойшлуулах нөхцөлийг бууруулах

Хойшлуулж буй тал нь Хойшлуулах нөхцөлийг даван гарах эсхүл түүнээс үүсэх үр дагаврыг бууруулах талаар бүхий л үндэслэл бүхий хичээл зүтгэл гаргана.

17.3 Давагдашгүй хүчин зүйл эсхүл доголдол арилгах ажлын улмаас бий болсон Хойшлуулах нөхцөлд хугацаа сунгах

Аливаа Хойшлуулах нөхцөл нь:

17.3.1 Давагдашгүй хүчин зүйл; эсхүл

17.3.2 энэхүү Гэрээний 21.1.4 (4) дэх дэд хэсэг (Концессын зүйлийг шилжүүлэх)-т заасны дауу Концесс эзэмшигчийн зүгээс доголдол арилгах ажил гүйцэтгэсэнтэй холбоотойгоор бий болсон бол

Үйл ажиллагаа эхлэх төлөвлөгөөт өдөр болон Урт хугацаат зогсолтын өдрийг тухайн Давагдашгүй хүчин зүйл эсхүл доголдол арилгах ажлын улмаас үүссэн тасалдлын хугацаанаас багагүй хугацаагаар сунгах бөгөөд ийнхүү хугацаа сунгасан нь бусад Концессын зүйлийг энэхүү Гэрээний 21.1.4 дэх хэсэг (Концессын зүйлийг шилжүүлэх)-т заасан журмын дагуу хүлээн авахад нөлөөлөхгүй.

17.4 Эрх бүхий этгээдийн хойшлуулах нөхцөлийн нөхөн төлбөр

Эрх бүхий этгээдийн зүгээс Эрх бүхий этгээдийн урьдчилсан нөхцөлийг Үйл ажиллагаа эхлэх төлөвлөгөөт өдөр (Давагдашгүй хүчин зүйлийн улмаас хугацаа сунгаснаар)-ийн байдлаар биелүүлээгүй эсхүл Төрийн эрх бүхий байгууллага болон ЧХОУНБ-ын зүгээс биелүүлэх асуудлыг хангаж чадаагүйн улмаас Эрх бүхий этгээд Хойшлуулж буй тал байх

тохиолдолд Концесс эзэмшигч нь Үйл ажиллагаа эхлэх төлөвлөгөөт өдрөөс (i) Үйл ажиллагаа эхлэх өдөр эсхүл (ii) Гэрээ цуцлагдах өдрийн аль эхэнд тохиолдсон өдөр хүртэл хугацаанд хамаарах, Хойшлуулах нөхцөлөөс үүдэн учирсан:

17.4.1 Концессын зүйл (Шилжилтийн төлөвлөгөөний дагуу Концесс эзэмшигчид шилжүүлсэн) болон Концесс эзэмшигчийн хөрөнгөөр бий болсон эд хөрөнгийн засвар үйлчилгээний зардал; болон

17.4.2 ажилтнуудын зардал

-ыг Эрх бүхий этгээдээс нэхэмжлэх эрхтэй (**"Эрх бүхий этгээдийн хойшлуулах нөхцөлийн зардал"**) ба ингэхдээ Концесс эзэмшигч нь дээрх зардлыг бууруулах талаар бүх талын арга хэмжээ авсан байх ба энэ талаар холбогдох нотлох баримтыг хүргүүлнэ.

17.5 Концесс эзэмшигчийн хойшлуулах нөхцөлийн нөхөн төлбөр.

Концесс эзэмшигч нь Концесс эзэмшигчийн урьдчилсан нөхцөлийг Үйл ажиллагаа эхлэх төлөвлөгөөт өдөр (Давагдашгүй хүчин зүйл эсвэл засварын ажлын улмаас хугацаа сунгаснаар)-ийн байдлаар хангаж чадаагүйн улмаас Концесс эзэмшигч Хойшлуулж буй тал байх тохиолдолд Эрх бүхий этгээд нь Үйл ажиллагаа эхлэх төлөвлөгөөт өдрөөс (i) Үйл ажиллагаа эхлэх өдөр эсхүл (ii) Гэрээ цуцлагдах өдрийн аль эхэнд тохиолдсон өдөр хүртэл хугацаанд хамаарах, Хойшлуулах нөхцөлөөс үүдэн учирсан:

17.5.1 Дор дурдсан зүйлсийн засвар үйлчилгээний зардал:

- (1) Эрх бүхий этгээд засвар үйлчилгээг нь хариуцах зүйл; болон
- (2) энэхүү Гэрээний Хавсралт 4 (Удирдлага, зохион байгуулалтын нарийвчилсан хуваарь)-т засвар үйлчилгээг хариуцах гэсэн мөрөнд Концесс эзэмшигч гэж тэмдэглэсэн боловч Хойшлуулах нөхцөлийн улмаас Шилжилтийн төлөвлөгөөний дагуу Концесс эзэмшигчид шилжүүлээгүй байгаа Концессын зүйл.

17.5.2 ажилтнуудын зардал

-ыг Концесс эзэмшигчээс нэхэмжлэх эрхтэй (**"Концесс эзэмшигчийн хойшлуулах нөхцөлийн зардал"**) ба ингэхдээ Эрх бүхий этгээд нь дээрх зардлыг бууруулах талаар бүх талын арга хэмжээ авсан байх ба энэ талаар холбогдох нотлох баримтыг хүргүүлнэ.

17.6 Хойшлуулах нөхцөлийн улмаас гэрээ цуцлах

17.6.1 Үйл ажиллагаа эхлэх өдөр Хойшлуулах нөхцөлийн улмаас Урт хугацаат зогсолтын өдрийн дараагийн өдөр тохиогоогүй бол аль ч Тал нь энэхүү Гэрээг цуцлах эрхтэй. Ийнхүү Талуудын аль нэг нь энэхүү 17.6.1 дэх хэсэг (Хойшлуулах нөхцөлийн улмаас гэрээ цуцлах)-т заасны дагуу Гэрээг цуцлах тохиолдолд тэд 17.6.2, 17.6.3 дах хэсгүүд (Хойшлуулах нөхцөлийн улмаас гэрээ цуцлах) болон 51 дүгээр зүйл (Нууцлал)-д зааснаас бусад энэхүү Гэрээний дагуу хүлээсэн аливаа бүх үүргээсээ чөлөөлөгдөнө.

17.6.2 Эрх бүхий этгээд нь Хойшлуулж буй тал бөгөөд энэхүү Гэрээний 17.6.1 дэх хэсэг (Хойшлуулах нөхцөлийн улмаас гэрээ цуцлах)-т заасны дагуу Гэрээг цуцлах тохиолдолд Эрх бүхий этгээд нь Концесс эзэмшигчийн аудитаар баталгаажсан Санхүүгийн тайланд үндэслэн дараах төлбөрийг Концесс эзэмшигчид төлнө. Үүнд:

- (1) Үйл ажиллагаа эхлэх төлөвлөгөөт өдрийн байдлаар оруулсан Эхлэлтийн хөрөнгө оруулалт; үүнээс ХАСАХ НЬ
- (2) Үйл ажиллагаа эхлэх төлөвлөгөөт өдрийн байдлаар Концесс эзэмшигчийн банкны дансан дах бэлэн мөнгөний нийт үлдэгдэл; үүн дээр НЭМЭХ НЬ
- (3) Үйл ажиллагаа эхлэх төлөвлөгөөт өдрийн байдлаар энэхүү Гэрээний 17.6.2 (2) дах дэд хэсэг (Хойшлуулах нөхцөлийн улмаас гэрээ цуцлах)-т заасан Концесс эзэмшигчийн бэлэн мөнгөний балансын дүн хүртэлх хэмжээний үнийн дүн бүхий Концесс эзэмшигчийн гуравдагч этгээдэд төлбөл зохих дансны өглөгийн дүн; үүн дээр НЭМЭХ НЬ
- (4) Гэрээний 17.4 дэх хэсэг (Эрх бүхий этгээдийн хойшлуулах нөхцөлийн нөхөн төлбөр)-т заасан Эрх бүхий этгээдийн хойшлуулах нөхцөлийн зардал.

Дээрх тохиолдолд Концессын зүйл (Шилжилтийн төлөвлөгөөний дагуу Концесс эзэмшигчид шилжүүлэн өгсөн) болон Концесс эзэмшигчийн хөрөнгөөр бий болсон эд хөрөнгийг Эрх бүхий этгээдэд үнэ төлбөргүй шилжүүлнэ.

17.6.3 Концесс эзэмшигч нь Хойшлуулж буй тал бөгөөд энэхүү Гэрээний 17.6.1 дэх хэсэг (Хойшлуулах нөхцөлийн улмаас гэрээ цуцлах)-т заасны дагуу Гэрээг цуцлах тохиолдолд Концесс эзэмшигч нь дараах төлбөрийг Эрх бүхий этгээдэд төлнө. Үүнд:

- (1) Гэрээний 17.5 дах хэсэг (Концесс эзэмшигчийн хойшлуулах нөхцөлийн нөхөн төлбөр)-т заасны дагуу Концесс эзэмшигчийн хойшлуулах нөхцөлийн зардал; үүн дээр НЭМЭХ НЬ
- (2) Концесс эзэмшигчийг сольж томилохтой холбоотойгоор Эрх бүхий этгээдэд учирсан нэг (1) сая америк доллараас ихгүй зардал.

Дээрх тохиолдолд Концессын зүйл (Шилжилтийн төлөвлөгөөний дагуу Концесс эзэмшигчид шилжүүлэн өгсөн)-ийг Эрх бүхий этгээдэд үнэ төлбөргүй шилжүүлэх бөгөөд харин Концесс эзэмшигчийн хөрөнгөөр бий болсон эд хөрөнгийг худалдан авсан буюу бий болгосон үнийн тал үнээр тооцож Эрх бүхий этгээдэд шилжүүлнэ.

18. НИСЭХ БУУДЛЫН ЗОХИЦУУЛАХ ХОРОО

18.1 Нисэх буудлын зохицуулах хороо байгуулах

- 18.1.1 Талууд Нисэх буудлын үйл ажиллагаатай холбоотой үүсэн гарах аливаа асуудлыг харгалзан үзэх, түүнийг шийдвэрлэхэд Эрх бүхий этгээд болон Концесс эзэмшигчийн төлөөлөгчдөд зөвлөх, дэмжлэг үзүүлэх Нисэх буудлын зохицуулах хороог байгуулна.
- 18.1.2 Нисэх буудлын зохицуулах хороо нь энэхүү Гэрээний аливаа нөхцөлийг өөрчлөх, өөр бусад байдлаар хамтарсан арга хэмжээ авах, гишүүд, оролцогчиддоо үүрэг хүлээлгэх эрхгүй байна.
- 18.1.3 Нисэх буудлын зохицуулах хороо нь зөвхөн зөвлөх шинжтэй байгууллага байх бөгөөд Талуудын төлөөлөл болох хорооны гишүүд нь төлөөлүүлж буй талдаа үүрэг бий болгох эрхгүй болохыг Талууд ойлгож, хүлээн зөвшөөрсөн болно.

18.2 Нисэх буудлын зохицуулах хорооны гишүүд

- 18.2.1 Нисэх буудлын зохицуулах хороо нь дараах гишүүдээс бүрдэнэ. Үүнд:
 - (1) Эрх бүхий этгээдийн томилсон хоёр (2) гишүүн (нэг гишүүн нь ЗТХЯ-аас нэр дэвшсэн байна);
 - (2) Концесс эзэмшигчийн томилсон хоёр (2) хүртэлх тооны гишүүн.
- 18.2.2 Талуудын аль нь ч шинээр томилогдож байгаа гишүүний тухай дэлгэрэнгүй мэдээлэл агуулсан мэдэгдлийг нөгөө талдаа

бичгээр хүргүүлэх замаар Нисэх буудлын зохицуулах хорооны аль ч гишүүнийг сольж болно.

- 18.2.3 Эрх бүхий этгээд нь энэхүү Гэрээний 18.2.1 дэх хэсэг (Нисэх буудлын зохицуулах хорооны гишүүд)-т заасны дагуу Нисэх буудлын зохицуулах хорооны нэг (1) гишүүнийг ЗТХЯ-аас томилох асуудлыг ханган ажиллана. ЗТХЯ өөрийн томилсон Нисэх буудлын зохицуулах хорооны гишүүнийг сольж болох бөгөөд ийнхүү солихдоо шинээр томилох гишүүний тухай дэлгэрэнгүй мэдээлэл агуулсан мэдэгдлийг Талуудад бичгээр хүргүүлэх асуудлыг Эрх бүхий этгээд ханган ажиллана.

18.3 Нисэх буудлын зохицуулах хорооны хурал

- 18.3.1 Хурал ойролцоогоор хоёр (2) сар тутамд УБХОУНОШБ-д эсхүл Нисэх буудлын зохицуулах хорооноос хуралдахаар шийдвэрлэсэн Монгол Улсад байрлах өөр бусад газарт зохион байгуулагдаж болно. Хойшлуулшгүй шаардлагатай асуудал гарсан тохиолдолд Нисэх буудлын зохицуулах хорооны аль ч гишүүн хэдийд ч нэмэлт хурал зарлаж болно.
- 18.3.2 Концесс эзэмшигч нь хурлын тов тогтоох, хурлаар хэлэлцэх асуудлын жагсаалт хүргүүлэх болон хурлын тэмдэглэл хөтлөх үүрэг хүлээнэ. Хурлаар хэлэлцэх асуудлын нарийвчилсан жагсаалтыг холбогдох бичиг баримтын хамт Нисэх буудлын зохицуулах хорооны гишүүдэд хурал товлогдсон өдрөөс хамгийн багадаа гурав (3)-аас доошгүй Ажлын өдрийн өмнө хүргүүлсэн байна.
- 18.3.3 Нисэх буудлын зохицуулах хорооны хурлын тэмдэглэлийг Эрх бүхий этгээд, ИНЕГ болон Концесс эзэмшигч (үүнд Концесс эзэмшигчийн төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүд хамаарна)-д нээлттэй байлгана.

18.4 Нисэх буудлын зохицуулах хорооны үйл ажиллагаа

- 18.4.1 Нисэх буудлын зохицуулах хороо нь дор дурдсан асуудлыг хэлэлцэнэ. Үүнд:
- (1) Шилжүүлэх комисстой уялдуулан харилцах зэргээр Шилжилтийн төлөвлөгөөний биелэлт;
 - (2) аливаа Сайжруулах саналыг багтаагаад Санхүүгийн төлөвлөгөө болон түүний нэмэлт, өөрчлөлтийн хэрэгжилт;
 - (3) Санхүүгийн тайлан;

- (4) хамгийн сүүлийн ҮАЗҮ-ний тайлан (үүнд Эрх бүхий этгээдийн чиг үүрэг болон Нисэх буудлын үйлчилгээний харилцан уялдаа холбооны талаарх асуудлууд багтана);
- (5) Эрх бүхий этгээдийн чиг үүрэг, Концесс эзэмшигчийн чиг үүрэг болон Нисэх буудлын үйлчилгээтэй холбоотой тодорхой бус байдал;
- (6) Нисэх буудлын хэрэглэгч болон олон нийтийн харилцаа.

18.5 Хамтын ажиллагаа

18.5.1 Эрх бүхий этгээд болон Концесс эзэмшигч нь энэ Гэрээнд заасан тус тусын үүргээ гүйцэтгэхдээ ямар ч үед бие биетэйгээ үнэнч шударгаар ажиллах зарчмыг баримтална.

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ. САЙЖРУУЛАХ САНАЛ

19. НИСЭХ БУУДЛЫН МАСТЕР ТӨЛӨВЛӨГӨӨ

- 19.1 Концесс эзэмшигч нь Үйл ажиллагаа эхлэх өдрөөс хойш хоёр (2) жилийн дотор Концессын хугацааг бүхэлд нь хамарсан Нисэх буудлын Мастер төлөвлөгөөг боловсруулж, Эрх бүхий этгээд болон/эсхүл ИНЕГ-т хүргүүлнэ.
- 19.2 Концесс эзэмшигч нь Мастер төлөвлөгөөг хамгийн багадаа гурван (3) жилд нэг удаа, шаардлагатай гэж үзвэл тухай бүр шинэчилж байх ба тийнхүү шинэчилсэн Нисэх буудлын Мастер төлөвлөгөөг Эрх бүхий этгээд болон Иргэний нисэхийн ерөнхий газарт хүргүүлнэ.

20. САЙЖРУУЛАХ САНАЛ

20.1 Концессыг сайжруулах санал

20.1.1 Нисэх буудлын Мастер төлөвлөгөө, Санхүүгийн төлөвлөгөө, энэхүү Гэрээний Хавсралт 4 (Удирдлага, зохион байгуулалтын нарийвчилсан хуваарь) болон УБХОУНОШБ-ын тухайн үеийн нөхцөл, байдлыг харгалзан аль ч Тал нь Нисэх буудлын бизнесийг сайжруулах зорилгоор Концессын зүйлийг болон/эсхүл Концессын талбайг хөгжүүлэх, сайжруулах, өргөтгөх тухай Концессыг сайжруулах санал гаргаж болно.

20.1.2 Санал гаргаж буй тал нь Концессыг сайжруулах саналд дараах зүйлсийг тусгана. Үүнд:

- (1) Концессыг сайжруулах санал гаргах болсон үндэслэл, шалтгаан;

- (2) Концессыг сайжруулах саналыг хэрэгжүүлснээр гарахаар хүлээгдэж буй үр дүн;
- (3) Концессыг сайжруулах саналыг хэрэгжүүлэх төлөвлөгөө болон төлөвлөсөн арга хэмжээ;
- (4) Концессыг сайжруулах саналыг санхүүжүүлэх эх үүсвэр;
- (5) Шаардлагатай Концесс эзэмшигчийн авах зөвшөөрлүүд болон Төрийн эрх бүхий байгууллагын авах зөвшөөрлүүд;
- (6) Концессын сайжруулах саналыг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө, зохион байгуулалт;
- (7) Концессыг сайжруулах саналыг хэрэгжүүлсний үр дүнд бий болсон шинэ эд хөрөнгийг бүртгүүлэхтэй холбоотой төлөвлөгөө;
- (8) Концессыг сайжруулах саналын нэг хэсэг байдлаар шинээр баригдах барилга байгууламжийн талаарх мэдээлэл, үүнд Концесс эзэмшигч нь тухайн барилга, байгууламжийн (1) үйл ажиллагаа, засвар үйлчилгээг хариуцах, (2) зөвхөн засвар үйлчилгээг хариуцах (үйл ажиллагаа явуулахгүйгээр), (3) үйл ажиллагаа, засвар үйлчилгээний алийг ч хариуцаж гүйцэтгэхгүй байх, (4) дамжуулан түрээслэх эрхтэй байх эсэх болон/эсхүл (5) төлбөр, хураамж авах эрхтэй байх эсэх талаарх санал зэрэг багтана;
- (9) Концессыг сайжруулах саналын үр дүнд Концесс эзэмшигчийн хөрөнгөөр бий болсон эд хөрөнгө бий болох эсэх талаар мэдээлэл.

20.1.3 Талууд зөвхөн харилцан тохиролцож, бичгээр үйлдсэнээр энэхүү Гэрээний салшгүй хэсэг болох нэмэлт гэрээний үндсэн дээр Концессыг Сайжруулах саналыг баталж, хэрэгжүүлнэ. Концессыг Сайжруулах санал нь Талуудын энэхүү Гэрээний дагуу эдлэх бүхий л эрх, давуу эрхийг хөндөхгүй, аливаа Хууль тогтоомжийг зөрчихгүй, Нисэх буудлын бизнесийн санхүүгийн нөхцөл байдал болон УБХОУНОШБ-ын үйл ажиллагааны аюулгүй байдалд сөрөг нөлөө үзүүлэхгүй байх тохиолдолд түүнийг баталж, хэрэгжүүлнэ.

20.1.4 Концесс эзэмшигч Концессыг сайжруулах санал хэрэгжүүлэх

Эрх бүхий этгээд нь Концесс эзэмшигчийн зүгээс Концессыг сайжруулах санал хэрэгжүүлэхтэй холбоотой бүхий л үндэслэл бүхий дэмжлэгийг холбогдох Хууль тогтоомжийн дагуу үзүүлэх ба үүнд дараах асуудал хамаарна. Үүнд:

- (1) Холбогдох төлөвлөгөөнүүдэд нэмэлт, өөрчлөлт оруулах;
- (2) Төрийн эрх бүхий байгууллагын авах шаардлагатай зөвшөөрлүүдийг авах;
- (3) Концесс эзэмшигчийн авах зөвшөөрлүүдийг Иргэний нисэхийн ерөнхий газар болон аливаа бусад Төрийн эрх бүхий байгууллагаас олгох асуудлыг хариуцах;
- (4) Концессын хугацаа дуусах хүртэл Нисэх буудлын талбайн холбогдох хэсэгт нэвтрэн орох эрх олгох буюу эрх олгуулах асуудлыг хариуцах;
- (5) Нисэх буудлын хэрэглэгчидтэй харилцах, хамтран ажиллах; болон
- (6) Концессыг сайжруулах саналыг санхүүжүүлэх.

20.1.5 Эрх бүхий этгээд Концессыг сайжруулах санал хэрэгжүүлэх

Концесс эзэмшигч нь Эрх бүхий этгээдийн зүгээс Концессыг сайжруулах санал хэрэгжүүлэхтэй холбоотой бүхий л үндэслэл бүхий дэмжлэгийг холбогдох Хууль тогтоомжийн дагуу үзүүлэх ба үүнд дараах асуудал хамаарна. Үүнд:

- (1) Холбогдох төлөвлөгөөнүүдэд нэмэлт, өөрчлөлт оруулах;
- (2) Шаардлагатай баримт бичгээр хангах;
- (3) Концессын хугацаа дуусах хүртэл Концессын талбай болон Концессын зүйлийн холбогдох хэсэгт нэвтрэн орох, түүнийг ашиглахад шаардлагатай эрх олгох, эрх олгуулах асуудлыг хариуцах; болон
- (4) Нисэх буудлын хэрэглэгчидтэй харилцах, хамтран ажиллах.



20.2 Нисэх буудлыг хөгжүүлэх санал

- 20.2.1 Концесс эзэмшигч нь Нисэх буудлын Мастер төлөвлөгөө, Санхүүгийн төлөвлөгөө болон УБХОУНОШБ-ын тухайн үеийн нөхцөл байдлыг харгалзан Нисэх буудлын бизнесийг сайжруулах зорилгоор Нисэх буудлыг хөгжүүлэх бүсийг хөгжүүлэх, сайжруулах, өргөтгөх талаар санал гаргаж болно (**"Нисэх буудлыг хөгжүүлэх санал"**).
- 20.2.2 Энэхүү Гэрээний 20.1 дэх хэсэг (Концессыг сайжруулах санал)-ийн заалтууд Нисэх буудлыг хөгжүүлэх бүсийн саналд нэгэн адил үйлчилнэ.

20.3 Гуравдагч этгээдийн нисэх буудлыг хөгжүүлэх санал

- 20.3.1 Аливаа гуравдагч этгээдийн зүгээс Эрх бүхий этгээдэд Нисэх буудлын хөгжүүлэх бүсийг хөгжүүлэх, сайжруулах, өргөтгөх тухай Гуравдагч этгээдийн нисэх буудлыг хөгжүүлэх санал (**"Гуравдагч этгээдийн нисэх буудлыг хөгжүүлэх санал"** гэх) гаргасан бол Эрх бүхий этгээд уг саналын талаарх дэлгэрэнгүй мэдээллийг Концесс эзэмшигчид аль болох боломжит богино хугацаанд мэдэгдэх бөгөөд тэрхүү мэдэгдэл нь энэ Гэрээний 20.1.2 дэх хэсэг (Концессыг сайжруулах санал)-т заасан мэдээллийг агуулсан байна.
- 20.3.2 Дээрх тохиолдолд Концесс эзэмшигч нь дараах эрхтэй байна. Үүнд:
- (1) Энэхүү Гэрээний 20.3.1 дэх хэсэг (Гуравдагч этгээдийн нисэх буудлыг хөгжүүлэх санал)-т заасан мэдэгдлийг хүлээн авснаас хойш нэг (1) сарын дотор Концесс эзэмшигчийн хариу санал гаргах талаар хүсэл зоригоо илэрхийлэх;
 - (2) Энэхүү Гэрээний 20.3.1 дэх хэсэг (Гуравдагч этгээдийн нисэх буудлыг хөгжүүлэх санал)-т заасан мэдэгдлийг хүлээн авснаас хойш гурван (3) сар (эсвэл Талуудын харилцан тохиролцсон хугацаа)-ын дотор Концесс эзэмшигчийн зүгээс Гуравдагч этгээдийн нисэх буудлыг хөгжүүлэх саналыг хэрэгжүүлэх талаар Концесс эзэмшигчийн хариу саналыг Эрх бүхий этгээдэд хүргүүлнэ. Концесс эзэмшигч нь Концесс эзэмшигчийн хариу саналыг гурван (3) сарын дотор хүргүүлэх боломжгүй байх тохиолдолд бол уг хугацаа дуусахаас өмнө хугацаа хожимдуулах болсон талаар үндэслэлээ

тайлбарласны үндсэн дээр Талууд уг хугацааг сунгаж болно.

20.3.3 Эрх бүхий этгээд нь Концесс эзэмшигчийн хариу саналыг хүлээн авснаас хойш хоёр (2) сарын хугацаанд Концесс эзэмшигчийн хариу саналыг хэрэгжүүлэх зорилгоор Концесс эзэмшигчтэй гэрээ байгуулах асуудлаар гагцхүү түүнтэй тусгайлан, үнэнч шударгаар хэлэлцээр хийнэ.

20.3.4 Гэрээний 20.1.4 дэх хэсэг (Концесс эзэмшигч Концессыг сайжруулах санал хэрэгжүүлэх) болон 20.1.5 дах хэсэг (Эрх бүхий этгээд Концессыг сайжруулах санал хэрэгжүүлэх)-ийн заалтууд Концесс эзэмшигчийн хариу санал болон түүнийг хэрэгжүүлэхэд нэгэн адил үйлчилнэ.

20.3.5 Концесс эзэмшигч нь энэхүү Гэрээний 20.3.2 дах хэсэг (Гуравдагч этгээдийн нисэх буудлыг хөгжүүлэх санал)-т заасан хугацаанд хүсэл зоригоо илэрхийлээгүй эсхүл Концесс эзэмшигчийн хариу санал ирүүлээгүй, эсхүл Талууд энэхүү Гэрээний 20.3.3 дах хэсэг (Гуравдагч этгээдийн нисэх буудлыг хөгжүүлэх санал)-т заасан хоёр (2) сарын хугацаанд Концесс эзэмшигчийн хариу саналыг хэрэгжүүлэх талаар тохиролцоонд хүрч чадаагүй бол дор дурдсан нөхцөл хангагдсан тохиолдолд Эрх бүхий этгээд нь гуравдагч этгээдэд Гуравдагч этгээдийн нисэх буудлыг хөгжүүлэх саналыг хэрэгжүүлэхийг зөвшөөрч болно. Үүнд:

- (1) уг санал нь Талуудын энэхүү Гэрээний дагуу эдлэх эрх, давуу эрхийг хөндөөгүй;
- (2) уг санал нь аливаа Хууль тогтоомж зөрчөөгүй; эсхүл
- (3) уг санал нь Нисэх буудлын бизнесийн санхүүгийн нөхцөл байдал болон УБХОУНОШБ-ын аюулгүй ажиллагаанд сөргөөр нөлөөлөх үндэслэл бүхий магадлал илрээгүй байх.

20.4 Талууд энэхүү Гэрээний 20.1.3 дах хэсэг (Концессыг сайжруулах санал)-т заасан гэрээнд өөрөөр тохиролцооүй бол Концесс эзэмшигч нь Сайжруулах саналын үр дүнд бий болсон эд хөрөнгийг Эрх бүхий этгээдэд үнэ төлбөргүй шилжүүлнэ.

ТАВДУГААР БҮЛЭГ. ҮЙЛ АЖИЛЛАГАА БА ЗАСВАР ҮЙЛЧИЛГЭЭ

21. КОНЦЕССЫН ЗҮЙЛИЙГ ШИЛЖҮҮЛЭХ

21.1 Концессын зүйлийг шилжүүлэх

21.1.1 Гэрээ хүчин төгөлдөр болмогц Эрх бүхий этгээд болон Концесс эзэмшигч нь Концессын зүйлийг Концесс эзэмшигчид шилжүүлэх ажлыг хариуцан зохион байгуулах Шилжүүлэх комисс томилно. Шилжүүлэх комисс нь Шилжилтийн төлөвлөгөөний дагуу үйл ажиллагаа явуулна.

21.1.2 Концесс эзэмшигч нь Шилжилтийн төлөвлөгөөнд заасан хуваарийн дагуу, дор заасан дарааллаар Концессын зүйлийг хүлээн авна. Үүнд:

- (1) Терминал, түүнд хамаарах байгууламжууд болон Газрын үйлчилгээний тоног төхөөрөмж;
- (2) Аэродром, түүнд хамаарах байгууламжууд; болон
- (3) Нийтлэг үйлчилгээний хангамжийн байгууламжууд.

21.1.3 Энэхүү Гэрээний 21.1.2 дах хэсэг (Концессын зүйлийг шилжүүлэх)-т заасны дагуу холбогдох Концессын зүйлийг шилжүүлэх үед Концессын зүйлийн хэвийн нөхцөлд бүрэн ажиллагаатай байх асуудлыг Эрх бүхий этгээд хариуцна.

21.1.4 Гэрээний 21.1.2 дах хэсэг (Концессын зүйлийг шилжүүлэх)-т заасны дагуу Терминал, түүнд хамаарах байгууламжууд, Газрын үйлчилгээний тоног төхөөрөмж, Аэродром, түүнд хамаарах байгууламжууд болон Нийтлэг үйлчилгээний хангамжийн байгууламжуудыг шилжүүлэх үед энэхүү Гэрээний 21.1.4 дэх хэсэгт заасан журмыг баримтална. Үүнд:

- (1) Шилжилтийн төлөвлөгөөний дагуу Терминал, түүнд хамаарах байгууламжууд болон Газрын үйлчилгээний тоног төхөөрөмжийг шилжүүлэхээр төлөвлөсөн өдрөөс нэг (1) сараас доошгүй хугацааны өмнө, бусад Концессын зүйлийг шилжүүлэхээр төлөвлөсөн өдрөөс гурван (3) сарын өмнө Шилжүүлэх комисс нь (i) энэхүү Гэрээний 21.1.3 дах хэсэг (Концессын зүйлийг шилжүүлэх)-т заасан шаардлагад нийцүүлэн шилжүүлэх Концессын зүйл тус бүрийн ажиллагааны байдал болон засварыг тодорхойлох зорилгоор хяналт шалгалт хийж (ii) доголдлыг илрүүлнэ.

- (2) Шилжүүлэх комисс Шилжүүлэг дууссан тухай гэрчилгээ үйлдэхээс өмнө энэхүү Гэрээний 21.1.4 (1) дэх дэд хэсэг (Концессын зүйлийг шилжүүлэх)-т заасны дагуу доголдол илрүүлсэн тохиолдолд:
- (i) Эрх бүхий этгээд шилжүүлэхээр төлөвлөсөн өдрөөс өмнө тухайн доголдыг өөрийн зардлаар арилгана;
 - (ii) Эрх бүхий этгээд гэрээт гүйцэтгэгч томилох зэргээр тухайн доголдлыг арилгах арга, хэлбэрийг тодорхойлно;
 - (iii) Хэрэв (А) Шилжилтийн төлөвлөгөөнд заасны дагуу шилжүүлэхээр төлөвлөсөн өдрийн байдлаар доголдол арилгах ажиллагаа дуусаагүй (ялимгүй доголдол үүнд хамаарахгүй) ба уг доголдол арилгах ажиллагаа нь Нисэх буудлын үйл ажиллагааг эхлүүлэх бэлтгэл үе шатан дах Концесс эзэмшигчийн үүргийн гүйцэтгэлд сөрөг нөлөө үзүүлэхүйц (ялимгүй доголдол үүнд хамаарахгүй) бөгөөд (Б) тэрхүү хойшлуулсан шилжүүлэг буюу хэрэгжилт нь Хойшлуулах нөхцөл бий болгосон бол энэхүү гэрээний 17 дугаар зүйл (Үйл ажиллагаа эхлэх өдрийг сунгах, нөхөн төлбөр төлөх, хойшлуулсны улмаас гэрээ цуцлах)-ийн заалтууд үйлчилж, Эрх бүхий этгээд Хойшлуулж буй талд тооцогдоно.
- (3) Энэхүү Гэрээний 21.1.4 (2) дах дэд хэсэг (Концессын зүйлийг шилжүүлэх)-т заасны дагуу доголдлыг арилгаж дууссаны дараа Талууд Терминал, түүнд хамаарах байгууламжууд, Газрын үйлчилгээний тоног төхөөрөмж, Аэродром, түүнд хамаарах байгууламжууд болон Нийтлэг үйлчилгээний хангамжийн байгууламжууд тус бүрийг шилжүүлж дууссаны дараа Шилжүүлэг дууссан тухай гэрчилгээг нэн даруй үйлдэнэ. Шилжүүлэг дууссан тухай гэрчилгээг үйлдсэнээр холбогдох Концессын зүйлтэй холбоотой эрсдэл, завсар үйлчилгээ, аюулгүй ажиллагаа, аюулгүй байдал болон холбогдох өртөг зардлууд Концесс эзэмшигчид шилжинэ (энэ Гэрээний 21.3 дах хэсэг (Доголдол арилгах баталгаат хугацаанд хамаарах Концессын зүйлийн доголдол)-т заасныг харгалзана).
- (4) Концесс эзэмшигч холбогдох Шилжүүлэг дууссан тухай гэрчилгээ үйлдсэний дараа Концессын зүйлд аливаа

доголдол илрүүлсэн бөгөөд уг доголдлыг арилгах нь Үйл ажиллагаа эхлэх өдрийг хойшлуулахаар байх тохиолдолд:

- (i) Концесс эзэмшигч нь тэдгээр Концессын зүйлд шаардлагатай аливаа засварын ажил, засвар, үйлчилгээ, аюулгүй байдал, аюулгүй ажиллагаа, эрсдэлийг хариуцах ба холбогдох зардлыг Концесс эзэмшигч хариуцна; мөн
- (ii) Үйл ажиллагаа эхлэх төлөвлөгөөт өдрийг засварын ажлыг гүйцэтгэхэд шаардлагатай хугацаагаар сунгана.

21.1.5 Энэхүү Гэрээний 21.1.2 болон 21.1.4 дэх хэсгүүд (Концессын зүйлийг шилжүүлэх)-ийн дагуу Нийтлэг үйлчилгээний хангамжийн байгууламжийг шилжүүлэхээс өмнө Эрх бүхий этгээд Концессын зүйлийг шаардлагатай нийтлэг үйлчилгээгээр хангах буюу бусад хэлбэрээр Нийтлэг үйлчилгээний хангамжийн байгууламжтай холбох асуудлыг хариуцах ба Концесс эзэмшигч өөрт нь шилжүүлсэн Концессын зүйлтэй холбогдон гарсан нийтлэг үйлчилгээний хангамжийн зардлыг төлнө.

21.2 Баригдсан байдлын зураг төсөл, заавар

21.2.1 Барилгын ажил гүйцэтгэх гэрээний дагуу Барилгын ажил гүйцэтгэгчийн бэлдэх шаардлагатай баримт, бичиг зэрэг Концессын зүйлтэй холбоотой бүхий л баригдсан байдлын зураг төсөл, үйл ажиллагаа болон засвар үйлчилгээний зааврын хувийг ИНЕГ-аас Концесс эзэмшигчид хүргүүлэх ажлыг Эрх бүхий этгээд хариуцаж, биелэлтийг хангана.

21.3 Доголдол арилгах баталгаат хугацаанд хамаарах Концессын зүйлийн доголдол

21.3.1 Шилжүүлэг дууссан тухай гэрчилгээ үйлдсэний дараа Концессын зүйлд аливаа доголдол илрүүлсэн ба уг доголдлын хувьд Барилгын ажил гүйцэтгэх гэрээнд заасан Доголдол арилгах баталгаат хугацаа дуусаагүй байх тохиолдолд Эрх бүхий этгээд Концесс эзэмшигчийн илрүүлсэн доголдлыг өөрийн зардлаар засварлана.

22. НИЙТЛЭГ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХАНГАМЖИЙН БАЙГУУЛАМЖИЙН АШИГЛАЛТ, ЗАСВАР ҮЙЛЧИЛГЭЭ

22.1 Нийтлэг үйлчилгээний хангамжийн байгууламжтай холбоотой Концесс эзэмшигчийн үүрэг

22.1.1 Концесс эзэмшигч нь Концессын зүйл болон Концесс эзэмшигчийн хөрөнгөөр бий болсон эд хөрөнгийн үйл ажиллагааг хэвийн явуулах нөхцөлийг хангах зорилгоор Концессын талбайд Концессын зүйл болон Концесс эзэмшигчийн хөрөнгөөр бий болсон эд хөрөнгийг дор дурдсан зүйлсээр хангах буюу түүнд холбоход шаардлагатай арга хэмжээг авч хэрэгжүүлэх үүрэгтэй. Үүнд:

- (1) гүний усны худаг, ус цэвэршүүлэх байгууламж болон ус дамжуулан түгээх сүлжээ;
- (2) бохир ус цэвэрлэх байгууламж;
- (3) цахилгаан эрчим хүч түгээх байгууламж;
- (4) шилэн кабелийн сүлжээ;
- (5) дулааны цахилгаан станц;
- (6) инженерийн дэд бүтцийн шугам, сүлжээ;
- (7) Бусад шаардлагатай байгууламж

(хамтад нь **“Нийтлэг үйлчилгээний хангамжийн байгууламж”**)

22.1.2 Энэхүү Гэрээний 22.2 дах хэсэг (Нийтлэг үйлчилгээний хангамжийн байгууламжтай холбоотой Эрх бүхий этгээдийн үүрэг)-т заасныг харгалзан, Концессын талбайг Нийтлэг үйлчилгээний хангамжийн байгууламжаар хангахад шаардлагатай бүхий л зардал, төлбөр, хураамжийг Концесс эзэмшигч хариуцна.

22.1.3 Нийтлэг үйлчилгээний хангамжийн байгууламжийг ашиглах болон түүгээр үйлчилгээ үзүүлэхтэй холбоотойгоор Концесс эзэмшигч нь Төрийн эрх бүхий байгууллага болон нийтлэг үйлчилгээгээр хангагч гуравдагч этгээдтэй харилцах асуудалд Эрх бүхий этгээдээс туслалцаа хүссэн тохиолдолд Эрх бүхий этгээд нь бүх талын үндэслэл бүхий дэмжлэг, туслалцаа үзүүлнэ.

22.2 Нийтлэг үйлчилгээний хангамжийн байгууламжтай холбоотой Эрх бүхий этгээдийн үүрэг

22.2.1 Энэхүү Гэрээний 22.2.2 дах хэсэг (Нийтлэг үйлчилгээний хангамжийн байгууламжтай холбоотой Эрх бүхий этгээдийн үүрэг)-т заасныг харгалзан, Эрх бүхий этгээд эсвэл Төрийн захиргааны байгууллага нь гэрээний Хавсралт 4 (Удирдлага,

зохион байгуулалтын нарийвчилсан хуваарь)-т хариуцан төлөхөөр заасан нийтлэг үйлчилгээний төлбөр, хураамжийг төлнө.

22.2.2 Концессын бус зүйл болон Төлөвлөгдөж буй байгууламжуудын хувьд:

- (1) Нийтлэг үйлчилгээний төлбөр, хураамжийг тухайн байгууламжийн үйл ажиллагааг хариуцаж байгаа этгээд хариуцан төлөх; ба
- (2) Концесс эзэмшигч нь тухай нийтлэг үйлчилгээний төлбөр, хураамжийг хураахтай холбоотойгоор тухайн байгууламжийн үйл ажиллагааг хариуцаж байгаа этгээдтэй гэрээ байгуулсан байх шаардлагатай.

22.3 Нийтлэг үйлчилгээний хангамжийн илүүдэл

Концесс эзэмшигч нь зөвхөн дор дурдсан нөхцөл хангагдсан бөгөөд өөрөө зөвшөөрсөн (үндэслэлгүйгээр татгалзахгүйгээр) тохиолдолд Нисэх буудлын бизнест шаардлагатай хэмжээнээс илүү гарсан Нийтлэг үйлчилгээний хангамжийг Эрх бүхий этгээд эсхүл түүний нэр заасан этгээдэд Нисэх буудлын талбай орчмын хот байгуулалт болон дагуул хотын бүтээн байгуулалтын зорилгоор нийлүүлэх эсхүл нийлүүлэлт хийх нөхцөлийг хангах үүрэгтэй. Үүнд:

22.3.1 Тухайн Нийтлэг үйлчилгээ нь Эрх бүхий этгээдэд эсхүл гуравдагч этгээдэд тийнхүү нийлүүлж болохуйц байх;

22.3.2 Концесс эзэмшигч нь ийнхүү нийлүүлж буй Нийтлэг үйлчилгээнд Өрсөлдөөний тухай хууль тогтоомж болон бусад холбогдох Хууль тогтоомжийн хүрээнд төлбөр, хураамж тогтоож болохуйц байх;

22.3.3 Эрх бүхий этгээд эсхүл холбогдох гуравдагч этгээд нь Нийтлэг үйлчилгээгээр хангахад шаардлагатай холболтыг Концессын талбайд хийх ба Концесс эзэмшигч уг холболтыг хийх асуудлыг хариуцахгүй (тэрхүү холболттой холбоотой үндэслэл бүхий туслалцаа үзүүлэхээс бусдаар) байх; болон

22.3.4 Концесс эзэмшигч нь Хууль тогтоомжид өөрөөр заагаагүй бол илүүдэл Нийтлэг үйлчилгээний хангамжийг нийлүүлэхэд шаардлагатай зөвшөөрлүүдийг авах боломжтой байх.

22.4 Нийтлэг үйлчилгээний хангамжийн тасалдал

- 22.4.1 Нийтлэг үйлчилгээний хангамжид аливаа саатал, тасалдал гарсан бөгөөд энэхүү саатал, тасалдал нь нэг (1) цагаас дээш хугацаагаар үргэлжилсэн тохиолдолд Концесс эзэмшигч нь Эрх бүхий этгээд болон бусад холбогдох Төрийн эрх бүхий байгууллагуудад аль болох боломжит богино хугацаанд уг саатал, тасалдлын талаар болон энэхүү Гэрээгээр хүлээсэн Концесс эзэмшигчийн үүрэгт үзүүлэх түүний нөлөөллийн талаар бичгээр мэдэгдэл хүргүүлнэ (**“Нийтлэг үйлчилгээний хангамжийн тасалдлын мэдэгдэл”**).
- 22.4.2 Концесс эзэмшигчийн буруугаас нийтлэг үйлчилгээний хангамжийн саатал/тасалдал гарснаас бусад тохиолдолд Концесс эзэмшигч нь уг саатал, тасалдлын нөлөөлөлд орсон энэхүү Гэрээгээр хүлээсэн үүргээсээ чөлөөлөгдөнө. Концесс эзэмшигч нь нийтлэг үйлчилгээний саатал, тасалдалд өртөөгүй энэхүү Гэрээгээр хүлээсэн бусад үүргээ хэвээр үргэлжлүүлэн гүйцэтгэх ба уг саатал, тасалдал арилсны дараа энэ Гэрээгээр хүлээсэн бүх үүргээ үргэлжлүүлэн гүйцэтгэнэ.
- 22.4.3 Эрх бүхий этгээд нь Концесс эзэмшигчийн Нийтлэг үйлчилгээний хангамжийн тасалдлын мэдэгдэл болон түүний агуулгыг хүлээн авсан болохыг үндэслэлгүйгээр саатуулахгүйгээр аль болох боломжит богино хугацаанд хүлээн зөвшөөрнө.
- 22.4.4 Концесс эзэмшигч нь Нийтлэг үйлчилгээний хангамжийн тасалдлын мэдэгдэл гаргахаас өмнө үүссэн аливаа төлбөрийн үүргээс чөлөөлөгдөхгүй.
- 22.4.5 Нийтлэг үйлчилгээний хангамжийн тасалдлын мэдэгдлийг анх хүргүүлснээс хойш нэг (1) долоо хоногийн хугацаанд уг тасалдал, саатал арилаагүй тохиолдолд Талууд Нисэх буудлын үйл ажиллагаанд уг Нийтлэг үйлчилгээний хангамжийн тасалдал, саатлын үзүүлэх нөлөөллийг бууруулах зохистой арга хэмжээний талаар хэлэлцээр хийнэ.
- 22.4.6 Концесс эзэмшигчийн буруугаас нийтлэг үйлчилгээний хангамжийн саатал/тасалдал гарснаас бусад тохиолдолд Талууд хэлэлцээр хийж эхэлснээс хойш гурван (3) долоо хоногийн дотор нөлөөлөл бууруулах зохистой арга хэмжээний талаар тохирч чадаагүй тохиолдолд Концесс эзэмшигч гэрээг хугацаанаас нь өмнө цуцлах тухай мэдэгдэл хүргүүлэх замаар Гэрээг цуцалж болно. Гэрээг хугацаанаас нь өмнө цуцлах тухай мэдэгдэл хүргүүлснээс хойш аль болох боломжит хугацаанд Талууд

Гэрээний 41 дүгээр зүйл (Гэрээ дуусгавар болох эсхүл Гэрээ цуцлах үед Концессын зүйл болон Концесс эзэмшигчийн хөрөнгөөр бий болсон эд хөрөнгийг буцаан шилжүүлэх)-ийн дагуу буцаан шилжүүлэх ажиллагааг эхлүүлнэ.

23. КОНЦЕССЫН ЗҮЙЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА БА ЗАСВАР ҮЙЛЧИЛГЭЭ

23.1 Үйл ажиллагаа, засвар үйлчилгээнд тавигдах шаардлага

Концесс эзэмшигч нь:

23.1.1 ҮАЗҮ-ий зүйлийн аюулгүй, найдвартай үйл ажиллагааг хангана;

23.1.2 Хууль тогтоомж, олон улсын болон үндэсний стандартад тавигдсан ерөнхий болон тусгай шаардлагын дагуу ҮАЗҮ зүйл болон Засвар үйлчилгээний зүйлүүдийн засвар үйлчилгээг хариуцан гүйцэтгэж, Концессын зүйлийн үйл ажиллагааны тасралтгүй, хэвийн ажиллагааг хангах, ердийн ашиглалтын хугацаанаас өмнө элэгдэж, эвдрэхээс хамгаалахад тухай бүр шаардлагатай засвар, үйлчилгээг хийнэ.

23.2 Концессын зүйлийг Сайжруулах

23.2.1 Концесс эзэмшигч нь аливаа Сайжруулалт хийх тохиолдолд энэхүү Гэрээний 20.1 дэх хэсэг (Концессыг сайжруулах санал)-д заасан Концессыг сайжруулах саналд хамаарч байгаа эсэхээс үл хамааран Сайжруулалт хийхээс өмнө Эрх бүхий этгээд болон ИНЕГ-т бичгээр мэдэгдэл хүргүүлнэ.

23.2.2 Концесс эзэмшигч нь Концессын талбайд хийгдэж буй аливаа Сайжруулалт болон бусад барилгын ажлын явцын талаар ҮАЗҮ-ний тайланд тусгаж Эрх бүхий этгээдэд гаргаж өгнө.

23.2.3 Эрх бүхий этгээд болон Концесс эзэмшигч нь Концессын талбайд хийгдэж буй аливаа Сайжруулалт болон бусад барилгын ажлыг хянах үүрэг бүхий зохих шалгуур хангасан нэг (1) Барилгын ажлын төлөөлөгчийг тус бүр томилж болно.

23.3 Аюулгүй ажиллагаа болон аюулгүй байдал

Концесс эзэмшигч дараах үүрэгтэй. Үүнд:

23.3.1 Концессын хугацааны туршид Нисэх буудлын үйлчилгээний аюулгүй ажиллагаа болон аюулгүй байдлыг хангах;

- 23.3.2 Аюулгүй ажиллагаа болон аюулгүй байдалтай холбоотой шаардлагатай урьдчилан сэргийлэх арга хэмжээг удирдан зохион байгуулах асуудлыг хариуцсан нэгж байгуулах;
- 23.3.3 Аюулгүй ажиллагаа болон аюулгүй байдлын талаар дотоод журам боловсруулах; болон
- 23.3.4 Аюулгүй ажиллагаа болон аюулгүй байдлын осол/тохиолдлын бүртгэл хөтөлж, түүнийг аюулгүй ажиллагаа болон аюулгүй байдлын холбогдох мэдээлэл, бичиг баримтын хамт Эрх бүхий этгээдэд нээлттэй байлгах.

23.4 Аэродромын үйл ажиллагааны заавар

- 23.4.1 Концесс эзэмшигч нь энэхүү Гэрээний 16.1.4 дэх хэсэг (Нисэх буудлын үйл ажиллагааг эхлүүлэх бэлтгэл үе шатан дах Концесс эзэмшигчийн үүрэг)-т заасны дагуу Аэродромын үйл ажиллагааны зааврыг боловсруулж, ИНЕГ-аар батлуулахаар хүргүүлнэ.
- 23.4.2 Концесс эзэмшигч нь Аэродромын үйл ажиллагааны зааврыг хянаж, шаардлагатай нэмэлт, өөрчлөлтийг тухай бүр оруулж, тэдгээр өөрчлөлтүүдтэй холбоотой шаардлагатай зөвшөөрлийг Хууль тогтоомжид заасны дагуу авна.

23.5 Концессын зүйлийн хяналт (мониторинг)

- 23.5.1 Концесс эзэмшигч нь Концессын хугацааны туршид Концессын зүйлийн хэвийн нөхцөлийг хянан үнэлэх ба Концессын зүйлийг аливаа эвдрэл гэмтэл, доголдол, устгал, сүйрлээс ангид байлгах асуудлыг хариуцна.
- 23.5.2 Барилгын бүтцийн алдаатай холбоотойгоос бусад тохиолдолд Концессын зүйлд аливаа эвдрэл гэмтэл, доголдол, устгал, сүйрэл үүссэн бол түүнийг Концесс эзэмшигч өөрийн зардлаар засварлана.
- 23.5.3 Концесс эзэмшигч нь үүссэн эвдрэл гэмтэл, доголдол, устгал, сүйрлийг Барилгын бүтцийн алдаа гэж үзвэл энэ тухай Эрх бүхий этгээдэд мэдэгдэх ба Барилгын бүтцийн алдаа мөн эсэхийг тодруулахаар холбогдох Төрийн эрх бүхий байгууллага (Улсын мэргэжлийн хяналтын комисс зэрэг) болон/эсхүл эрх бүхий шинжээчид хүсэлт гаргана.

ЗУРГААДУГААР БҮЛЭГ. САНХҮҮГИЙН УДИРДЛАГА

24. САНХҮҮГИЙН ТАЙЛАН

24.1 Санхүүгийн тайлан

24.1.1 Концесс эзэмшигч нь дараа улирлын эхний сарын 20-ны өдрийн дотор өмнөх улирлын Санхүүгийн тайланг, дараагийн Концессын жилийн 3 дугаар сарын 20-ны өдрийн дотор өмнөх жилийн аудитаар баталгаажсан Санхүүгийн тайлан (**“Санхүүгийн жилийн тайлан”**)-г тус тус Эрх бүхий этгээд болон ИНЕГ-т хүргүүлнэ. Санхүүгийн жилийн тайланг Монгол Улсад өөрийн оффистой, олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн бөгөөд Концесс эзэмшигчийн аль нэг хувьцаа эзэмшигчтэй аливаа ашиг сонирхлын зөрчилгүй аудитын байгууллагаас аудитласан байна.

24.1.2 Концесс эзэмшигч нь Монгол Улсын Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4 дүгээр зүйлд заасны дагуу Санхүүгийн тайлангаа хөтөлнө.

24.2 Бүртгэл

24.2.1 Концесс эзэмшигч нь Нисэх буудлын үйлчилгээтэй холбоотой дор дурдсан баримт бичгүүдийн бүртгэлийг хөтлөн хадгална. Үүнд:

- (1) Энэхүү Гэрээ болон Хууль тогтоомжид заасан тайлангууд;
- (2) нягтлан бодох бүртгэлийн олон улсын шилдэг туршлагын дагуу хөтөлсөн журнал;
- (3) Концессын хугацаанд хийж гүйцэтгэсэн бүх засвар үйлчилгээний ажлын бүрэн бүртгэл; болон
- (4) Концессын хугацаанд гарсан эрүүл ахуй, аюулгүй ажиллагаа, аюулгүй байдалтай холбоотой бүхий л тохиолдлуудыг багтаасан бүрэн бүртгэл.

24.2.2 Эрх бүхий этгээд нь нууцлалын үүрэгт хамаарахаас бусад Нисэх буудлын бизнестэй төстэй шинж бүхий асуудлаарх ЧХОУНБ-тай холбоотой Эрх бүхий этгээдийн бүртгэл, тэмдэглэлийг Концесс эзэмшигчид хүргүүлнэ.

24.2.3 Гэрээний 24 дүгээр зүйлийн 24.2 дах хэсэг (Бүртгэл)-т дурдсан бүртгэлүүдийг Концессын хугацаанд хадгална.



24.3 Эрх бүхий этгээд энэхүү Гэрээг цуцалсны дараа Нисэх буудлын бизнесийн үйл ажиллагаа болон менежменттэй холбоотойгоор өөр гэрээ байгуулах хүсэлтэй байх тохиолдолд Концесс эзэмшигч нь нууцлалын үүрэгт хамаарахаас бусад Концесс эзэмшигчийн зүгээс Нисэх буудлын бизнесийн үйл ажиллагааг эрхлэн явуулахтай холбоотой мэдээлэл, бичиг баримт гаргуулах тухай Эрх бүхий этгээдийн үндэслэл бүхий бүх хүсэлтийг хангана.

25. САНХҮҮГИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

25.1 Концесс эзэмшигч нь Нисэх буудлын бизнес болон Нисэх буудлын үйлчилгээг Санхүүгийн төлөвлөгөөнд заасны дагуу эрхлэн явуулахын тулд дээд зэргийн хүчин чармайлт гарган ажиллана.

25.2 Концесс эзэмшигч нь аудитаар баталгаажсан Санхүүгийн жилийн тайлан гарснаас хойш хуанлийн гүч (30) хоногийн дотор Санхүүгийн төлөвлөгөөг шинэчлэх ба уг шинэчилсэн Санхүүгийн төлөвлөгөөг Нисэх буудлын зохицуулах хорооны дараагийн хуралд лавлагааны зорилгоор хүргүүлнэ.

26. КОНЦЕССЫН ТӨЛБӨР БА БУСАД ТӨЛБӨР, ХУРААМЖ

26.1 Нисэх буудлын төлбөр, хураамж

26.1.1 Энэхүү Гэрээний 26 дугаар зүйлийн 26.1.2 - 26.1.6 дах хэсгүүд (Нисэх буудлын төлбөр, хураамж)-д заасныг харгалзан, Концесс эзэмшигч нь энэхүү Гэрээний 11.4 дэх хэсэг (Орлого)-т заасны дагуу Концессын хугацааны туршид Концессын зүйлтэй холбоотой бүхий л төлбөр, хураамж, түрээс болон бусад орлогыг ногдуулж өөрийн дансанд хураан төвлөрүүлэх онцгой эрхтэй байна.

26.1.2 Концесс эзэмшигч нь Өрсөлдөөний тухай хууль тогтоомжид нийцүүлэн Зохицуулалтгүй төлбөр хураамжийн үнэ тарифыг тогтоох онцгой эрх, үүрэгтэй ба ийнхүү тогтоосон Зохицуулалтгүй төлбөр хураамжийн үнэ тарифын хэмжээг Эрх бүхий этгээдээс зөвшөөрөл авахгүйгээр өөрчлөх эрхтэй.

26.1.3 Талууд Зохицуулалттай төлбөр хураамжийн жагсаалтыг энэхүү Гэрээний Хавсралт 2 (Төлбөр, хураамж)-ийн 1 дүгээр хэсэг (Зохицуулалттай төлбөр, хураамж)-т зааснаар харилцан тохиролцов.

26.1.4 Концесс эзэмшигч нь инфляци болон дефляцийн хэмжээтэй уялдуулан дараалсан гурван (3) Концессын жилийн хугацаа тутмын дараа Зохицуулалттай төлбөр хураамжийн үнэ тарифт өөрчлөлт оруулах эрхтэй ба ийнхүү өөрчлөлт оруулах эхний

хугацаа нь гурав (3) дах Концессын жилийн эцэст байна. Концесс эзэмшигч нь дараагийн гурван (3) Концессын жилд мөрдөх Зохицуулалттай төлбөр хураамжийн шинэ хувь хэмжээг дараах томъёоны дагуу тооцоолон шинэчилнэ.

[CPI N/ CPI NLC] * RFC

CPI N – гэж Монголын үндэсний статистикийн хорооноос тухайн жилд/хамгийн сүүлд гаргасан ХҮИ-г,

CPI NLC – гэж Зохицуулалттай төлбөр хураамжийг хамгийн сүүлд шинэчилсэн онд Монголын үндэсний статистикийн хорооноос гаргасан ХҮИ-г,

RFC – гэж Зохицуулалттай төлбөр хураамжийн дүнг тус тус илэрхийлнэ.

26.1.5 Концесс эзэмшигч нь Зохицуулалттай төлбөр хураамжийн хэмжээнд өөрчлөлт хийх (дээрх 26.1.4 дэх хэсэг (Нисэх буудлын төлбөр, хураамж)-т зааснаас бусад байдлаар) хүсэлтэй байх тохиолдолд энэ талаар Эрх бүхий этгээд болон Иргэний нисэхийн ерөнхий газарт доорх мэдээллийг тусгасан мэдэгдэл бичгээр хүргүүлж, энэхүү Гэрээний 10.2 дах хэсэг (Төрийн эрх бүхий байгууллага)-т заасны дагуу ИНЕГ зэрэг холбогдох Төрийн эрх бүхий байгууллагаас зөвшөөрөл авна. Үүнд:

- (1) санал болгож буй өөрчлөлт;
- (2) өөрчлөлт оруулах болсон дэлгэрэнгүй үндэслэл болон үүнээс үүдэн Нисэх буудлын бизнесийн үйл ажиллагаанд үүсэх давуу болон сул талын харьцуулалт; болон
- (3) тухайн өөрчлөлтийг оруулснаар Концесс эзэмшигчийн үзэж буйгаар орлогын төсөөлөл хэрхэн өөрчлөгдөх талаар дэлгэрэнгүй мэдээлэл.

26.1.6 Холбогдох Төрийн эрх бүхий байгууллага болон/эсхүл ИНЕГ санал болгож буй өөрчлөлтийг зөвшөөрөхгүй тохиолдолд Эрх бүхий этгээд нь энэ Гэрээний 26.1.5 дах хэсэг (Нисэх буудлын төлбөр, хураамж)-т заасан мэдэгдлийг хүлээн авснаас хойш жар (60) хоногийн дотор Төрийн эрх бүхий байгууллага болон Иргэний нисэхийн ерөнхий газар санал нийлэхгүй байгаа талаар болон түүний шалтгааны талаар Концесс эзэмшигчид бичгээр мэдэгдэнэ. Эрх бүхий этгээд нь энэ Гэрээний 26.1.5 дах хэсэг (Нисэх буудлын төлбөр, хураамж)-т заасан мэдэгдлийг хүлээн авснаас хойш жар (60) хоногийн дотор хариу өгөөгүй тохиолдолд

ИНЕГ-ийг оролцуулаад холбогдох Төрийн эрх бүхий байгууллага дээрх өөрчлөлтийн саналыг хүлээн зөвшөөрсөнд тооцогдох ба Концесс эзэмшигч санал болгосон өөрчлөлтийн дагуу Зохицуулалттай төлбөр хураамжийн хэмжээнд өөрчлөлт оруулах эрхтэй.

26.1.7 Талууд энэ Гэрээний 26.1.5 дах хэсэг (Нисэх буудлын төлбөр, хураамж)-т заасан журмыг баримталсан бөгөөд ИНЕГ болон/эсхүл холбогдох Төрийн эрх бүхий байгууллагаас Зохицуулалттай төлбөр хураамжид өөрчлөлт оруулах саналыг хүлээн зөвшөөрөхөөс татгалзсан ба Концесс эзэмшигч уг татгалзсан шалтгааныг (хуулийн) үндэслэлгүй гэж үзсэн бол аль ч тал нь уг асуудлыг Гэрээний 48 дугаар зүйл (Маргаан шийдвэрлэх)-д заасны дагуу шийдвэрлүүлэхээр хандаж болно.

26.1.8 Концесс эзэмшигч нь Концессын хугацаанд энэхүү Гэрээгээр тохирсон Зохицуулалттай болон Зохицуулалтгүй төлбөр хураамжаас өөр төрлийн шинэ төлбөр, хураамжийг шинээр бий болгож, хураахыг хүссэн тохиолдолд:

- (1) Концесс эзэмшигчийн шинээр бий болгохыг хүсэж буй төлбөр хураамж нь холбогдох Хууль тогтоомжид заасны дагуу Эрх бүхий этгээд болон/эсхүл холбогдох Төрийн эрх бүхий байгууллагаас зөвшөөрөл авах шаардлагатай бол тухайн төлбөр хураамжийг ногдуулахаас өмнө энэхүү Гэрээний 26.1.5-аас 26.1.7 дах хэсгүүд (Нисэх буудлын төлбөр, хураамж)-д заасан журмын шаардлагыг дагаж мөрдөнө;
- (2) Энэ зүйлийн 26.1.8 (1) дэх дэд хэсэг (Нисэх буудлын төлбөр, хураамж)-т зааснаас бусад тохиолдолд Эрх бүхий этгээдэд (а) шинээр бий болж байгаа төлбөр хураамжийн нэр болон хувь хэмжээ (б) шинээр төлбөр хураамж бий болгох болсон үндэслэл (в) шинэ төлбөр хураамж бий болсноор Концесс эзэмшигчийн үзэж буйгаар орлогын төсөөлөл хэрхэн өөрчлөгдөх талаар дэлгэрэнгүй мэдээлэл бүхий мэдэгдэл бичгээр хүргүүлнэ.

26.2 Концессын төлбөр

26.2.1 Концесс эзэмшигч нь Концессын хугацааны туршид Эрх бүхий этгээдэд Концессын төлбөрийг Монгол Улсын мөнгөн тэмдэг-төгрөгөөр төлнө.

26.2.2 Концессын төлбөрийг Концессын жил тутам дараах байдлаар тооцно.

Концессын төлбөр = (тухайн Концессын жилийн орлого (1*)) x (Хувь хэмжэ (2*))

(1*) Орлого гэдгийг энэхүү Гэрээний 11.4.3 дах хэсэг (Орлого)-т заасан утгаар ойлгоно. Үйл ажиллагаа эхлэх өдрөөс хойш таван (5) Концессын жилийн хугацаанд Дотоодын агаарын тээвэрлэгчийн үйлдэж буй олон улсын зургаан зуун (600) миллээс дээш холын зайн нислэгийн Буулт хөөрөлтийн хураамжийг тонн тутамд арван долоон мянган (17,000) төгрөгөөр тооцно.

(2*) "Хувь хэмжээ"-г тухайн Концессын жилд УБХОУНОШБ-аар зорчсон нийт Зорчигчдын тоо (*2.1) болон Эхлэлтийн хөрөнгө оруулалт ("ЭХО")-д үндэслэн дор дурдсан хүснэгтэд зааснаар тодорхойлно.

(*2.1) Зорчигчийн тоо нь олон улсын болон дотоодын нислэгийн Зорчигчдын тооноос бүрдэнэ. "Зорчигч" гэдэгт УБХОУНОШБ-д агаарын хөлгөөр хүрэлцэн ирж байгаа болон түүнээс хөөрч байгаа аливаа этгээдийг ойлгоно. Олон улсын нислэгийн хувьд Зорчигчдын тоог хилийн хяналт буюу гадаад улс руу зорчих асуудлыг хариуцсан Засгийн газрын агентлагийн гаргасан тоон мэдээлэлд үндэслэнэ. Дотоодын нислэгийн хувьд Зорчигчдын тоог Концесс эзэмшигч болон Иргэний нисэхийн ерөнхий газраас харилцан зөвшөөрсөн тоон мэдээлэлд үндэслэнэ.

Зорчигч (*2.1) (сая)(A) ЭХО (сая ам.доллар) (B)	(A)<1.6	$1.6 \leq (A) < 1.8$	$1.8 \leq (A) < 2.0$	$2.0 \leq (A) < 2.2$	$2.2 \leq (A) < 2.4$	$2.4 \leq (A)$
B=36.6	9%	10%	12%	14%	16%	18.5%
$36.6 < B \leq 36.85$	9%	10%	12%	14%	16%	18%
$36.85 < B \leq 37.1$	9%	10%	11%	12%	16%	18%
$37.1 < B \leq 37.35$	8%	10%	11%	13%	16%	18%
$37.35 < B \leq 37.6$	8%	9%	11%	13%	15%	18%

$37.6 < B \leq 37.85$	8%	9%	11%	13%	15%	18%
$37.85 < B \leq 38.1$	7%	9%	11%	13%	14%	18%
$38.1 < B \leq 38.35$	7%	9%	10%	13%	14%	18%
$38.35 < B \leq 38.6$	6%	8%	10%	13%	14%	18%
$38.6 < B \leq 38.85$	6%	8%	10%	13%	14%	17%
$38.85 < B \leq 39.1$	6%	8%	10%	12%	13%	16%
$39.1 < B \leq 39.35$	6%	8%	9%	12%	13%	16%
$39.35 < B \leq 39.6$	5%	7%	9%	11%	14%	17%
$39.6 < B \leq 39.85$	5%	7%	9%	11%	13%	17%
$39.85 < B \leq 40.1$	5%	7%	9%	10%	12%	16%
$40.1 < B \leq 40.35$	5%	7%	9%	10%	12%	16%
$40.35 < B \leq 40.6$	4%	6%	8%	10%	12%	16%
$40.6 < B \leq 40.85$	4%	6%	8%	10%	12%	16%
$40.85 < B \leq 41.1$	4%	5%	7%	9%	12%	16%
$41.1 < B \leq 41.35$	4%	5%	7%	9%	12%	15%
$41.35 < B \leq 41.6$	3%	5%	7%	9%	12%	14%
$B=41.6$	3%	5%	7%	9%	12%	14%

26.2.3 Эрх бүхий этгээд нь энэхүү Гэрээний 24.1 дэх хэсэг (Санхүүгийн тайлан)-т заасны дагуу Концессын жил тутмын аудитаар баталгаажсан Санхүүгийн жилийн тайлан болон Гэрээний 29.1 дэх хэсэг (Тайлан)-т заасан ҮАЗҮ-ний тайланг хүлээн авсны дараа Гэрээний 26.2.2 дах хэсэг (Концессын төлбөр)-т заасны дагуу Санхүүгийн жилийн тайлан болон ҮАЗҮ-ний тайлангийн тоон үзүүлэлтүүдэд үндэслэн тооцоолсон тухайн Концессын жилийн төлбөрийн хэмжээ бүхий нэхэмжлэхийг Концесс эзэмшигчид хүргүүлнэ.

26.2.4 Концесс эзэмшигч нь Концессын төлбөрийг дараах байдлаар хоёр хэсэгт хувааж төлнө.

(1) Эхний төлбөр: Концессын жилийн эхний хагасын төлбөрийг өмнөх оны Концессын төлбөрийн 50%-тай тэнцүү хэмжээгээр 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор төлнө.

(2) Хоёрдах төлбөр: Концессын жилийн хоёр дугаар хагасын төлбөрийг энэ Гэрээний 26.2.2 дах хэсэг (Концессын төлбөр)-т заасны дагуу тооцоолсон тухайн Концессын жилийн Концессын төлбөрөөс Гэрээний 26.2.4 (1) дэх хэсэг (Концессын төлбөр)-т заасны дагуу төлсөн Эхний төлбөрийг хассантай тэнцүү хэмжээгээр төлнө. Концесс эзэмшигч Хоёрдах төлбөрийг Эрх бүхий этгээдээс ирүүлсэн тухайн Концессын жилийн Концессын төлбөрийг баталгаажуулсан нэхэмжлэх хүлээн авснаас хойш нэг (1) сарын дотор төлнө.

26.2.5 Гэрээний 26.2.4 дэх хэсэг (Концессын төлбөр)-т заасныг үл харгалзан, Концесс эзэмшигч нь эхний Концессын жилийн Концессын төлбөрийг Гэрээний 26.2.3 дах хэсэг (Концессын төлбөр)-т заасны дагуу Эрх бүхий этгээдээс ирүүлсэн нэхэмжлэхийг хүлээн авснаас хойш нэг (1) сарын дотор нэг удаагийн төлөлтөөр төлнө.

26.3 Концесс эзэмшигч нь энэхүү Гэрээний 26.2 дах хэсэг (Концессын төлбөр)-т заасны дагуу Эрх бүхий этгээдээс нэхэмжилсэн Концессын төлбөрийн үнийн дүнг хүлээн зөвшөөрөхгүй байх үндэслэл бүхий шалтгаантай бол дараах журмыг баримтална. Үүнд:

26.3.1 Концесс эзэмшигч нь Гэрээний 26.2.3 дах хэсэг (Концессын төлбөр)-т заасны дагуу ирүүлсэн Концессын төлбөрийн нэхэмжлэхийг хүлээн авснаас хойш арван (10) Ажлын өдрийн дотор Концесс эзэмшигчийн тооцоолсон Концессын төлбөр

болон Эрх бүхий этгээдийн нэхэмжилсэн Концессын төлбөрийн талаарх үндэслэл бүхий шалтгааныг тайлбарласан мэдэгдэл Эрх бүхий этгээдэд хүргүүлнэ.

26.3.2 Эрх бүхий этгээд нь дээрх 26.3.1 дэх хэсэг (Концессын төлбөр)-т заасны дагуу Концесс эзэмшигчээс ирүүлсэн мэдэгдлийг хүлээн зөвшөөрч байгаа эсэх тухай хариуг арван (10) Ажлын өдрийн дотор хүргүүлнэ.

26.3.3 Эрх бүхий этгээд Концесс эзэмшигчийн үндэслэлтэй санал нийлэхгүй бол Талууд уг асуудлыг Гэрээний 26.3.2 дах хэсэг (Концессын төлбөр)-т заасны дагуу Эрх бүхий этгээдээс мэдэгдэл хүргүүлснээс хойш гучин (30) хоногт багтаан шийдвэрлэхээр бүхий л хүчин чармайлтыг гаргана.

26.3.4 Талууд Концессын төлбөрийн үнийн дүнгийн талаар санал нийлээгүй тохиолдолд Концесс эзэмшигч нь Концессын төлбөрийн маргаангүй хэсгийг нэхэмжлэлд заасан эцсийн хугацаанаас өмнө төлөх бөгөөд Талууд үлдсэн хэсэгтэй холбогдох маргааныг энэ Гэрээний 48 дугаар зүйл (Маргаан шийдвэрлэх)-д заасны дагуу шийдвэрлүүлнэ.

26.3.5 Маргааны үр дүнд шийдвэрлэгдсэн Концессын төлбөрийн үнийн дүн Гэрээний 26.3.4 дэх хэсэг (Концессын төлбөр)-ийн дагуу Концесс эзэмшигчийн төлсөн төлбөрийн дүнгээс илүү байх тохиолдолд төлөгдөөгүй үнийн дүнг энэхүү Гэрээний 26.4 дэх хэсэг (Хугацаа хэтрүүлсэн төлбөрийн хоног тутамд тооцох алданги)-т заасан хугацаа хэтрүүлсэн төлбөрийн хоног тутамд тооцсон алдангийн хамт маргаан шийдвэрлэгдсэнээс хойш арван (10) Ажлын өдрийн дотор төлнө.

26.4 Хугацаа хэтрүүлсэн төлбөрийн хоног тутамд тооцох алданги

26.4.1 Гэрээний аль нэг тал нь Концессын төлбөр болон бусад төлбөр төлөх үүргийг энэхүү Гэрээнд заасан төлбөр төлөх өдөр эсхүл түүнээс өмнө биелүүлээгүй хожимдуулсан бол хугацаа хэтрүүлсэн тал нь Монгол Улсын Иргэний хуулийн 232 дугаар зүйлийн 232.6 дах хэсэгт заасан алдангийг төлбөр төлөх ёстой байсан өдрөөс тухайн төлбөрийг бүхэлд нь төлсөн өдөр хүртэлх хугацаа хэтрүүлсэн хоног тутамд 0.046%-аар тооцож, нөгөө талдаа төлнө.

26.4.2 Талууд төлөгдөөгүй үнийн дүн болон энэхүү Гэрээний 26.4 дэх хэсэг (Хугацаа хэтрүүлсэн төлбөрийн хоног тутамд тооцох алданги)-т заасан хугацаа хэтрүүлсэн төлбөрийн хоног тутамд



тооцох алдангиас бусад ямар нэгэн мөнгөн дүнг нөгөө талаасаа нэхэмжлэх эрхгүй буюу нөгөө талдаа төлөх үүрэг хүлээхгүй.

27. САНХҮҮЖИЛТ БОЛОН БАРЬЦААНЫ ЭРХ

- 27.1 Концесс эзэмшигч нь Нисэх буудлын бизнесийн үйл ажиллагааг өөрийн хөрөнгө (үүнд энэхүү Гэрээний 11.4 дэх хэсэг (Орлого) болон 26.1 дэх хэсэг (Нисэх буудлын төлбөр, хураамж)-т заасны дагуу олсон орлого хамаарна) эсхүл банкнаас авсан зээл зэрэг өөрийн босгосон санхүүжилтээр санхүүжүүлнэ. Концесс эзэмшигч нь ирээдүйд олох орлогоо барьцаалах замаар хөрөнгө босгож болохгүй.
- 27.2 Гэрээний 27.1 дэх хэсэг (Санхүүжилт болон Барьцааны эрх)-т заасны дагуу хөрөнгө босгохдоо Концесс эзэмшигч нь Концессын зүйл болон Концесс эзэмшигчийн хөрөнгөөр бий болсон эд хөрөнгийг барьцаалахгүй бөгөөд энэхүү Гэрээний 15 дугаар зүйл (Концесс эзэмшигчид хориглох үйл ажиллагаа)-ийг дагаж мөрдөнө.
- 27.3 Концесс эзэмшигч нь Концессын зүйлийг барьцаалах замаар хөрөнгийн зах зээлд хувьцаа гаргах эсхүл хувьцааг олон нийтэд санал болгох замаар хөрөнгө босгож болохгүй.
- 27.4 Эрх бүхий этгээд нь энэхүү Гэрээг хэрэгжүүлэхтэй холбоотойгоор Концесс эзэмшигчид аливаа санхүүгийн дэмжлэг үзүүлэхгүй. Гэхдээ энэ нь энэхүү Гэрээний 17 дугаар зүйл (Үйл ажиллагаа эхлэх өдрийг сунгах, нөхөн төлбөр төлөх, хойшлуулсны улмаас гэрээ цуцлах), 39 дүгээр зүйл (Гэрээ цуцалсантай холбоотой нөхөн төлбөр) зэрэг энэ Гэрээний дагуу Эрх бүхий этгээдийн эсрэг шаардлага гаргах Концесс эзэмшигчийн эрхийг хөндөхгүй болно.

28. ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ДОТООД ӨГӨӨЖ

- 28.1 Концесс эзэмшигч нь энэхүү Гэрээний 28 дугаар зүйл (Хөрөнгө оруулалтын дотоод өгөөж)-д заасны дагуу өөрийн санхүүгийн бодит гүйцэтгэл болон үлдсэн Концессын хугацаанд төсөөлсөн гүйцэтгэлийг тооцоолж, нийт Концессын хугацаанд хамаарах, Монгол Улсад татвар төлөхөөс өмнөх Концесс эзэмшигчийн Хөрөнгө оруулалтын дотоод өгөөж (ХОДӨ)-ийг тооцоолж гаргана (**Төсөөлсөн ХОДӨ**).
- 28.2 Нийт Концессын хугацааны туршид хамаарах Эхлэлтийн хөрөнгө оруулалтын Төсөөлсөн ХОДӨ-ийг Монгол Улсад татвар төлөхөөс өмнө Концесс эзэмшигчийн хувьцаа эзэмшигч тус бүрийн хүлээн авсан ногдол ашигт үндэслэн тооцоолно.
- 28.3 Эхлэлтийн хөрөнгө оруулалтын Төсөөлсөн ХОДӨ-г хорь аравны таван хувь (20.5%) ("**Зорилтот ХОДӨ**")-д хадгалахын тулд Концесс эзэмшигч нь

дээд хүчин чармайлт гарган ажиллахыг Эрх бүхий этгээд ямар нэгэн баталгаа гаргалгүйгээр хүлээн зөвшөөрч байгаа болно. Концесс эзэмшигчийн ХОДӨ-г Эхлэлтийн хөрөнгө оруулалтаас тооцно. Хувьцаа эзэмшигч болон/эсхүл хөрөнгө оруулагч(д)аас хийсэн дараагийн хөрөнгө оруулалт эсхүл оруулсан хөрөнгө нь Эхлэлтийн хөрөнгө оруулалтын хэмжээг нэмэгдүүлэхэд нөлөөлөхгүй.

- 28.4 Үйл ажиллагаа эхлэх өдрөөс хойш гурван (3) жилийн дараах өдөр болон түүнээс хойших гурван (3) Концессын жил тутмын эцэст Төсөөлсөн ХОДӨ-ийг тооцно. Төсөөлсөн ХОДӨ нь Зорилтот ХОДӨ (татвар төлөхөөс өмнөх 20.5%-ийн ХОДӨ)-ээс бага эсхүл түүнээс илүү гарсан тохиолдолд Гэрээний аль ч тал нь зургаа (6) дах Концессын жилийн эцэст хийгдэх хоёр дах удаагийн гурван жил тутмын үнэлгээ хийгдсэний дараа энэхүү Гэрээний нөхцөлийг өөрчлөх талаар санал гаргаж болно. Талууд тухайн саналыг заавал хүлээн авах, хэлэлцэх үүрэггүй бөгөөд түүнээс татгалзах эрхтэй байна. Концессын хугацааны туршид Концесс эзэмшигчийн Төсөөлсөн ХОДӨ нь Зорилтот ХОДӨ-д хүрээгүйтэй холбоотойгоор Эрх бүхий этгээд нь Концесс эзэмшигчид нөхөн төлбөр төлөх, хохиролгүй болгох эсхүл аливаа төлбөр төлөх үүрэг хүлээхгүй. Энэ нь Талуудын энэхүү Гэрээний 28.4 дэх хэсэг (Хөрөнгө оруулалтын дотоод өгөөж)-т заасны дагуу хэлэлцээр хийх боломжид нөлөөлөхгүй болно.

ДОЛООДУГААР БҮЛЭГ. КОНЦЕСС ЭЗЭМШИГЧИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙГ ДҮГНЭХ

29. ТАЙЛАН

- 29.1 Концесс эзэмшигч нь улирлын ҮАЗҮ-ний тайланг дараа улирлын эхний сарын сүүлийн өдрийн дотор Эрх бүхий этгээд болон ИНЕГ-т хүргүүлнэ.
- 29.2 Концесс эзэмшигч нь гурван (3) Концессын жил тутам уг хугацааны дараагийн Концессын жилийн хоёрдугаар улирлын эхний сард багтаан энэхүү Гэрээний Гүйцэтгэлийн тайланг Эрх бүхий этгээд болон ИНЕГ-т хүргүүлнэ.
- 29.3 Концесс эзэмшигч нь Санхүүгийн тайланг энэхүү Гэрээний 24.1 дэх хэсэг (Санхүүгийн тайлан)-т заасны дагуу Эрх бүхий этгээд болон ИНЕГ-т хүргүүлнэ.
- 29.4 Концесс эзэмшигч нь Эрх бүхий этгээдээс Хууль тогтоомжид заасан үндэслэлээр шаардсан аливаа бусад тайлан, мэдээллийг тийнхүү хүсэлт гаргаснаас хойш арван (10) Ажлын өдрийн дотор эсхүл Хууль тогтоомжид өөрөөр заасан хугацаанд гаргаж өгнө.
- 29.5 Гэрээний хугацаа дуусгавар болсон эсвэл Гэрээ цуцлагдсан тохиолдолд Концесс эзэмшигч нь хяналтын тайлангууд, Санхүүгийн тайлангууд, засвар үйлчилгээний гарын авлага болон бусад бүх тайлан, бүртгэлийг



холбогдох баримт бичгийн хамт дөчин таван (45) Ажлын өдрийн дотор Эрх бүхий этгээдэд хүргүүлнэ.

- 29.6 Концесс эзэмшигч нь хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа Хууль тогтоомж, норм норматив, стандарт, техникийн шаардлагууд, улирлын болон төлөвлөгөөт, төлөвлөгөөт бус засвар үйлчилгээ хийх шаардлага, нисэх буудлын аюулгүй байдлын шаардлага болон Концесс эзэмшигчийн авах зөвшөөрлүүдийн шаардлагыг хэрхэн ханган ажиллаж байгаа талаар тогтмол дотоод хяналт хэрэгжүүлж, Концессын жил тутмын хяналтын тайланг ("**Нийцлийн тайлан**") дараагийн Концессын жилийн эхний улирлын эцэст Эрх бүхий этгээдэд хүргүүлнэ.
- 29.7 Концесс эзэмшигч нь засвар үйлчилгээний хуваарийг баримтлан ажиллах үүрэгтэй бөгөөд энэ талаар Гүйцэтгэлийн тайланд тусгана.
- 29.8 ОУИНБ болон ИНЕГ нь нисэх буудлын үйлчилгээ, чанар, стандарт, санхүү, удирдлага болон нисэх буудлын үйл ажиллагааны бусад асуудлаар Хууль тогтоомж болон олон улсын шаардлага (хэрэв хамааралтай бол)-ын дагуу хяналт шалгалт хийж, дүгнэлт гаргах эрхтэй байна. Энэхүү 29.8 дах заалт нь Нисэх буудлын үйлчилгээ явуулах, Нисэх буудлын бизнес эрхлэхтэй холбоотойгоор Эрх бүхий этгээд эсхүл Төрийн эрх бүхий байгууллагын зүгээс Хууль тогтоомжоор шаардсан бусад хяналт, шалгалт явуулах эрхийг хөндөхгүй.
- 30. КОНЦЕСС ЭЗЭМШИГЧИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ ХИЙХ**
- 30.1 Энэхүү 30 дугаар зүйл (Концесс эзэмшигчийн гүйцэтгэлд хяналт шинжилгээ, үнэлгээ хийх) нь зөвхөн Үйл ажиллагаа эхлэх өдрөөс хойш Концессын гэрээ дуусгавар болох эсхүл цуцлах өдөр хүртэлх Концесс эзэмшигчийн үйл ажиллагаанд үйлчилнэ.
- 30.2 Эрх бүхий этгээд нь энэхүү Гэрээний хэрэгжилтэд үнэлгээ, дүгнэлт хийх эрхтэй бөгөөд Гэрээний 9.3 дах хэсэг (Үнэлгээ, дүгнэлт)-т заасан эрхийг хэрэгжүүлнэ.
- 30.3 Эрх бүхий этгээд нь гурван (3) Концессын жил тутамд Концесс эзэмшигчийн гүйцэтгэлийн үнэлгээг хийнэ.
- 30.4 Эрх бүхий этгээд Концесс эзэмшигчийн гүйцэтгэлд үнэлгээ хийлгэхтэй холбоотойгоор хараат бус, хөндлөнгийн байгууллага авч ажиллуулж болох бөгөөд үнэлгээ хийхтэй холбоотой зардлыг өөрөө хариуцна.
- 30.5 Концесс эзэмшигчийн гүйцэтгэлийг дараах үндсэн шалгуур үзүүлэлтүүд (ҮШҮ)-д тулгуурлан үнэлнэ. Үүнд:

- 30.5.1 Концессын талбайд гарсан осол, хэргийн тоо;
- 30.5.2 ОУИНБ-ын үйлчилгээний Оптимум түвшинд хүрсэн байдал;
- 30.5.3 хэрэглэгчдийн сэтгэл ханамжийн түвшин;
- 30.5.4 бүтээмж;
- 30.5.5 Нисэх буудлын менежментийн санхүүгийн гүйцэтгэлийн үзүүлэлтүүд, үүнд дор дурдсан үзүүлэлтүүд багтах боловч эдгээрээр хязгаарлагдахгүй байна. Үүнд:
- (1) ЭБИДТА (EBITDA) (хүүгийн төлбөр, татвар, биет болон биет бус хөрөнгийн хорогдол болон үнэ цэнийн бууралтаас өмнөх орлого);
 - (2) Зорчигчдын тоо (PAX); болон
 - (3) Агаарын навигацийн бус орлогын хувь.
- 30.6 Концесс эзэмшигч нь өөрийн үйл ажиллагааны гүйцэтгэлийг хянах зорилгоор гурван (3) Концессын жил тутам Үндсэн шалгуур үзүүлэлт (ҮШҮ)-ийн зорилт тогтооно. Эрх бүхий этгээд болон Төрийн эрх бүхий байгууллагын зүгээс ҮШҮ-ийг нэмэгдүүлэхэд шаардлагатай хамтын ажиллагааны хүрээнд боломжит хамгийн дээд хүчин чармайлт гаргана. Гүйцэтгэлийн тайланд ҮШҮ-ийн гүйцэтгэл болон дараагийн 3 Концессын жилийн зорилтот ҮШҮ-ийг тусгасан байна.
- 30.7 Эрх бүхий этгээдээс шаардсан тохиолдолд Концесс эзэмшигч нь ҮШҮ-ийн гүйцэтгэлийн явцын тайлан гаргаж өгнө.
- 30.8 Эрх бүхий этгээд, ИНЕГ-ийг оролцуулаад Төрийн эрх бүхий байгууллага болон хөндлөнгийн гуравдагч этгээд үнэлгээний үр дүнд хангалтгүй гүйцэтгэл илрүүлсэн тохиолдолд Эрх бүхий байгууллага нь аливаа ҮШҮ-ийн хангалтгүй гүйцэтгэлийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг багтаасан мэдэгдлийг Концесс эзэмшигчид хүргүүлнэ.
- 30.9 Концесс эзэмшигч дээрх мэдэгдлийг хүлээн авсны дараа тухайн ҮШҮ-ийн хангалтгүй гүйцэтгэлийн шалтгааны талаарх тайлбар болон түүнийг засах арга хэмжээний төлөвлөгөөг Эрх бүхий этгээдэд хүргүүлэх ба тус төлөвлөгөөнд заасан хугацааны дотор гүйцэтгэлийн хангалттай түвшинд хүрэхийн тулд төлөвлөгөөг хэрэгжүүлнэ.
- 30.10 Санхүүгийн тайлан болон түүний хэрэгжилтийн үнэлгээний хувьд Концесс эзэмшигч нь Санхүүгийн төлөвлөгөөнд зааснаас их хэмжээгээр давсан өртөг, зардал гаргасан бол Эрх бүхий этгээд энэ талаарх тайлбарыг Концесс эзэмшигчээс гаргуулан авах эрхтэй.



31. ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТҮВШНИЙ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ БА ХЭРЭГЛЭГЧДИЙН СЭТГЭЛ ХАНАМЖ

31.1 Концесс эзэмшигч нь Концессын хугацааны туршид нислэгийн хөдөлгөөн болон зорчигчийн урсгал, Концессын зүйлийн үйл ажиллагааны гүйцэтгэлд дараах байдлаар тогтмол хяналт тавьж ажиллана. Үүнд:

31.1.1 аюулгүй байдлыг дэмжих хороог байгуулж, хяналтын хурлыг гурван (3) сар тутамд хуралдуулах;

31.1.2 үйлчилгээний түвшний хяналт шалгалтыг хагас жил тутам явуулах; болон

31.1.3 Концесс эзэмшигчийн ажилтнуудаас бүрдсэн хэрэглэгчдийн үйлчилгээний хороо байгуулж, хяналтын хурлыг улирал тутам хуралдуулах.

31.2 Концесс эзэмшигч нь Концессын хугацааны туршид агаарын тээвэрлэгчид болон бусад оролцогч талуудыг хамруулаад Нисэх буудлын хэрэглэгчдийн сэтгэл ханамжийн түвшинг дээшлүүлэхийн тулд дээд хүчин чармайлт гарган ажиллана.

НАЙМДУГААР БҮЛЭГ. НӨХӨН ТӨЛБӨР

32. КОНЦЕСС ЭЗЭМШИГЧИЙН ХОХИРОЛ НӨХӨН ТӨЛӨХ БАТАЛГАА

32.1 Энэхүү Гэрээний 32.2 дах хэсэг (Концесс эзэмшигчийн хохирол нөхөн төлөх баталгаа)-т заасныг харгалзан, Концесс эзэмшигч нь дор дурдсан зүйлсээс үүссэн бүх Шууд хохирлыг хариуцаж, Эрх бүхий этгээдийг түүнээс ангид хохиролгүй байлгаж, хохирлыг нөхөн төлж барагдуулна. Үүнд:

32.1.1 Гуравдагч этгээд ажлын байран дээр осолд орох, түүний биед гэмтэл учрах эсхүл амь нас хохирсон;

32.1.2 Гуравдагч этгээдийн эд хөрөнгөд учирсан хохирол, гэмтэл; болон

32.1.3 Эрх бүхий этгээд болон Төрийн эрх бүхий байгууллагын эсрэг гуравдагч этгээдийн зүгээс гаргасан гомдол, нэхэмжлэл, шаардлага, аливаа өр авлага, төлбөр зэрэг нь доорх нөхцөл байдлын улмаас бий болон эсхүл тэдгээрийн үр дүнд үүссэн бол. Үүнд:

- (1) Концесс эзэмшигч Нисэх буудлын бизнес эсхүл энэхүү Гэрээнд заасан аливаа үүргээ биелүүлсэн эсвэл эс биелүүлснээс; эсхүл
- (2) Концесс эзэмшигч болон Концесс эзэмшигчтэй хамаарал бүхий этгээдийн Концессын талбайд хэрэгжүүлсэн аливаа үйл ажиллагаа.

32.2 Концесс эзэмшигч нь Монгол Улсын Иргэний хуулийн 229 дүгээр зүйлийн 229.2 дах хэсэгт заасныг харгалзан Эрх бүхий этгээд, Эрх бүхий этгээдтэй хамаарал бүхий этгээд болон ЧХОУНБ-ын хайхрамжгүй болон/эсхүл шууд санаатай үйлдэл, Эрх бүхий этгээдийн энэхүү Гэрээгээр хүлээсэн үүргийн зөрчил эсхүл Эрх бүхий этгээдтэй хамаарал бүхий этгээд/Төрийн эрх бүхий байгууллага болон ЧХОУНБ-д энэхүү Гэрээний дагуу ногдуулсан үүргийн зөрчлийн улмаас дээрх заалтад дурдсан гуравдагч этгээдэд учирсан аливаа хохирлыг хариуцахгүй ба Эрх бүхий этгээдийг түүнээс ангид байлгаж, нөхөн төлбөр төлөх үүрэг хүлээхгүй.

32.3 Концесс эзэмшигч нь Концесс эзэмшигч болон түүнтэй хамаарал бүхий этгээдийн үйл ажиллагааны улмаас Эрх бүхий этгээд эсхүл Төрийн эрх бүхий байгууллагын эд хөрөнгө (Концессын зүйл, Концессын талбайг оруулаад)-д учирсан алдагдал, хохирлоос үүдэлтэй бүх Шууд хохирлыг хариуцаж, Эрх бүхий этгээдийг түүнээс ангид хохиролгүй байлгаж, хохирлыг нөхөн төлж барагдуулна.

32.4 Эргэлзээ төрүүлэхээс зайлсхийх зорилгоор дурдахад, Эрх бүхий этгээд өөрт учирсан Шууд хохирлыг Концесс эзэмшигчээс нэхэмжлэхдээ дор дурдсан зүйлсийн нийлбэр дүнг хасаж тооцох ба уг нийлбэр нь эерэг утгатай байх ба хэрэв хасах дүнтэй байвал нийлбэрийг тэг (0) гэж тооцно. Үүнд:

32.4.1 хохирол эсхүл эвдрэл, гэмтлийг засварлахад зарцуулагдсан эсхүл Эрх бүхий этгээд болон холбогдох Төрийн байгууллагын аль нэгэнд төлсөн даатгалын нөхөн төлбөр; түүнээс хасах нь

32.4.2 энэхүү Гэрээний 32.1 дэх хэсэг (Концесс эзэмшигчийн хохирол нөхөн төлөх баталгаа)-т заасны дагуу Концесс эзэмшигчээс Эрх бүхий этгээдэд нөхөн төлбөр төлөхөд хүргэх үйл явдлаас шууд үүссэн, энэхүү 32.1 дэх хэсэг (Концесс эзэмшигчийн хохирол нөхөн төлөх баталгаа)-т заасны дагуу Концесс эзэмшигчээс Эрх бүхий этгээдэд нөхөн төлбөр төлөх шаардлагатай нөхцөл байдал бий болсонтой холбоотойгоор даатгалын шаардлага гаргасны дараагийн жил Эрх бүхий этгээдийн төлөх ёстой даатгалын хураамж нэмэгдсэн бол тэрхүү нэмэгдсэн хураамжтай холбоотой зардал.

33. ЭРХ БҮХИЙ ЭТГЭЭДИЙН ХОХИРОЛ НӨХӨН ТӨЛӨХ БАТАЛГАА

33.1 Энэхүү Гэрээний 33.2 дах хэсэг (Эрх бүхий этгээд хохирол нөхөн төлөх баталгаа)-т заасныг харгалзан, Эрх бүхий этгээд нь дор дурдсан зүйлсээс үүссэн бүх Шууд хохирлыг хариуцаж, Концесс эзэмшигчийг түүнээс ангид хохиролгүй байлгаж, хохирлыг нөхөн төлж барагдуулна. Үүнд:

33.1.1 Гуравдагч этгээд ажлын байран дээр осолд орох, түүний биед гэмтэл учрах, амь нас хохирох;

33.1.2 Гуравдагч этгээдийн эд хөрөнгөд учирсан хохирол, гэмтэл; болон

33.1.3 Концесс эзэмшигчийн эсрэг гуравдагч этгээдийн зүгээс гаргасан гомдол, нэхэмжлэл, шаардлага, аливаа өр авлага, төлбөр нь доорх нөхцөл байдлын улмаас бий болон эсхүл тэдгээрийн үр дүнд үүссэн бол. Үүнд:

(1) Эрх бүхий этгээд энэхүү Гэрээний 4 дүгээр зүйлийн 4.4, 4.5, 4.7 дах хэсгүүд (Концессын талбай болон Нисэх буудлыг хөгжүүлэх бүс), 9 дүгээр зүйлийн 9.1.1, 9.1.2, 9.1.3, 9.1.6 дах хэсгүүд (Эрх бүхий этгээдийн чиг үүрэг), 9.4 дэх хэсэг (Үл тасалдалт), 9.6.3 дах заалт (Өрсөлдөх нисэх буудал болон арилжааны боломжуудыг хязгаарлах), 9.7 дах хэсэг (Саадын хязгаарлалтын техникийн шаардлагыг хангах), 9.8 дах хэсэг (Хүрээлэн буй орчин, эрүүл мэнд, аюулгүй ажиллагаа болон аюулгүй байдлын тухай хууль тогтоомжийг биелүүлэх), 10 дугаар зүйлийн 10.1, 10.7 дах хэсгүүд (Эрх бүхий этгээд)-д заасан үүргээ Нисэх буудлын талбайд биелүүлсэн эсхүл эс биелүүлснээс (дээрхид үл хамаарах аливаа онцгой тохиолдол байхгүй болно); эсхүл

(2) Эрх бүхий этгээд болон Төрийн эрх бүхий байгууллагын Концессын талбайд хэрэгжүүлсэн аливаа үйл ажиллагаа.

33.2 Эрх бүхий этгээд нь Монгол улсын Иргэний хуулийн 229 дүгээр зүйлийн 229.2 дах хэсэгт заасныг харгалзан, Концесс эзэмшигч болон түүнтэй хамаарал бүхий этгээдийн хайхрамжгүй болон/эсхүл шууд санаатай үйлдэл, Концесс эзэмшигчийн энэхүү Гэрээгээр хүлээсэн үүргийн зөрчил эсхүл Концесс эзэмшигчийн хамаарал бүхий этгээдэд энэ Гэрээний дагуу ногдуулсан үүргийн зөрчлийн улмаас дээрх заалтад дурдсан гуравдагч этгээдэд учирсан аливаа хохирлыг хариуцахгүй ба Концесс эзэмшигчийг түүнээс ангид байлгаж, нөхөн төлбөр төлөх үүрэг хүлээхгүй.

33.3 Эрх бүхий этгээд нь Эрх бүхий этгээд болон Төрийн эрх бүхий байгууллагын үйл ажиллагааны улмаас Концесс эзэмшигчийн эд хөрөнгө (Концесс эзэмшигчийн хөрөнгөөр бий болсон эд хөрөнгийг оруулаад)-д учирсан алдагдал, хохирлоос үүдэлтэй бүх Шууд хохирлыг хариуцаж, Концесс эзэмшигчийг түүнээс ангид хохиролгүй байлгаж, хохирлыг нөхөн төлж барагдуулна.

33.4 Эргэлзээ төрүүлэхээс зайлсхийх зорилгоор дурдахад, Концесс эзэмшигч өөрт учирсан Шууд хохирлыг Эрх бүхий этгээдээс нэхэмжлэхдээ дор дурдсан зүйлсийн нийлбэр дүнг хасаж тооцох ба уг нийлбэр нь эерэг утгатай байх ба хэрэв хасах дүнтэй байвал нийлбэрийг тэг (0) гэж тооцно. Үүнд:

33.4.1 хохирол эсхүл эвдрэл, гэмтлийг засварлахад зарцуулсан эсхүл Концесс эзэмшигчид төлсөн даатгалын нөхөн төлбөр;

33.4.2 энэхүү Гэрээний 33.1 дэх хэсэг (Эрх бүхий этгээдийн хохирол нөхөн төлөх баталгаа)-т заасны дагуу Эрх бүхий этгээдээс Концесс эзэмшигчид нөхөн төлбөр төлөхөд хүргэх үйл явдлаас шууд үүссэн, энэхүү 33.1 дэх хэсэг (Эрх бүхий этгээдийн хохирол нөхөн төлөх баталгаа)-т заасны дагуу Эрх бүхий этгээдээс Концесс эзэмшигчид нөхөн төлбөр төлөх шаардлагатай нөхцөл байдал бий болсонтой холбоотойгоор даатгалын шаардлага гаргасны дараагийн жил Концесс эзэмшигчийн төлөх ёстой даатгалын хураамж нэмэгдсэн бол тэрхүү нэмэгдсэн хураамжтай холбоотой зардал.

34. КОНЦЕССЫН ЗҮЙЛ, ШИЛЖҮҮЛСЭН АЖИЛТНУУД БОЛОН ГУРАВДАГЧ ЭТГЭЭДТЭЙ БАЙГУУЛСАН ГЭРЭЭНҮҮДТЭЙ ХОЛБООТОЙ ЭРХ БҮХИЙ ЭТГЭЭДИЙН ХОХИРОЛ НӨХӨН ТӨЛӨХ БАТАЛГАА

34.1 Эрх бүхий этгээд нь дор дурдсан зүйлээс үүсэлтэй болон түүнтэй холбоотойгоор бий болсон Шууд хохирлыг хариуцаж, Концесс эзэмшигчийг түүнээс ангид хохиролгүй байлгаж, хохирлыг нөхөн төлнө. Үүнд:

34.1.1 Концессын зүйл тус бүрийн хувьд Шилжүүлэг дууссан тухай гэрчилгээ үйлдэхээс өмнө эсхүл Шилжүүлсэн ажилтан бүрийн хувьд Концесс эзэмшигчид ажиллаж эхлэсэн үеэс өмнөх хугацаанд хамаарах;

34.1.2 Үйл ажиллагаа эхлэх өдрөөс өмнө Эрх бүхий этгээд, ИНЕГ, ЧХОУНБ болон Эрх бүхий этгээдтэй хамаарал бүхий этгээдтэй байгуулсан аливаа гэрээтэй холбоотойгоор аливаа Агаарын тээвэрлэгч эсхүл аливаа гуравдагч этгээдийн гаргасан нэхэмжлэл.

35. НӨХӨН ТӨЛБӨР ТӨЛҮҮЛЭХ ШААРДЛАГА ГАРГАХ

35.1 Эрх бүхий этгээд эсвэл Концесс эзэмшигчийн аль нэг нь ("**Нөхөн төлбөр төлүүлэх тал**") гуравдагч этгээдээс аливаа шаардлагын талаар мэдэгдэл, шаардах бичиг, албан захидал, эсвэл бусад төрлийн баримт бичиг ("**Шаардлага**") хүлээн авсан ба уг шаардлагын хувьд Эрх бүхий этгээд эсхүл Концесс эзэмшигч ("**Нөхөн төлбөр төлөх тал**")-ээс энэхүү Гэрээний дагуу нөхөн төлбөр авах эрхтэй гэж үзэх тохиолдолд Нөхөн төлбөр төлүүлэх тал нь Нөхөн төлбөр төлөх талд Шаардлагын талаар аль болох боломжит богино хугацаанд мэдэгдэнэ.

35.2 Энэхүү Гэрээний 35.3 дах хэсэг (Хохирол нөхөн төлүүлэх шаардлага гаргах)-т заасныг харгалзан, 35.1 дэх хэсэг (Хохирол нөхөн төлүүлэх шаардлага гаргах)-т заасны дагуу мэдэгдэл хүргүүлснээр Нөхөн төлбөр төлөх тал нь уг Шаардлагыг Нөхөн төлбөр төлүүлэх талын нэрийн өмнөөс өөрийн зардлаар няцаах, уг Шаардлагатай холбоотой хамгаалалтын арга хэмжээ авах, маргах, давж заалдах болон хэлэлцээр хийх зэрэг арга хэмжээг авах эрхтэй ба авч хэрэгжүүлнэ. Нөхөн төлбөр төлүүлэх тал нь Нөхөн төлбөр төлөх талд уг Шаардлагыг харгалзан үзэх болон түүнийг няцаахтай холбоотой асуудлаар бүхий л талаар боломжит хэмжээнд хамтран ажиллаж, дэмжлэг үзүүлнэ. Хэрэв Нөхөн төлбөр төлүүлэх тал Шаардлагыг шийдвэрлэхэд оролцох хүсэлт гаргавал Талууд Шаардлагыг шийдвэрлэх талаар үнэнч, шударгаар харилцан зөвшилцөнө.

35.3 Дээрх 35.2 дах хэсэг (Хохирол нөхөн төлүүлэх шаардлага гаргах)-т заасан аливаа Шаардлагын хувьд Талууд дараах арга хэмжээг авна. Үүнд:

35.3.1 Нөхөн төлбөр төлөх тал нь Нөхөн төлбөр төлүүлэх талыг нэхэмжлэлтэй холбоотой бүхий л мэдээллээр хангаж, нэхэмжлэлийг хэрхэн шийдвэрлэх талаар зөвшилцөнө;

35.3.2 (i) Нөхөн төлбөр төлүүлэх тал нь тухайн Шаардлагатай холбоотой бүх Шууд хохирлыг Нөхөн төлбөр төлөх талаар нөхөн төлүүлэх эрхгүй бөгөөд (ii) түүний улмаас Нөхөн төлбөр төлүүлэх тал нь тухайн Шаардлагыг гаргасан гуравдагч этгээдэд тодорхой хэмжээний төлбөр төлж болзошгүй байх тохиолдолд энэхүү 35.2 дах хэсгийн дагуу Шаардлагыг шийдвэрлэхдээ Нөхөн төлбөр төлөх тал нь Нөхөн төлбөр төлүүлэх талаас тэрхүү гуравдагч этгээдэд төлж болох төлбөрийн хэмжээг нэмэгдүүлж болзошгүй аливаа арга хэмжээ авч хэрэгжүүлэхгүй; бөгөөд

35.3.3 Нөхөн төлбөр төлөх тал нь Нөхөн төлбөр төлүүлэх талын зөвшөөрөлгүйгээр тухайн Шаардлагыг биелүүлэн төлбөр төлөх, эвлэрэх зэрэг арга хэмжээ авахгүй ба Нөхөн төлбөр төлүүлэх тал нь дээрх зөвшөөрлийг үндэслэлгүйгээр саатуулах эсхүл олгохоос татгалзах эрхгүй.

35.4 Гэрээний 32 дугаар зүйл (Концесс эзэмшигчийн нөхөн төлбөр төлөх баталгаа), 33 дугаар зүйл (Эрх бүхий этгээдийн нөхөн төлбөр төлөх баталгаа), 34 дүгээр зүйл (Концессын зүйл, Шилжүүлсэн ажилтнууд болон гуравдагч этгээдтэй байгуулсан гэрээнүүдтэй холбоотой Эрх бүхий этгээдийн хохирол нөхөн төлөх баталгаа), 35 дугаар зүйл (Нөхөн төлбөр төлүүлэх шаардлага гаргах) дугаар зүйлүүдийг харгалзан, энэхүү Гэрээний 37.1 (Концесс эзэмшигчийн үүргийн зөрчлийн улмаас гэрээ цуцлах) болон 38.1 дэх хэсгүүд (Эрх бүхий этгээдийн үүргийн зөрчлийн улмаас гэрээ цуцлах)-д зааснаас бусад үүргээ зөрчсөн Тал нь зөвхөн тэрхүү үүргийг зөрчсөний улмаас нөгөө талдаа учирсан Шууд хохирлыг холбогдох шаардлагын талаарх мэдэгдлийг нотлох баримтын хамтаар хүлээн авснаас хойш ер (90) хоногийн дотор нөхөн төлнө.

ЕСДҮГЭЭР БҮЛЭГ. ГЭРЭЭ ЦУЦЛАХ БОЛОН ГЭРЭЭ ЦУЦАЛСНААС ҮҮСЭХ НӨХӨН ТӨЛБӨР

36. ГЭРЭЭГ ЦУЦЛАХ

36.1 Энэхүү Гэрээг Монгол Улсын Концессын тухай хууль, бусад холбогдох Хууль тогтоомжийн дагуу болон дараах зүйлсийн аль эхэнд тохиолдсоноор цуцалж болно. Үүнд:

36.1.1 Гэрээний 6.2 дах хэсэгт зааснаар Концессын хугацааг сунгасан хугацааг оруулаад Концессын хугацааны сүүлийн өдөр;

36.1.2 Талууд гэрээг дуусгавар болгохоор тохиролцсон бол гэрээг дуусгавар болгохоор тохиролцсон өдөр;

36.1.3 Үйл ажиллагаа эхлэх өдөр хойшлогдсоны улмаас энэ Гэрээний 17.6 дах хэсэг (Хугацаа хэтрүүлснээс гэрээг цуцлах)-т заасны дагуу Гэрээг цуцалсан өдөр;

36.1.4 Гэрээний 37 дугаар зүйл (Концесс эзэмшигчийн үүргийн зөрчлийн улмаас гэрээ цуцлах)-д заасны дагуу Концесс эзэмшигч гэрээний үүргээ зөрчсөний улмаас Гэрээг цуцалсан өдөр;

36.1.5 Гэрээний 38 дугаар зүйл (Эрх бүхий этгээдийн үүргийн зөрчлийн улмаас гэрээ цуцлах)-д заасны дагуу Эрх бүхий этгээд гэрээний үүргээ зөрчсөний улмаас Гэрээг цуцалсан өдөр;

- 36.1.6 Гэрээний 45.7 дах хэсэг (Давагдашгүй хүчин зүйл)-т заасны дагуу Давагдашгүй хүчин зүйлийн тохиолдол бий болсонтой холбоотойгоор Гэрээг цуцалсан өдөр;
- 36.1.7 Гэрээний 22.4 дэх хэсэг (Нийтлэг үйлчилгээний хангамжийн тасалдал)-т заасны дагуу Нийтлэг үйлчилгээний хангамжийн тасалдлын талаар мэдэгдэл хүргүүлсэнтэй холбоотойгоор Гэрээг цуцалсан өдөр; эсхүл
- 36.1.8 Монгол Улсын Засгийн газраас Гэрээг Үндэсний аюулгүй байдал, батлан хамгаалах болон нийтийн ашиг сонирхолд харш гэж үзэж Гэрээг цуцалсан өдөр.
- 36.2 Үйл ажиллагаа эхлэх өдрөөс өмнө Гэрээг цуцалсан тохиолдолд энэхүү Гэрээний 17.6.2 болон 17.6.3 дэх хэсгүүд (Хойшлуулах нөхцөлийн улмаас гэрээ цуцлах)-ийг тус тус удирдлага болгон Талуудад учирсан хохирлын нөхөн төлбөрийн асуудлыг шийдвэрлэнэ.
- 36.3 Үйл ажиллагаа эхлэх өдөр эсхүл түүнээс хойш Гэрээг цуцалсан тохиолдолд энэхүү 9 дүгээр бүлэг (Гэрээ цуцлах болон гэрээ цуцалснаас үүсэх нөхөн төлбөр)-ийн зүйл заалтуудыг баримтална.
- 36.4 Талууд Гэрээг цуцалсантай холбоотой энэхүү Гэрээнд зааснаас бусдаар аливаа төлбөр авах эсхүл бусад эрх хамгаалах арга хэмжээ хэрэгжүүлэх эрхгүй байна.
- 36.5 Талууд Гэрээний 36 дугаар зүйл (Гэрээ цуцлах)-д зөвшөөрснөөс бусад тохиолдолд энэхүү Гэрээг цуцлах эрхгүй байна.
- 36.6 Гэрээг цуцалсан нь (i) Гэрээний үүргийн өмнөх зөрчилтэй холбоотой хохирол төлүүлэх шаардлага гаргах эрхийг багтаагаад Гэрээ цуцлах өдөр болон түүнээс өмнө үүссэн эсвэл үүсэж байгаа эсхүл (ii) доорх 36.7 дах хэсэг (Гэрээ цуцлах)-т дурдсан зүйлүүдтэй холбоотойгоор Гэрээ цуцлах өдрөөс хойш үүсэж буй аль нэг талын зүгээс нөгөө талын эсрэг хэрэгжүүлэх аливаа эрх эсхүл эрх хамгаалах арга хэмжээг хөндөхгүй.
- 36.7 Энэхүү Гэрээний дараах зүйл, заалт Гэрээ цуцалснаас үл хамааран хүчин төгөлдөр хэвээр үлдэнэ. Үүнд: 1 дүгээр зүйл (Нэр томьёоны тайлбар), 12 дугаар зүйл (Оюуны өмч), 17.4 дэх хэсэг (Эрх бүхий этгээдийн хойшлуулах нөхцөлийн нөхөн төлбөр), 17.5 дах хэсэг (Концесс эзэмшигчийн хойшлуулах нөхцөлийн нөхөн төлбөр), 36 дугаар зүйл (Гэрээ цуцлах), 39 дүгээр зүйл (Гэрээ цуцалсантай холбоотой нөхөн төлбөр), 41 дүгээр зүйл (Гэрээ дуусгавар болох эсхүл Гэрээ цуцлах үед Концессын зүйл болон Концесс эзэмшигчийн хөрөнгөөр бий болсон хөрөнгийг буцаан шилжүүлэх), 48 дугаар зүйл (Маргаан шийдвэрлэх), 49 дүгээр зүйл (Гэрээний ашгийн төлөө (арилжааны) шинж чанар), 50 дугаар

зүйл (Баримтлах хууль), 51 дүгээр зүйл (Нууцлал), 55 дугаар зүйл (Гуравдагч тал эрх эдлэхгүй байх), 56 дугаар зүйл (Харилцах хаяг) болон 57 дугаар зүйл (Гэрээний хэл) тус тус багтана.

37. КОНЦЕСС ЭЗЭМШИГЧИЙН ҮҮРГИЙН ЗӨРЧЛИЙН УЛМААС ГЭРЭЭ ЦУЦЛАХ

37.1 Дараах тохиолдлууд “Концесс эзэмшигчийн үүргийн зөрчил”-д тооцогдоно. Үүнд:

37.1.1 Хууль тогтоомж болон энэхүү Гэрээний 5.2.1 - 5.2.6 дах хэсгүүд (Концесс эзэмшигчийн менежмент, үйл ажиллагаанд тавигдах шаардлага), 11 дүгээр зүйл (Концесс эзэмшигчийн эрх үүрэг (11.5.1, 11.5.3, 11.6.1, 11.6.2, 11.6.5, 11.6.8 дах хэсгүүдэд зааснаас бусад)), 12.1 дэх хэсэг (Оюуны өмчийн эрх шилжүүлэх), 15 дугаар зүйл (Концесс эзэмшигчид хориглох зүйл), 16.1.4 / 16.3.1 дэх хэсэг (Нисэх буудлын аюулгүй байдлын хөтөлбөр), 22.1 дэх хэсэг (Нийтлэг үйлчилгээний хангамжийн байгууламжтай холбоотой Концесс эзэмшигчийн үүрэг), 22.3 дах хэсэг (Нийтлэг үйлчилгээний хангамжийн илүүдэл), 23.1 дэх хэсэг (Үйл ажиллагаа, засвар үйлчилгээнд тавигдах шаардлага), 23.3 дах хэсэг (Аюулгүй ажиллагаа болон аюулгүй байдал) болон 44 дүгээр зүйл (Онцгой нөхцөл байдал) –ийг дагаж мөрдөх үүргээ биелүүлээгүй, зөрчсөн;

37.1.2 Концесс эзэмшигч дампуурсан эсвэл татан буугдсан (Эрх бүхий этгээдийн зөвшөөрөлтэй өөрчлөн зохион байгуулагдах асуудал үүнд хамаарахгүй)-тай холбоотой шүүхийн ажиллагаа эхэлсэн;

37.1.3 Энэ Гэрээний 26.2 дах хэсэг (Концессын төлбөр)-т заасны дагуу төлөх Концессын төлбөрийг оруулаад энэхүү Гэрээний дагуу Концесс эзэмшигчийн төлөх, маргаан бүхий төлбөрөөс бусад төлөх хугацаа нь болсон төлбөрийг Талууд харилцан тохиролцсоноос хойш гурван (3) сарын дотор төлөөгүй;

37.1.4 Хууль тогтоомж болон Гэрээнд заасан үндэслэл бүхий шалтгаангүйгээр Консерциумын гишүүд эсхүл Концесс эзэмшигчийн хувьцаа эзэмшигчдийн хооронд маргаан гарсан зэргийн улмаас Нисэх буудлын бизнес хаагдсан эсхүл түдгэлзсэн;

37.1.5 Монгол Улсын Концессын тухай хуулийг харгалзан Концесс эзэмшигч нэг Хувьцаа эзэмшигчтэй болсноос бусад тохиолдолд Хувьцаа эзэмшигчдийн гэрээг дуусгавар болгосон, цуцалсан;

37.1.6 Энэхүү Гэрээний 29.1 дэх хэсэг (Үйл ажиллагаа ба засвар үйлчилгээний тайлан), 29.2 дах хэсэг (Гүйцэтгэлийн тайлан), 29.6 дах хэсэг (Нийцлийн тайлан) болон 24.1 дэх хэсэг (Санхүүгийн тайлан)-ийн дагуу тус тус ирүүлсэн тайлан нь худал бөгөөд хуурамч агуулгатай.

37.2 Концесс эзэмшигчийн үүргийн зөрчил гарсан бол Эрх бүхий этгээд энэ тухай мэдэгдэл (**“Концесс эзэмшигч үүргийн зөрчил гаргасан тухай мэдэгдэл”**) хүргүүлнэ. Тус мэдэгдэлд Концесс эзэмшигчийн үүргийн зөрчил гарсан талаар мэдээллийг зохих хэмжээгээр дэлгэрэнгүй заана.

37.3 Хэрэв:

37.3.1 Концесс эзэмшигч нь Концесс эзэмшигч үүргийн зөрчил гаргасан тухай мэдэгдэл хүлээн авснаас хойш дөчин (40) Ажлын өдрийн дотор Эрх бүхий этгээдэд хүлээн зөвшөөрөгдөхүйц (Эрх бүхий этгээд нь зохистой шаардлага тавьж хандана) зөрчил арилгах хөтөлбөр боловсруулаагүй; эсхүл

37.3.2 Зөрчил арилгах хөтөлбөрийг тус хөтөлбөрт заасан Талуудын тохиролцсон хугацаанд эсхүл Талуудын тохиролцож хойшлуулсан хугацаанд хэрэгжүүлээгүй бол

Эрх бүхий этгээд нь Концесс эзэмшигчид хандан гэрээ цуцлах мэдэгдэл (**“Эрх бүхий этгээдийн гэрээ цуцлах тухай мэдэгдэл”**) гаргах эрхтэй бөгөөд Эрх бүхий этгээдийн гэрээ цуцлах тухай мэдэгдлийг хүлээн авснаас хойш жаран (60) хуанлийн өдрийн сүүлийн өдөр энэхүү Гэрээ цуцлагдах болохыг заасан байна.

37.4 Дор дурдсан тохиолдолд Эрх бүхий этгээд нь УБХОУНОШБ-ын үйл ажиллагааны тасралтгүй байдлыг хангахын тулд энэхүү Гэрээний 11.1 дэх хэсэг (Концесс)-т заасан Концесс эзэмшигчийн чиг үүргийг түр шилжүүлэн авч болно (**“Түр шилжүүлэн авах”**). Үүнд:

37.4.1 энэ Гэрээний 37.1.2, 37.1.4, 37.1.6 дах хэсгүүд (Концесс эзэмшигчийн үүргийн зөрчлийн улмаас гэрээ цуцлах)-ийн дагуу Концесс эзэмшигчийн үүргийн зөрчил гарсан;

37.4.2 Концесс эзэмшигч нь Монгол Улсын Концессын тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.3 дах хэсгийн дагуу Хууль тогтоомжийг удаа дараа ноцтойгоор зөрчсөн;

37.4.3 энэхүү Гэрээний 44 дүгээр зүйл (Онцгой нөхцөл байдал)- т заасны дагуу Онцгой нөхцөл байдал үүссэн;

37.4.4 энэхүү Гэрээний 45.1 дэх хэсэг (Давагдашгүй хүчин зүйл)-т заасны дагуу Давагдашгүй хүчин зүйл тохиолдсон.

37.5 Түр шилжүүлэн авах тохиолдолд:

37.5.1 Эрх бүхий этгээд нь Концесс эзэмшигчийн бүх чиг үүргийг шилжүүлэн авах бөгөөд энэ Гэрээгээр хүлээсэн Концесс эзэмшигчийн эрх, үүргийг хариуцна;

37.5.2 Эрх бүхий этгээд нь энэ Гэрээний 37.3 дах хэсэг (Эрх бүхий этгээдийн гэрээ цуцлах тухай мэдэгдэл)-т заасны дагуу Эрх бүхий этгээдийн гэрээ цуцлах тухай мэдэгдэлд Түр шилжүүлэн авах огноог тусгаж Концесс эзэмшигчид хүргүүлнэ;

37.5.3 Концесс эзэмшигч Эрх бүхий этгээдийн тавьсан хүсэлтийн дагуу хамтран ажиллана;

37.5.4 Концесс эзэмшигч нь энэхүү Гэрээгээр хүлээсэн Буцаан шилжүүлэх үүргээсээ чөлөөлөгдөхгүй;

37.5.5 Концесс эзэмшигч нь энэ Гэрээ болон бүх Зөвшөөрлүүдийн дагуу эдлэх бүх эрхээ Эрх бүхий этгээдэд түр шилжүүлнэ;

37.5.6 Эрх бүхий этгээд нь Түр шилжүүлэн авах хугацаанд үүссэн үр дагаврыг хариуцах боловч Концесс эзэмшигчид учирсан Шууд хохирлоос бусдаар Концесс эзэмшигчид төлбөр төлөх болон бусад эрх хамгаалах арга хэмжээ авах үүрэг хүлээхгүй.

38. ЭРХ БҮХИЙ ЭТГЭЭДИЙН ҮҮРГИЙН ЗӨРЧЛИЙН УЛМААС ГЭРЭЭ ЦУЦЛАХ

38.1 Дараах тохиолдлууд "Эрх бүхий этгээдийн үүргийн зөрчил"-д тооцогдоно. Үүнд:

38.1.1 Эрх бүхий этгээд нь маргаан бүхий төлбөрөөс бусад энэ Гэрээний дагуу төлөх, төлөх хугацаа нь болсон төлбөрийг Талууд харилцан тохиролцсоноос хойш гурван (3) сарын дотор төлөөгүй;

38.1.2 Эрх бүхий этгээд энэхүү Гэрээний 9.6 дах хэсэг (Өрсөлдөх нисэх буудал болон арилжааны боломжуудыг хязгаарлах)-т заасан үүргээ зөрчсөн;

38.1.3 Эрх бүхий этгээд эсхүл аливаа Төрийн эрх бүхий байгууллага эсхүл ЧХОУНБ дор дурдсан зүйл, хэсэгт заасан үүргээ зөрчсөн нь Концесс эзэмшигчийн зүгээс энэхүү Гэрээний дагуу эдлэх эрх, хүлээх үүргээ хэрэгжүүлэх боломжийг хоёр (2) сараас дээш

хугацаагаар үлэмж хэмжээгээр гацаасан эсхүл хэрэгжүүлэх боломжгүй байдалд хүргэсэн. Үүнд:

- (1) 4 дүгээр зүйлийн 4.4, 4.5, 4.7 дах хэсгүүд (Концессын талбай болон Нисэх буудлыг хөгжүүлэх бүс);
- (2) 9.6 дах хэсгээс бусад 9 дүгээр зүйл (Эрх бүхий этгээдийн эрх, үүрэг);
- (3) 10 дугаар зүйл (Төрийн эрх бүхий байгууллага); болон
- (4) 14 дүгээр зүйл (Бизнесийн боломжуудыг ашиглах эрх);

38.1.4 Эрх бүхий этгээд, түүний эрх залгамжлагч Засгийн газрын бүрэн хяналтад байхаа больсон.

38.1.5 аливаа Барилгын бүтцийн алдаа.

38.2 Эрх бүхий этгээдийн үүргийн зөрчил гарсан бол Концесс эзэмшигч энэ тухай мэдэгдэл (**“Эрх бүхий этгээд үүргийн зөрчил гаргасан тухай мэдэгдэл”**) хүргүүлнэ. Тус мэдэгдэлд Эрх бүхий этгээдийн үүргийн зөрчил гарсан тухай мэдээллийг зохих хэмжээгээр дэлгэрэнгүй заана.

38.3 Хэрэв:

38.3.1 Эрх бүхий этгээд нь Эрх бүхий этгээд үүргийн зөрчил гаргасан тухай мэдэгдэл хүлээн авснаас хойш дөчин (40) Ажлын өдрийн дотор Концесс эзэмшигчид хүлээн зөвшөөрөгдөхүйц (Концесс эзэмшигч нь зохистой шаардлага тавьж хандана) зөрчил арилгах хөтөлбөр боловсруулаагүй; эсхүл

38.3.2 Зөрчил арилгах хөтөлбөрийг тус хөтөлбөрт заасан Талуудын тохиролцсон хугацаанд эсхүл Талуудын тохиролцож хойшлуулсан хугацаанд хэрэгжүүлээгүй бол

Концесс эзэмшигч нь Эрх бүхий этгээдэд хандан гэрээ цуцлах мэдэгдэл (**“Концесс эзэмшигчийн гэрээ цуцлах тухай мэдэгдэл”**) гаргах эрхтэй бөгөөд Концесс эзэмшигчийн гэрээ цуцлах тухай мэдэгдлийг хүлээн авснаас хойш жаран (60) хуанлийн өдрийн сүүлийн өдөр энэхүү Гэрээ цуцлагдах болохыг заасан байна.

39. ГЭРЭЭ ЦУЦАЛСАНТАЙ ХОЛБООТОЙ НӨХӨН ТӨЛБӨР

39.1 Үйл ажиллагаа эхлэх өдрөөс өмнө Гэрээ цуцалснаас үүсэх нөхөн төлбөр

39.1.1 Энэхүү Гэрээний 17.6 дах хэсэг (Хойшлуулах нөхцөлийн улмаас гэрээ цуцлах)-т заасны дагуу Үйл ажиллагаа эхлэх өдрөөс өмнө Эрх бүхий этгээдийн хойшлуулах нөхцөлийн улмаас Гэрээг цуцалсан тохиолдолд Эрх бүхий этгээд нь Гэрээний 17.6.2 дах хэсэг (Хойшлуулах нөхцөлийн улмаас гэрээ цуцлах)-т заасан төлбөрийг Концесс эзэмшигчид төлнө.

39.1.2 Энэхүү Гэрээний 17.6 дах хэсэг (Хойшлуулах нөхцөлийн улмаас гэрээ цуцлах)-т заасны дагуу Үйл ажиллагаа эхлэх өдрөөс өмнө Концесс эзэмшигчийн хойшлуулах нөхцөлийн улмаас Гэрээг цуцалсан тохиолдолд Концесс эзэмшигч нь Гэрээний 17.6.3 дах хэсэг (Хойшлуулах нөхцөлийн улмаас гэрээ цуцлах)-т заасан төлбөрийг Эрх бүхий этгээдэд төлнө.

39.2 Концесс эзэмшигчийн үүргийн зөрчлийн улмаас Гэрээ цуцалснаас үүсэх нөхөн төлбөр

39.2.1 Энэхүү Гэрээний 37 дугаар зүйл (Концесс эзэмшигчийн үүргийн зөрчлийн улмаас гэрээ цуцлах)-ийн дагуу Концесс эзэмшигчийн үүргийн зөрчлийн улмаас Гэрээг цуцалсан тохиолдолд, Концесс эзэмшигч нь Концесс эзэмшигчийн хөрөнгөөр бий болсон эд хөрөнгийг шилжүүлнэ. Концесс эзэмшигч нь (i) Концесс эзэмшигчийг сольж өөр этгээдийг шинээр томилохтой холбоотойгоор Эрх бүхий этгээдэд учрах нэг (1) сая ам.доллараас хэтрэхгүй зардлыг төлж, (ii) Концесс эзэмшигчийн гаргасан хувьцааны зуун хувь (100%)-ийг Эрх бүхий этгээдэд үнэ төлбөргүйгээр нөхөн төлбөрт шилжүүлнэ. Концесс эзэмшигч нь Концесс эзэмшигч үүргийн зөрчил гаргасан тухай мэдэгдлийг хүлээн авснаас хойш зөрчил арилгах хөтөлбөрийг амжилттай хэрэгжүүлж дуусах хүртэл хугацаанд Концесс эзэмшигчийн Хувьцаа эзэмшигчдэд ногдол ашиг хуваарилах буюу зарлахгүй (томоохон засвар үйлчилгээний нөөцийн данснаас ногдол ашиг хуваарилах асуудал үүнд хамаарна).

39.2.2 Гэрээний 37.1.2 дах хэсэг (Концесс эзэмшигчийн үүргийн зөрчлийн улмаас гэрээ цуцлах)-т заасан зөрчлийн улмаас Гэрээг цуцалсан бол энэхүү 39.2.1 дэх хэсэг үйлчилнэ.

39.3 Эрх бүхий этгээдийн үүргийн зөрчлийн улмаас Гэрээ цуцалснаас үүсэх нөхөн төлбөр

39.3.1 Энэхүү Гэрээний 38 дугаар зүйл (Эрх бүхий этгээдийн үүргийн зөрчлийн улмаас гэрээ цуцлах)-ийн дагуу Эрх бүхий этгээдийн үүргийн зөрчлийн улмаас Гэрээг цуцалсан тохиолдолд Концесс эзэмшигч нь Концессын зүйл болон Концесс эзэмшигчийн

хөрөнгөөр бий болсон эд хөрөнгийг Эрх бүхий этгээдэд үнэ төлбөргүйгээр шилжүүлэх (тодруулбал, Эрх бүхий этгээдийн үүргийн зөрчлийн үр дүнд Концесс эзэмшигч татан буугдана) ба Эрх бүхий этгээд нь Концесс эзэмшигчид дараах төлбөрийг төлнө. Үүнд:

- (1) Эхлэлтийн хөрөнгө оруулалт; НЭМЭХ НЬ
- (2) Эхлэлтийн хөрөнгө оруулалттай тэнцүү хэмжээ бүхий Гэрээг цуцалсны улмаас үүссэн ашгийн алдагдал.

Эрх бүхий этгээдийн үүргийн зөрчил Концессын хугацааны сүүлийн жилд тохиолдсон бол Эрх бүхий этгээд нь зөвхөн Эхлэлтийн хөрөнгө оруулалтыг төлнө.

39.4 Гэрээ цуцалсантай холбоотойгоор төлөх төлбөрийн хэмжээг тооцоолох

39.4.1 Үүргийн зөрчил гаргаагүй Тал нь үүргийн зөрчил гаргасан Талын төлбөл зохих төлбөрийн хэмжээг энэ Гэрээний 39 дүгээр зүйл (Гэрээ цуцалсантай холбоотой нөхөн төлбөр)-ийн дагуу тооцоолох ба уг тооцооллыг түүнийг нотлох баримт бичгийн хамтаар (олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрөгдсөн аудитын байгууллагаар баталгаажуулсан санхүүгийн тайлан зэрэг хамаарах боловч үүгээр хязгаарлагдахгүй) үүргийн зөрчил гаргасан Талд хүргүүлнэ.

39.4.2 Үүргийн зөрчил гаргасан Тал нь холбогдох төлбөрийг үүргийн зөрчил гаргаагүй Талаас ирүүлсэн хүчин төгөлдөр нэхэмжлэхийг хүлээн авснаас хойш хорин (20) Ажлын өдрийн дотор төлнө. Төлбөл зохих үнийн дүнтэй холбоотой маргаан үүсвэл үүргийн зөрчил гаргасан Тал нь төлбөрийн үл маргах хэсгийг төлөх ба маргаантай хэсгийг Гэрээний 48 дугаар зүйл (Маргаан шийдвэрлэх)-ийн дагуу шийдвэрлүүлнэ.

39.5 Энэхүү Гэрээний 37.1 (Концесс эзэмшигчийн үүргийн зөрчлийн улмаас гэрээ цуцлах) болон 38.1 дэх хэсэг (Эрх бүхий этгээдийн үүргийн зөрчлийн улмаас гэрээ цуцлах)-т тус тус заасны дагуу үүргийн зөрчил гаргасан бөгөөд Зөрчил арилгах хөтөлбөрийг амжилттай хэрэгжүүлсэн Тал нь зөвхөн тухайн зөрчилтэй холбоотойгоор нөгөө талд учирсан Шууд хохирлыг холбогдох шаардлагын талаарх мэдэгдлийг нотлох баримтын хамт хүлээн авсан өдрөөс хойш ер (90) хоногийн дотор нөхөн төлнө.

АРАВДУГААР БҮЛЭГ. КОНЦЕССЫН ЗҮЙЛИЙГ БУЦААН ШИЛЖҮҮЛЭХ

40. КОНЦЕССЫН ЗҮЙЛ БОЛОН КОНЦЕСС ЭЗЭМШИГЧИЙН ХӨРӨНГӨӨР БИЙ БОЛСОН ЭД ХӨРӨНГИЙГ БУЦААН ШИЛЖҮҮЛЭХ

40.1 Концесс эзэмшигч нь Гэрээ дуусгавар болох эсхүл Гэрээг цуцлах үед Концессын зүйл болон оюуны өмч зэрэг Концесс эзэмшигчийн хөрөнгөөр бий болсон эд хөрөнгө, Концессын талбай, Нисэх буудлын бизнесийг Эрх бүхий этгээд эсхүл түүний нэр заасан этгээдэд буцаан шилжүүлнэ.

40.2 Концесс эзэмшигч нь дараах зүйлсийг шилжүүлэхгүй:

40.2.1 Концессын зүйлд хамааралтай аливаа бүх эд хөрөнгийн эрхийг Концессын хугацааны туршид ямар ч тохиолдолд;

40.2.2 Гэрээний хугацаа дуусгавар болох эсхүл Гэрээ цуцлагдах өдрөөс өмнөх сүүлийн нэг жилийн хугацаанд Концесс эзэмшигчийн хөрөнгөөр бий болсон эд хөрөнгийн өмчлөх эрх болон бусад эд хөрөнгийн эрхийг Эрх бүхий этгээдийн зөвшөөрөлгүйгээр Нэгдмэл сонирхолтой этгээдийг оруулаад аливаа гуравдагч этгээдэд шилжүүлэхгүй.

40.3 Концесс эзэмшигч нь Гэрээ дуусгавар болох эсхүл Гэрээг цуцлах үед Концессын зүйл болон оюуны өмч зэрэг Концесс эзэмшигчийн хөрөнгөөр бий болсон эд хөрөнгө, Концессын талбай, Нисэх буудлын бизнестэй холбоотой бүх эрх, эд хөрөнгийн эрх болон ашиг сонирхлыг Эрх бүхий этгээд эсхүл түүний нэр заасан этгээдэд үнэ төлбөргүй шилжүүлэх үүрэгтэй боловч энэ нь энэхүү Гэрээний 17 дугаар зүйл (Үйл ажиллагаа эхлэх өдрийг сунгах, нөхөн төлбөр төлөх, хойшлуулсны улмаас гэрээ цуцлах) эсхүл 39 дүгээр зүйл (Гэрээ цуцалсантай холбоотой нөхөн төлбөр)-д заасны дагуу Концесс эзэмшигчийн нөхөн төлбөр авах эрхийг хөндөхгүй.

40.4 Талуудын хооронд ойлголтын зөрүү үүсч, маргаан гарснаас үл хамааран Концесс эзэмшигч нь Нисэх буудлын бизнесийн үйл ажиллагааг тасалдуулахгүй, зардал багатай байдлаар буцаан шилжүүлнэ.

41. ГЭРЭЭ ДУУСГАВАР БОЛОХ ЭСХҮЛ ГЭРЭЭ ЦУЦЛАХ ҮЕД КОНЦЕССЫН ЗҮЙЛ БОЛОН КОНЦЕСС ЭЗЭМШИГЧИЙН ХӨРӨНГӨӨР БИЙ БОЛСОН ЭД ХӨРӨНГИЙГ БУЦААН ШИЛЖҮҮЛЭХ

41.1 Гэрээ дуусгавар болох эсхүл гэрээ цуцлах үед Концесс эзэмшигч нь энэхүү Гэрээний 10 дугаар бүлэг (Концессын зүйл болон Концесс эзэмшигчийн хөрөнгөөр бий болсон эд хөрөнгийг буцаан шилжүүлэх)-т заасны дагуу Эрх бүхий этгээдэд Нисэх буудлын бизнесийг шилжүүлэх үүрэгтэй ба Гэрээний 11.7 дах хэсэг (Буцаан шилжүүлэх үүрэг)-д

зааснаас бусад тохиолдолд Концесс эзэмшигч Эрх бүхий этгээд эсхүл түүний нэр заасан этгээдэд шилжүүлсэн эд хөрөнгөтэй холбоотой баталгаа гаргахгүй ба тийнхүү шилжүүлсний дараа тэдгээр эд хөрөнгөтэй холбоотой хариуцлага хүлээхгүй.

41.2 Гэрээ дуусгавар болох эсхүл Гэрээ цуцлагдах өдөр Концесс эзэмшигч нь Концессын зүйл болон Концесс эзэмшигчийн хөрөнгөөр бий болсон эд хөрөнгийн хувьд эдлэх эрх, ашиг сонирхлыг Эрх бүхий этгээдэд энэхүү 41 дүгээр зүйл (Гэрээ дуусгавар болох эсхүл гэрээ цуцлах үед Концессын зүйл болон Концесс эзэмшигчийн хөрөнгөөр бий болсон эд хөрөнгийг буцаан шилжүүлэх)- ийн дагуу шилжүүлнэ.

41.3 Концесс эзэмшигч нь Концессын зүйл болон Концесс эзэмшигчийн хөрөнгөөр бий болсон эд хөрөнгийн хувьд эдлэх өөрийн эрх, ашиг сонирхлыг Буцаан шилжүүлэхэд тавигдах шаардлагад нийцүүлэн, аливаа барьцаа, сөрөг шаардлага, хугацаа хэтэрсэн өр төлбөргүйгээр Эрх бүхий этгээдэд үнэ төлбөргүй шилжүүлнэ. Талууд Буцаан шилжүүлэхэд тавигдах шаардлага болон Буцаан шилжүүлэх төлөвлөгөөг Үйл ажиллагаа эхлэх өдрөөс хойш хоёр (2) жилийн дотор харилцан тохиролцох ба Буцаан шилжүүлэх төлөвлөгөө нь Буцаан шилжүүлэхэд тавигдах шаардлагад үндэслэсэн байна.

41.4 Гэрээний 6 дугаар зүйл (Концессын хугацаа)-ийн дагуу Концессын хугацаа дуусгавар болохтой холбоотойгоор:

41.4.1 Хугацаа дуусгавар болох өдрөөс хамгийн багадаа арван хоёр (12) сарын өмнө Эрх бүхий этгээд болон Концесс эзэмшигч нь Концессын зүйл болон Концесс эзэмшигчийн хөрөнгөөр бий болсон эд хөрөнгийг буцаан шилжүүлэх асуудлаар Буцаан шилжүүлэх комисс томилно;

41.4.2 Хугацаа дуусгавар болох өдрөөс 6 сараас доошгүй хугацааны өмнө Талууд Буцаан шилжүүлэх төлөвлөгөөг хэрэгжүүлж эхэлнэ;

41.4.3 Хугацаа дуусгавар болох өдрөөс гурван (3) сарын өмнө Буцаан шилжүүлэх Комисс нь Буцаан шилжүүлэхэд тавигдах шаардлага болон Буцаан шилжүүлэх төлөвлөгөөнд үндэслэн УБХОУНОШБ-ын үйл ажиллагааны болон үйлчилгээний хэсгийг Гэрээний хугацаа дуусгавар болох өдрийн 23:59 цагаас өмнө Эрх бүхий этгээдэд хэрхэн шилжүүлэх талаар нарийвчилсан журам боловсруулна.

41.5 Гэрээг хугацаанаас нь өмнө цуцлах тохиолдолд:

41.5.1 Гэрээг хугацаанаас өмнө цуцлах тухай аль нэг Талын гаргасан мэдэгдлийг хүлээн авснаас хойш таван (5) Ажлын өдрийн дотор



Талууд Концессын зүйл болон Концесс эзэмшигчийн хөрөнгөөр бий болсон эд хөрөнгийг Буцаан шилжүүлэх комисс байгуулна;

41.5.2 Гэрээг хугацаас нь өмнө цуцлах мэдэгдэл хүргүүлсний дараа аль болох боломжит богино хугацаанд:

- (1) Талууд Буцаан шилжүүлэх төлөвлөгөөг хэрэгжүүлж эхэлнэ;
- (2) Буцаан шилжүүлэх комисс нь Буцаан шилжүүлэхэд тавигдах шаардлага болон Буцаан шилжүүлэх төлөвлөгөөнд үндэслэн УБХОУНОШБ-ын үйл ажиллагааны болон үйлчилгээний хэсгийг Гэрээ цуцлагдах өдрийн 23:59 цагаас өмнө Эрх бүхий этгээдэд хэрхэн шилжүүлэх талаар нарийвчилсан журам боловсруулна;
- (3) Буцаан шилжүүлэх комисс Гэрээ цуцлагдах өдрөөс өмнө Буцаан шилжүүлэх төлөвлөгөөг хэрэгжүүлж дуусна.

41.6 Энэхүү Гэрээний 41.4 эсхүл 41.5 дах хэсэг (Гэрээ дуусгавар болох эсхүл гэрээ цуцлах үед Концессын зүйл болон Концесс эзэмшигчийн хөрөнгөөр бий болсон эд хөрөнгийг буцаан шилжүүлэх)-ийн дагуу Концессын зүйл болон Концесс эзэмшигчийн хөрөнгөөр бий болсон эд хөрөнгийг шилжүүлэх үед Талууд буцаан шилжүүлэх ажиллагааг хэрэгжүүлж дууссан тухай гэрчилгээ үйлдэнэ. Тус гэрчилгээг үйлдсэнээр Концессын зүйл болон Концесс эзэмшигчийн хөрөнгөөр бий болсон эд хөрөнгөтэй холбоотой бүх эрсдэл, засвар арчилгаа, аюулгүй ажиллагаа, аюулгүй байдал, холбогдох зардал Эрх бүхий этгээд эсхүл түүний санал болгосон этгээдэд шилжинэ.

41.7 Концесс эзэмшигч нь Гэрээ хүчин төгөлдөр болох өдрөөс Гэрээ цуцлах эсхүл дуусгавар болох хүртэл хугацаанд хамаарах энэхүү Гэрээний дагуу Концесс эзэмшигчийн гүйцэтгэсэн бүх ажлыг үнэлж, дүгнэх зорилгоор эцсийн тайлан (**“Концесс эзэмшигчийн эцсийн тайлан”**)-г:

41.7.1 Гэрээний хугацаа дуусгавар болохоос хоёр (2) сарын өмнө; эсхүл

41.7.2 Гэрээг хугацаанаас нь өмнө цуцлах тохиолдолд хугацаанаас өмнө цуцлах тухай мэдэгдэл хүргүүлснээс хойш нэг (1) сарын дотор хүргүүлнэ.

41.8 Концесс эзэмшигчийн эцсийн тайлан, Үйл ажиллагаа ба засвар үйлчилгээний тайлан, Гүйцэтгэлийн тайлан, Нийцлийн тайлан, Мастер төлөвлөгөө, Санхүүгийн төлөвлөгөө, Санхүүгийн жилийн тайлан, Шилжилтийн төлөвлөгөө, Буцаан шилжүүлэхэд тавигдах шаардлага,

Буцаан шилжүүлэх төлөвлөгөө зэрэг нь Концесс эзэмшигчийн гэрээнд заасан эрх, үүргээ хэрэгжүүлсэн байдлыг болон энэ Гэрээнд заасан бусад асуудлыг үнэлэх үндэслэл болно. Концесс эзэмшигч болон Эрх бүхий этгээд Гэрээний гүйцэтгэлийн үнэлгээг Эцсийн тайлан хүлээн авснаас хойш нэг (1) сарын дотор хийх ба Талууд ийнхүү үнэлж, дүгнэхээс үндэслэлгүйгээр татгалзаж болохгүй.

42. ГУРАВДАГЧ ЭТГЭЭДТЭЙ БАЙГУУЛСАН ГЭРЭЭ БОЛОН БУСАД ЗҮЙЛ

42.1 Гэрээ дуусгавар болох эсхүл гэрээ цуцлах үед Концесс эзэмшигч нь энэхүү 42 дугаар зүйл (Гуравдагч этгээдтэй байгуулсан гэрээ болон бусад зүйл)-д заасан баримт бичиг болон энэхүү Гэрээний Гэрээний 24.2 дах хэсэг (Бүртгэл)-т заасан бүртгэлийн баримт бичиг зэргийг багтаагаад Концесс эзэмшигчийн бүх бичиг баримтыг Эрх бүхий этгээдэд шилжүүлнэ.

42.2 Эрх бүхий этгээд нь Концесс эзэмшигч болон гуравдагч этгээдийн хооронд Нисэх буудлын бизнесийн үйл ажиллагаатай холбоотой байгуулагдсан аливаа гэрээ, хэлцэл, тохиролцоо, тушаал, шийдвэрийг хариуцахгүй бөгөөд тэдгээрийг дагаж мөрдөх үүрэг хүлээхгүй. Концесс эзэмшигч нь Концессын хугацаанд хамаарах Концесс эзэмшигч болон гуравдагч этгээдийн хооронд байгуулагдсан аливаа гэрээ, хэлцэл, тохиролцоо, тушаал, шийдвэрээс үүдэлтэй нөхөн төлбөр, шаардлагыг Эрх бүхий этгээд хариуцахгүй, Концесс эзэмшигч хариуцахыг баталж байна.

42.3 Концесс эзэмшигч нь Концесс эзэмшигч болон гуравдагч этгээдийн хооронд Нисэх буудлын бизнесийн үйл ажиллагаатай холбоотой байгуулагдсан аливаа гэрээ, хэлцэл, тохиролцоо, тушаал, шийдвэрийг Концессын хугацаанд хэрэгжүүлж дуусгана. Концесс эзэмшигч нь Нисэх буудлын үйл ажиллагааны тогтортой хэвийн ажиллагааг хадгалах зорилгоор Эрх бүхий этгээд эсхүл түүний томилсон этгээдийг гуравдагч этгээдтэй байгуулсан гэрээний талаар шаардлагатай мэдээллээр хангана. Нисэх буудлын бизнесийн үйл ажиллагаатай холбоотой гуравдагч этгээдтэй хийсэн аливаа гэрээ, тохиролцоо, тушаал, шийдвэр нь Эрх бүхий этгээдэд үүрэг үүсгэхгүй.

АРВАНЭГДҮГЭЭР БҮЛЭГ. БАТАЛГАА МЭДЭГДЭЛ

43. БАТАЛГАА, МЭДЭГДЭЛ

43.1 Эрх бүхий этгээдийн баталгаа мэдэгдэл

Эрх бүхий этгээд нь дараах баталгаа мэдэгдлийг үргэлжилсэн байдлаар (Гэрээ байгуулсан өдрийн байдлаар Баталгаа мэдэгдлийг гаргасан гэж тусгайлан зааснаас бусад тохиолдолд) гаргаж байна. Үүнд:

- 43.1.1 Эрх бүхий этгээд нь Засгийн газрын байгууллага ба Засгийн газрыг төлөөлөн, түүний нэрийн өмнөөс энэхүү Гэрээг байгуулах болон энэхүү Гэрээ, Монгол Улсын Концессын тухай хуулиар олгосон бүх эрх үүргийг хэрэгжүүлэх эрхийг Засгийн газраас Эрх бүхий этгээдэд олгосон болно;
- 43.1.2 Энэхүү Гэрээнд заасан үүргээ хэрэгжүүлэх нь холбогдох Хууль тогтоомж болон бусад гэрээний үүргийг зөрчихгүй;
- 43.1.3 Эрх бүхий этгээд болон холбогдох Төрийн эрх бүхий байгууллагууд нь Нисэх буудлын бизнес эрхлэх болон Нисэх буудлын үйлчилгээ явуулахад шаардлагатай тусгай зөвшөөрөл, бусад шаардлагатай зөвшөөрлийг олгох эрхтэй болно;
- 43.1.4 ИНЕГ-ийг багтаагаад холбогдох Төрийн эрх бүхий байгууллагууд нь Концессын зүйлийг хууль ёсоор эзэмшдэг ба эзэмших бүрэн эрхтэй бөгөөд аливаа барьцааны эрх буюу бусад байдлаар түүнд үүрэг үүсгээгүй болно;
- 43.1.5 Эрх бүхий этгээд болон/эсхүл Төрийн эрх бүхий байгууллагууд нь Концесс эзэмшигчийн зүгээс энэ Гэрээний Хавсралт 2 (Төлбөр хураамж)-д заасан Нисэх буудлын төлбөр, хураамжийг ногдуулах болон хураан авах онцгой эрхийг энэхүү Гэрээний хүрээнд зөвшөөрөх эрх хэмжээтэй болно;
- 43.1.6 энэхүү Гэрээ байгуулагдсан өдрийн байдлаар Эрх бүхий этгээд (зохих тодруулга явуулсны үр дүнд) нь доорх зүйлст нөлөөлөх эсхүл түүнтэй холбоотой ямар нэг үйл ажиллагаа, үйлдэл, шаардлага үүссэн эсхүл шийдвэрлэгдэж байгаа талаар мэдээлэлгүй болно. Үүнд:
 - (1) Консорциумт энэхүү Гэрээгээр эрх олгосон үнэлгээ болон эрх олгох үйл ажиллагаа;
 - (2) энэхүү Гэрээ болон үүнтэй холбоотой байгуулагдсан бусад гэрээ;
 - (3) Нисэх буудлын талбай, үүний дотор хүрээлэн буй орчны бохирдол болон өмчлөх эрх, эд хөрөнгийн эрхтэй холбоотой;
 - (4) Концессын зүйл.

43.1.7 энэхүү Гэрээ байгуулагдсан өдрийн байдлаар холбогдох Төрийн эрх бүхий байгууллага нь Концессын зүйлийн өмчлөх эрхийг хууль ёсоор, бүрэн эзэмшдэг бөгөөд түүнтэй холбоотой аливаа барьцааны болон бусад төрлийн хөрөнгийн эрх үүсгээгүй;

43.1.8 Нисэх буудлын удирдлага, үйлчилгээ, үйл ажиллагаа, засвар үйлчилгээтэй холбоотой Эрх бүхий этгээд болон Төрийн эрх бүхий байгууллага эсхүл ЧХОУНБ-ын зүгээс нэг тал болж оролцсон аливаа томоохон хэмжээнийгэрээ, түрээс, болон бусад бичгээр үйлдсэн тохиролцоо (Концессын зүйлийн нэг хэсэг болж Концесс эзэмшигчид шилжүүлж байгаагаас бусад) байхгүй;

43.2 Концесс эзэмшигчийн баталгаа мэдэгдэл

Концесс эзэмшигч нь өөрийн болон Консорциум ТЗК, Консорциумын гишүүн тус бүрийн өмнөөс дараах баталгаа мэдэгдлийг үргэлжилсэн байдлаар (Гэрээ байгуулсан өдрийн байдлаар Баталгаа мэдэгдлийг гаргасан гэж тусгайлан зааснаас бусад тохиолдолд) гаргаж байна. Үүнд:

43.2.1 Монгол Улсын эсхүл Япон Улсын хууль тогтоомжийн дагуу байгуулагдаж бүртгүүлсэн, албан ёсны хаягтай, үйл ажиллагаа явуулах гэрчилгээтэй ба өөрийн бизнесийг явуулах компанийн эрх хэмжээ бүхий хуулийн этгээд болно;

43.2.2 төлбөрийн чадвартай, татан буугдаагүй, дампуурлын хэрэг үүсгээгүй, хэрэг гүйцэтгэгч томилогдоогүй бөгөөд энэ Гэрээг амжилттай хэрэгжүүлэхэд сөргөөр нөлөөлөхүйц аливаа шүүхийн ажиллагаа явагдаагүй ба нэмэлт хөрөнгө оруулалтыг хариуцна;

43.2.3 Концесс эзэмшигчийн хувьд энэхүү Гэрээг байгуулах, түүгээр хүлээсэн үүргийг хэрэгжүүлэх бүрэн эрхтэй ба Концесс эзэмшигч, Консорциум ТЗК, Консорциум нь Концесс эзэмшигчийг энэхүү Гэрээг байгуулах талаар эрх олгоход шаардлагатай бүх арга хэмжээг авсан;

43.2.4 Энэхүү Гэрээг байгуулах, хэрэгжүүлэх нь түүний үүсгэн байгуулах баримт, бичгийг зөрчихгүй;

43.2.5 Энэхүү Гэрээ нь өөрт нь болон түүний эд хөрөнгөд үүрэг хүлээлгэсэн аливаа гэрээ, баримт бичигтэй зөрчилдөөгүй ба гэрээний үүргийг зөрчих нөхцөл байдалд хүргэхгүй, аливаа хөрөнгийн хувьд барьцааны эрх үүсгэхгүй эсхүл эд хөрөнгө болон эд хөрөнгийн эрхтэй холбоотой гэрээ, харилцан ойлголцлын санамж бичиг, тохиролцоо, тушаал шийдвэрийг зөрчихгүй; ба

43.2.6 Энэхүү Гэрээг байгуулах, хэрэгжүүлэх нь аливаа хууль тогтоомжтой зөрчилдөхгүй ба бусад гэрээний үүргийг зөрчихгүй.

АРВАНХОЁРДУГААР БҮЛЭГ. ОНЦГОЙ НӨХЦӨЛ БАЙДАЛ, ДАВАГДАШГҮЙ ХҮЧИН ЗҮЙЛ, ДААТГАЛ

44. ОНЦГОЙ НӨХЦӨЛ БАЙДАЛ

44.1 Концесс эзэмшигч нь Нисэх буудлын онцгой байдлын төлөвлөгөөг Монгол Улсын Иргэний нисэхийн багц дүрэм – 139 болон Хууль тогтоомжид заасан шаардлагад нийцүүлэн боловсруулж, батлуулна.

44.2 Онцгой нөхцөл байдал үүссэн үед дараах арга хэмжээг авч хэрэгжүүлнэ. Үүнд:

44.2.1 Концесс эзэмшигч нь Концессын зүйл болон Концессын талбайтай холбоотой Нисэх буудлын онцгой байдлын төлөвлөгөөнд заасан арга хэмжээг хариуцан зохион байгуулна;

44.2.2 Эрх бүхий этгээд болон/эсхүл холбогдох Төрийн эрх бүхий байгууллага нь Нисэх буудлын онцгой байдлын төлөвлөгөөнд заасан бүхий л үйл ажиллагааг Нисэх буудлын талбайн Концессын зүйл болон Концессын талбайгаас бусад хэсэгт хариуцан зохион байгуулна;

44.2.3 Концесс эзэмшигч нь нөлөөллийн хүчин зүйлсийг ангилж, түүнтэй холбоотой эрсдэлийг бууруулах үр дүнтэй арга хэмжээ авч хэрэгжүүлэх үүрэгтэй.

44.3 Талууд Холбогдох Төрийн эрх бүхий байгууллагууд (цагдаа, тагнуул, онцгой байдал, мэргэжлийн хяналтын чиг үүргийн байгууллагууд)-аас УБХОУНОШБ-д үүсч болох Онцгой нөхцөл байдлаас урьдчилан сэргийлэх онцгой байдлын арга хэмжээ авч хэрэгжүүлэхэд туслалцаа үзүүлж ажиллах, Онцгой нөхцөл байдал бий болсон тохиолдолд шаардлагатай бол УБХОУНОШБ-ын үйл ажиллагааг хаах, түр хугацаагаар зогсооход Талууд холбогдох Төрийн эрх бүхий байгууллагуудтай хамтарч ажиллахыг үүгээр хүлээн зөвшөөрөв.

45. ДАВАГДАШГҮЙ ХҮЧИН ЗҮЙЛ

45.1 Энэхүү Гэрээний хүрээнд **Давагдашгүй хүчин зүйлийн тохиолдол** гэж Талуудын үндэслэл бүхий хяналтаас гадуур бий болсон, түүнээс урьдчилан сэргийлэх буюу зайлсхийх боломжгүй бөгөөд Талууд өөрсдийн зүгээс тэдгээр үйл явдлын нөлөөллөөс сэргийлэх талаар зохих шаардлагатай арга хэмжээг авсан бөгөөд энэхүү Гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэх боломжид саад учруулсан нөхцөл байдлыг ойлгоно.

“Давагдашгүй хүчин зүйлийн тохиолдол”-д дараах нөхцөл байдал хамаарна. Үүнд:

- 45.1.1 нийтийг хамарсан үймээн, дайн, уулгалан довтлох, дайн зарласан эсэхээс үл хамааран хийсэн байлдааны үйл ажиллагаа, терроризм буюу алан хядах ажиллагаа, иргэний дайн, бослого, хувьсгал, цэргийн болон бусад хүчийг ашиглан хийх төрийн эргэлт, төрийн эрх мэдлийг хууль бусаар булаан авах;
 - 45.1.2 цацраг идэвхт бодисын тархалт, хордлого, цөмийн болон хорт бодис дэлбэрснээс үүдсэн цацраг идэвхт бодисын тархалт, цөмийн хог хаягдал зэргээс үүссэн бохирдол, бусад аливаа тэсэрч дэлбэрэх болон цөмийн эд материал бодисоос үүссэн аюултай нөхцөл;
 - 45.1.3 газар хөдлөлт, үер, гал түймэр болон бусад цаг уур, байгаль орчны онц ноцтой нөхцөл байдал;
 - 45.1.4 УБХОУНОШБ-ын үйл ажиллагааг зогсоох хэмжээний үр дагавар бүхий байгаль орчны нөхцөл байдал, археологийн олдвор болон байгалийн баялаг илэрсэн;
 - 45.1.5 Гадаад улсын зүгээс хил хаасан, иргэний нислэгийн харилцааг үргэлжүүлээгүй буюу зогсоосон;
 - 45.1.6 халдварт өвчин, тахал;
 - 45.1.7 аливаа Эд хөрөнгө хураах, дайчлан авах тохиолдол.
- 45.2 Аль нэг талын байгуулсан гэрээний нөгөө тал болох гуравдагч этгээд гэрээний үүргээ биелүүлээгүй нь дээр дурдсан Давагдашгүй хүчин зүйлээс шалтгаалснаас бусад тохиолдолд Давагдашгүй хүчин зүйлд тооцогдохгүй.
- 45.3 Давагдашгүй хүчин зүйл тохиолдсон бол Давагдашгүй хүчин зүйлийн нөлөөлөлд өртсөн тал нь нөгөө талдаа тухайн Давагдашгүй хүчин зүйл болон түүний энэхүү Гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэх боломжид үзүүлж буй нөлөө болон Давагдашгүй хүчин зүйлийн үргэлжлэх хугацааны төсөөллийн талаар нэн даруй бичгээр мэдэгдэнэ (**“Давагдашгүй хүчин зүйлийн тухай мэдэгдэл”**).
- 45.4 Давагдашгүй хүчин зүйлийн нөлөөнд өртсөн тал нь тухайн Давагдашгүй хүчин зүйлийн нөлөөнд өртсөн үүргийн биелэлтээс чөлөөлөгдөх ба Давагдашгүй хүчин зүйлийн нөлөөлөлд өртөөгүй үүргээ хэвээр үргэлжлүүлэн гүйцэтгэнэ. Давагдашгүй хүчин зүйл арилсны дараа аль

болох боломжит богино Гэрээнд заасан бүх үүргээ үргэлжлүүлэн гүйцэтгэнэ. Эрх бүхий этгээд нь Концесс эзэмшигчийн чөлөөлөгдөж буй үүрэг зэргийг багтаасан Давагдашгүй хүчин зүйлийн тухай мэдэгдэл болон түүний агуулгыг хүлээн авсныг үндэслэлгүй байдлаар татгалзахгүйгээр хүлээн зөвшөөрнө.

45.5 Давагдашгүй хүчин зүйлийн нөлөөлөлд өртсөн тал нь Давагдашгүй хүчин зүйл тохиолдохоос өмнө үүссэн төлбөрийн үүргээс чөлөөлөгдөхгүй.

45.6 Давагдашгүй хүчин зүйл нь 120 (зуун хорь) өдрөөс илүү хугацаагаар үргэлжлэх төлөвтэй гэж талууд дүгнэсэн, эсхүл Давагдашгүй хүчин зүйл бодитоор ийм хугацаанд үргэлжлэх тохиолдолд Концессын хугацааг уг Давагдашгүй хүчин зүйлийн улмаас тасалдсан хугацаанаас багагүй хугацаагаар сунгана.

45.7 Давагдашгүй хүчин зүйлийн тухай мэдэгдэл хүргүүлснээс хойш тухайн Давагдашгүй хүчин зүйл зуун наян (180) хоногоос илүү хугацаагаар үргэлжилсэн бол аль ч тал нь Гэрээг цуцлах эрхтэй. Давагдашгүй хүчин зүйлийн улмаас бий болсон хохирлыг Концесс эзэмшигчид нөхөн төлөхгүй байхаар Талууд үүгээр тохиролцов.

46. ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ӨӨРЧЛӨЛТ

46.1 Зөвхөн Хууль тогтоомжийн өөрчлөлтийн улмаас, Концесс эзэмшигчийн зардал өссөн, цэвэр ашиг буурсан эсхүл нийт санхүүгийн нөлөөллийн хувьд өмнөх Концессын жилтэй харьцуулахад арван хоёр аравны таван хувь (12.5%)-аар хэтэрсэн нөлөө бүхий санхүүгийн бусад хүндрэлтэй тулгарсан бол Концесс эзэмшигч нь энэ тухай Эрх бүхий этгээдэд мэдэгдэл хүргүүлж, Концесс эзэмшигчийг санхүүгийн хувьд дээр дурдсан зардал нэмэгдүүлсэн, ашиг бууруулсан эсхүл бусад санхүүгийн хүндрэлд хүргэсэн Хууль тогтоомжийн өөрчлөлт ороогүй байсан бол байх байсан нөхцөл байдалд хүргэхэд шаардлагатай нэмэлт, өөрчлөлтийг Гэрээнд оруулах санал гаргаж болно. Концесс эзэмшигчийн мэдэгдлийн үндсэн дээр Талууд мэдэгдэл хүргүүлснээс хойш гучин (30) өдрөөс хэтрүүлэхгүйгээр аль болох боломжит богино хугацааны дотор уулзаж, энэхүү Гэрээнд оруулах нэмэлт, өөрчлөлт эсхүл бусад харилцан тохиролцсон арга хэмжээний талаар тохиролцох ба 90 хоногийн дотор ийнхүү тохиролцоонд хүрч чадаагүй бол асуудлыг энэ Гэрээний 48 дугаар зүйл (Маргаан шийдвэрлэх)-ийн дагуу шийдвэрлүүлнэ. Эргэлзээ төрүүлэхээс зайлсхийх зорилгоор дурдахад, энэхүү 46.1 дэх хэсэг (Хууль тогтоомжийн өөрчлөлт) нь Концесс эзэмшигчийн энэ Гэрээгээр хүлээсэн үүргээ гүйцэтгэхэд гарах зардалд шууд нөлөөлөх Хууль тогтоомжийн өөрчлөлтийн хүрээнд хязгаарлагдахаар Талууд тохиролцсон болно.

46.2 Зөвхөн Хууль тогтоомжийн өөрчлөлтийн улмаас Концесс эзэмшигчийн зардал буурсан, цэвэр ашиг өссөн, санхүүгийн нөлөөллийн хувьд өмнөх Концессын жилтэй харьцуулахад арван хоёр аравны таван хувь (12.5%)-аар илүү гарсан санхүүгийн нөлөө санхүүгийн давуу байдал олж авсан бол Эрх бүхий этгээд нь энэ тухай мэдэгдлийг Концесс эзэмшигчид хүргүүлж, Концесс эзэмшигчийг санхүүгийн хувьд дээр дурдсан зардал бууруулсан, ашиг нэмэгдүүлсэн эсхүл бусад санхүүгийн давуу байдал олж авахад хүргэсэн Хууль тогтоомжийн өөрчлөлт ороогүй байсан бол байх байсан нөхцөл байдалд хүргэхэд шаардлагатай нэмэлт, өөрчлөлтийг Гэрээнд оруулах санал гаргаж болно. Эрх бүхий этгээдийн мэдэгдлийн үндсэн дээр Талууд мэдэгдэл хүргүүлснээс хойш гучин (30) өдрөөс хэтрүүлэхгүйгээр аль болох боломжит богино хугацааны дотор уулзаж, энэхүү Гэрээнд оруулах нэмэлт, өөрчлөлт эсхүл бусад харилцан тохиролцсон арга хэмжээний талаар тохиролцох ба 90 хоногийн дотор ийнхүү тохиролцоонд хүрч чадаагүй бол асуудлыг энэ Гэрээний 48 дугаар зүйл (Маргаан шийдвэрлэх)-ийн дагуу шийдвэрлүүлнэ. Эргэлзээ төрүүлэхээс зайлсхийх зорилгоор дурдахад, энэхүү 46.2 дах хэсэг нь Концесс эзэмшигчийн Гэрээгээр хүлээсэн үүргээ гүйцэтгэхэд гарах зардалд шууд нөлөөлөх Хууль тогтоомжийн өөрчлөлтийн хүрээнд хязгаарлагдахаар Талууд тохиролцсон болно.

46.3 Энэхүү Гэрээнд өөрөөр зааснаас үл хамааран Концесс эзэмшигч Хууль тогтоомжийн өөрчлөлтийн үр дагаврыг бууруулах арга хэмжээг өөрөө авах боломжтой бол Эрх бүхий этгээд нь аливаа хэлбэрээр нөхөн төлбөр төлөх үүрэг хүлээхгүй.

46.4 Талууд өөрөөр тохиролцсоноос бусад тохиолдолд энэхүү 46.1 эсхүл 46.2 дах хэсэг (Хууль тогтоомжийн өөрчлөлт)-т зааснаар харилцан тохиролцоонд хүрэх хүртэл эсхүл харилцан тохиролцоонд хүрээгүй бол маргааныг шийдвэрлэх хүртэл Талууд энэхүү Гэрээний дагуу хүлээсэн эрх, үүргээ хэрэгжүүлэн, Нисэх буудлын бизнесийн хэвийн үйл ажиллагааг үргэлжлүүлнэ.

47. ДААТГАЛ

47.1 Концесс эзэмшигч нь дор дурдсан даатгалыг хийлгэсэн байна. Үүнд:

47.1.1 Нисэх буудлын хариуцлагын даатгалд (үүнд ослын болон мэргэжлийн хариуцлагын даатгал хамаарах боловч эдгээрээр хязгаарлагдахгүй);

47.1.2 Гэрээний Хавсралт 4 (Удирдлага, зохион байгуулалтын нарийвчилсан хуваарь)-т заасан Концесс эзэмшигчийн хариуцах Концессын зүйл (CIQ барилга байгууламж, тоног төхөөрөмжийг оролцуулахгүй)-ийн хувьд эд хөрөнгийн даатгал;

- 47.1.3 Концесс эзэмшигчийн хөрөнгөөр бий болсон эд хөрөнгийн хувьд эд хөрөнгийн даатгал;
- 47.1.4 холбогдох Хууль тогтоомжид заасны дагуу Концесс эзэмшигчийн заавал даатгуулах бусад даатгалууд; болон
- 47.1.5 Салбарын сайн туршлагыг харгалзан, Концесс эзэмшигчийн зүгээс хангалттай хамгаалагдсан байхад шаардлагатай гэж үзсэн аливаа бусад даатгалууд (энэхүү Гэрээг хэрэгжүүлэхтэй холбоотой улс төрийн болон гуравдагч этгээдтэй холбоотой үүсч болох эрсдэлийг зохицуулах зорилго үүнд хамаарна) ("**Концесс эзэмшигчийн даатгалууд**").
- 47.2 Үйл ажиллагаа эхлэх өдрөөс өмнө Шилжилтийн төлөвлөгөөний дагуу Концессын зүйлийг шилжүүлэх үед Концесс эзэмшигчийн даатгал хүчинтэй байх болон Концессын хугацааны туршид хүчинтэй хэвээр байх явдлыг Концесс эзэмшигч хангана.
- 47.3 Концесс эзэмшигч нь Концесс эзэмшигчийн бүх даатгалын хураамжийг хариуцах ба Эрх бүхий этгээд болон/эсхүл түүний төлөөлөгч Концесс эзэмшигчийн даатгалын хамрах эрсдлийн хэмжээ, Концесс эзэмшигчийн даатгалын гэрээний нөхцөлийн талаар Концесс эзэмшигчид санал гаргаж болно.
- 47.4 Аливаа даатгалын нэхэмжлэл нь Нисэх буудлын бизнес, Гэрээний 11 дүгээр зүйл (Концесс эзэмшигчийн эрх, үүрэг) эсхүл 32 дугаар зүйл (Концесс эзэмшигчийн хохирол нөхөн төлөх баталгаа)-д заасан нөхөн төлбөрийн шаардлагад холбогдох бол даатгалын нэхэмжлэлтэй холбоотой бүх суутгагдах төлбөрийг Концесс эзэмшигч хариуцна.
- 47.5 Аливаа даатгалын нэхэмжлэл нь Эрх бүхий этгээдийн чиг үүрэг, Гэрээний 10 дугаар зүйл (Төрийн эрх бүхий байгууллага)-ийн дагуу бусад төрийн эрх бүхий байгууллагад хүлээлгэсэн үүрэг, Гэрээний 33 дугаар зүйл (Эрх бүхий этгээдийн хохирол нөхөн төлөх баталгаа) болон 34 дүгээр зүйл (Шилжүүлсэн Концессын зүйл, Шилжүүлсэн ажилтнууд болон гуравдагч этгээдтэй байгуулсан гэрээнүүдтэй холбоотой Эрх бүхий этгээдийн хохирол нөхөн төлөх баталгаа)-үүдэд заасан нөхөн төлбөрийн шаардлагад холбогдох бол даатгалын нэхэмжлэлтэй холбоотой бүх суутгагдах төлбөрийг Эрх бүхий этгээд хариуцна.
- 47.6 Энэхүү 47 дугаар зүйл (Даатгал)-д заасан Концесс эзэмшигчийн даатгалыг хүчин төгөлдөр байлгах үүргээ биелүүлээгүйгээс учирсан бүх зардал, хохирол, эрсдэлийг Концесс эзэмшигч өөрийн хөрөнгөөр бүрэн хариуцна.

- 47.7 Эрх бүхий этгээд болон Концесс эзэмшигчийн аль нь ч Концесс эзэмшигчийн аль нэг даатгалын хүрээнд даатгагч нь даатгалын нөхөн төлбөр төлөхөөс татгалзахад хүргэх ямарваа үйлдэл, эс үйлдэхүй гаргахгүй.
- 47.8 Даатгалын нөхөн төлбөрийг тухайн даатгалын зүйлд учирсан хохирлыг арилгахад зарцуулна.
- 47.9 Концесс эзэмшигч нь бүх даатгалыг Монгол Улсын хуулийн дагуу үүсгэн байгуулагдсан, Монгол Улсад үйл ажиллагаа явуулдаг давхар даатгали бүхий даатгалын компаниар хийлгэнэ.

АРВАНГУРАВДУГААР БҮЛЭГ. МАРГААН ШИЙДВЭРЛЭХ

48. МАРГААН ШИЙДВЭРЛЭХ

48.1 Эвийн журмаар шийдвэрлэх

- 48.1.1 Энэхүү Гэрээг тайлбарлах эсхүл хэрэгжүүлэхтэй холбоотой аливаа маргаан Талуудын хооронд үүссэн бол Талууд маргааныг юун түрүүн эвийн журмаар, хэлэлцээ хийх замаар шийдвэрлэхийг эрмэлзэнэ.
- 48.1.2 Хэрэв маргаан бүхий асуудлаар гэрээний нэг тал нөгөө талдаа мэдэгдэл хүргүүлсэн ба Талууд маргаан бүхий асуудлыг мэдэгдэл хүргүүлсэн өдрөөс хойш гуч (30) хоногийн дотор шийдвэрлэж чадаагүй бол Талуудын эрх бүхий дээд шатны төлөөлөл уулзалт зохион байгуулна.
- 48.1.3 Хэрэв дээрх дээд шатны төлөөлөл маргаан бүхий асуудлыг уулзалтаар шийдвэрлэж чадаагүй бол Талууд энэ зүйлийн дагуу томилсон хараат бус шинжээч эсхүл арбитраар маргааныг шийдвэрлүүлэхээр хандаж болно.
- 48.1.4 Энэхүү 48.1 дэх хэсэг (Эвийн журмаар шийдвэрлэх)-ийн аль ч заалт нь Талуудыг маргааны мэдэгдэлд заагаагүй болон/эсхүл хэлэлцээрийн зүйл байгаагүй болон/эсхүл маргааны зүйл болоогүй асуудлаар нэхэмжлэл, гомдол, сөрөг нэхэмжлэл, хариу шаардлага гаргах эрхийг хязгаарлахгүй болно.
- 48.1.5 Энэхүү Гэрээний 48.2 (Шинжээчийн дүгнэлт) болон 48.3 (Арбитр) дах хэсгүүд нь Монгол Улсын шүүхийн онцгой харьяалалд хамаарах эсхүл Хууль тогтоомжийн дагуу Монгол Улсын иргэний болон захиргааны хэргийн шүүхийг багтаагаад Монгол Улсын шүүхээр шийдвэрлүүлэх шаардлагатай маргаан бүхий асуудалд хамаарахгүй. Эргэлзээ төрүүлэхээс зайлсхийх зорилгоор

дурдахад, энэхүү Гэрээний 26.1.7 дах хэсгийг харгалзан, Зохицуулалттай төлбөр, хураамжтай холбоотой аливаа маргааныг Монгол Улсын холбогдох шүүхээр шийдвэрлүүлнэ.

48.2 Шинжээчийн дүгнэлт

48.2.1 Аль нэг тал нь маргааныг энэхүү Гэрээний 48.1.3 дах хэсэг (Эвийн журмаар шийдвэрлэх)-т заасны дагуу хөндлөнгийн шинжээчээр шийдвэрлүүлэхээр хандсан бол Талуудын эрх бүхий дээд шатны төлөөлөл маргааныг шинжээчээр шийдвэрлүүлэх талаар шийдвэрлэснээс хойш нэг (1) сарын дотор шинжээчийг харилцан тохиролцох замаар сонгоно. Шинжээч нь ашиг сонирхлын зөрчилгүй, маргаан бүхий Талуудын төлөөлөгч, ажилтан, гэрээт ажилтан биш бөгөөд өмнө нь түүний төлөөлөгч, ажилтан, гэрээт ажилтан байсан байж болохгүй

48.2.2 Талууд шинжээч сонгох асуудлаар нэг (1) сарын хугацаанд зөвшилцөлд хүрч чадаагүй бол хоёр Талын хүсэлтээр Олон улсын Шинжээчийн Төвөөс Олон улсын Худалдааны Танхимын Дүрмийн дагуу шинжээч томилно. Шинжээч өөрийн томилогдсон асуудлыг бичгээр хүлээн зөвшөөрч Талуудад хүргүүлснээр шинжээчийн томилгоо эхэлнэ.

48.2.3 Шинжээч нь арбитрч бус шинжээчийн хувиар ажиллах ба тодруулбал худалдааны арбитртай холбоотой хууль тогтоомж энэ ажиллагаанд үйлчлэхгүй.

48.2.4 Аль нэг тал нь шинжээчийн шийдвэр гарснаас хойш зургаан (6) сарын дотор маргааныг шийдвэрлүүлэхээр энэхүү Гэрээний 49.3 дах хэсэг (Арбитр)-т заасны дагуу арбитрт хандсанаас бусад тохиолдолд маргаан бүхий асуудлын талаарх шинжээчийн шийдвэр Талуудын хувьд заавал дагаж мөрдөх шинжтэй байна.

48.2.5 Шинжээчийн бүх үйл ажиллагаа Англи хэл дээр явагдана.

48.3 Арбитр

48.3.1 Аль нэг тал нь маргааныг энэхүү Гэрээний 48.1.3 дах хэсэг (Эвийн журмаар шийдвэрлэх)-т заасны дагуу арбитраар шийдвэрлүүлэхээр хандсан бол доорх 48.3.2 - 48.3.7 дах хэсгүүд (Арбитр) үйлчилнэ.

48.3.2 Талууд маргааныг Байнгын Арбитрын Шүүх ("БАШ") (Permanent Court of Arbitration) ЮНСИТРАЛ-ын Арбитрын Дүрмийн дагуу арбитраар шийдвэрлүүлэхээр харилцан тохиролцов.

Аль нэг тал нь БАШ-д арбитрын хүсэлт гаргасан тохиолдолд нөгөө тал нь хариу өгөх үүрэг хүлээнэ.

- 48.3.3 Арбитрын бүрэлдэхүүн 3 арбитрчаас бүрдэх ба Эрх бүхий этгээд нэг (1) арбитрч, Концесс эзэмшигч нэг (1) арбитрч тус тус томилох ба Талуудын томилсон арбитрчид харилцан тохиролцож даргалагч арбитрчийг сонгоно.
- 48.3.4 Арбитрын ажиллагааны хэл Англи хэл байна.
- 48.3.5 Арбитрын ажиллагаа Нидерланд Улсын Гааг хотод явагдана.
- 48.3.6 Арбитрын шийдвэр эцсийн бөгөөд заавал дагаж мөрдөх шинжтэй байх ба арбитрын шийдвэрийг эрх бүхий шүүхийн шийдвэрээр биелүүлж болно.
- 48.3.7 Талууд арбитрын шүүхийн шийдвэрийг бүрэн биелүүлэхээ үүгээр хүлээн зөвшөөрөв.
- 48.4 Энэхүү 48 дугаар зүйл (Маргаан шийдвэрлэх)-д баримтлах хууль нь Монгол Улсын холбогдох материаллаг хууль байна.
- 48.5 Энэхүү Гэрээний 48 дугаар зүйл (Маргаан шийдвэрлэх)-д заасан маргаан шийдвэрлэх процесс нь Гэрээ хүчин төгөлдөр байх эсэхээс үл хамааран хүчин төгөлдөр үйлчилнэ.
- 48.6 Аливаа маргаан үүссэн бөгөөд түүнийг шинжээч эсхүл арбитраар хэлэлцэж байгаа эсэхээс үл хамааран Талууд тухайн маргаантай асуудлаас бусад энэхүү Гэрээнд заасан холбогдох үүргийг үргэлжлүүлэн гүйцэтгэж, эрхийг хэрэгжүүлнэ.

АРВАНДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ. БУСАД ЗҮЙЛ

49. ГЭРЭЭНИЙ АШГИЙН ТӨЛӨӨ (АРИЛЖААНЫ) ШИНЖ ЧАНАР

- 49.1 Талууд Гэрээг Монгол Улсын Захиргааны ерөнхий хуульд тодорхойлсон захиргааны гэрээ бус, ашгийн төлөөх (арилжааны) гэрээ гэдгийг ойлгож, хүлээн зөвшөөрсөн болно.
- 49.2 Монгол Улсын хүчин төгөлдөр Хууль тогтоомжийн хүрээнд Эрх бүхий этгээд нь энэхүү Гэрээнд болон Гэрээнээс үүдэн гарсан эсхүл түүнтэй холбоотой аливаа маргаанд Монгол Улсын Захиргааны ерөнхий хууль үйлчилнэ хэмээн маргах буюу шаардах эрхгүй болно.
- 49.3 Энэхүү 49 дүгээр зүйл (Гэрээний ашгийн төлөө (арилжааны) шинж чанар)-ийг харгалзан:



49.3.1 энэхүү Гэрээний аль ч зүйл, заалт нь Концесс эзэмшигчийг Хууль тогтоомжийг дагаж мөрдөх үүргээс чөлөөлөхгүй; ба

49.3.2 энэхүү Гэрээний аль ч зүйл нь Засгийн газраас Эрх бүхий этгээдэд энэхүү Гэрээг байгуулах эрх олгосонтой холбоотой асуудлаар Хууль тогтоомжоос дээгүүр хүчин чадалтай гэж тайлбарлах үндэслэл болохгүй.

50. БАРИМТЛАХ ХУУЛЬ

50.1 Энэхүү Гэрээний 49 дүгээр зүйл (Гэрээний ашгийн төлөө (арилжааны) шинж чанар)-ийг харгалзан, энэ Гэрээнээс үүдэн гарсан эсхүл түүнтэй холбоотой аливаа маргааныг шийдвэрлэхдээ Монгол Улсын хууль тогтоомж, тэдгээрийн албан ёсны тайлбарыг баримтална. Гэрээгээр зохицуулаагүй аливаа маргааныг Монгол Улсын хүчин төгөлдөр мөрдөгдөж буй холбогдох Хууль тогтоомжийн дагуу зохицуулна.

50.2 Энэхүү Гэрээний зүйл, заалтыг ойлгоход зөрчилдөөн үүссэн тохиолдолд энэ зүйлийн хүрээнд Монгол Улсын Хууль тогтоомжийн дагуу тайлбарлана.

50.3 Энэхүү Гэрээний зүйл, заалт Монгол Улсын Хууль тогтоомжтой зөрчилдвөл Монгол Улсын Хууль тогтоомж давуу хүчин чадалтай байна.

51. НУУЦЛАЛ

51.1 Гэрээний нууцлалын талаарх үүрэг

51.1.1 Энэхүү Гэрээний 51.2 дах хэсэг (Гэрээний нууцлалын үүрэгт үл хамаарах зүйлс)-т заасныг харгалзан, аль ч Тал нь (нөгөө талын урьдчилан бичгээр өгсөн зөвшөөрөлгүйгээр) нууцлал бүхий мэдээлэл агуулж буй бүх хэлэлцээ, тохиролцоо, гэрээ, баримт бичиг болон бусад хэлбэрийн мэдээллийн нууцлалыг задруулах эрхгүй.

51.1.2 Нууцлал бүхий мэдээлэл гэдэгт барилга байгууламжийн төсөл, схем зураг, загвар, барилгын ажил, даатгал, үйл ажиллагаа, засвар үйлчилгээ, удирдлага, төслийн санхүүжилттэй холбоотой бүх баримт бичиг, тэдгээрт агуулагдсан мэдээлэл зэргийг оролцуулаад Хууль тогтоомжоор хамгаалагдсан мэдээллийг ойлгоно. Аль нэг талын үүрэгтэй холбоотой энэхүү Гэрээг хэрэгжүүлэх явцад олж авсан аливаа баримт бичиг болон мэдээлэл (техникийн эсхүл арилжааны эсэхээс үл хамааран)-ийг гагцхүү энэ Гэрээгээр хүлээсэн үүргийг гүйцэтгэх зорилгоор ашиглана.

51.1.3 Нууцлал бүхий мэдээлэл алдагдсанаас аль нэг Талд хохирол учирсан бол нөгөө Талаасаа Хууль тогтоомжийн дагуу учирсан хохирлыг нэхэмжлэх эрхтэй.

51.2 Гэрээний нууцлалын үүрэгт үл хамаарах зүйлс

Энэхүү Гэрээний 51.1 дэх хэсэг (Гэрээний нууцлалын талаарх үүрэг) дараах мэдээлэлд хамаарахгүй. Үүнд:

51.2.1 Концесс эзэмшигч, түүнтэй Нэгдмэл сонирхолтой этгээд болон Концесс эзэмшигчтэй хамаарал бүхий этгээдэд задруулсан мэдээлэл;

51.2.2 Эрх бүхий этгээд, түүнтэй Нэгдмэл сонирхолтой этгээд, Эрх бүхий этгээдтэй хамаарал бүхий этгээд болон ЧХОУНБ-д задруулсан мэдээлэл;

51.2.3 техникийн, хуулийн, нягтлан бодох бүртгэлийн, даатгалын болон бусад мэргэжлийн зөвлөгөө авахтай холбоотой итгэлцлийн үүргийн дагуу задруулсан мэдээлэл;

51.2.4 гэрээний нууцлалын үүргийг зөрчсөний улмаас биш байдлаар олон нийтэд ил болсон мэдээлэл;

51.2.5 аливаа шүүхийн маргаантай холбоотойгоор шүүхээс шаардсаны задруулсан мэдээлэл;

51.2.6 энэхүү Гэрээгээр зөвшөөрсний үндсэн дээр эрх шилжүүлэх болон бусад байдлаар эрхийг захиран зарцуулахтай холбоотойгоор задруулсан мэдээлэл;

51.2.7 энэхүү Гэрээгээр зөвшөөрсний үндсэн дээр хувьцаа худалдах буюу захиран зарцуулахтай холбоотойгоор хүлээн авч буй Тал эсхүл тухайн Талын толгой компанид задруулсан мэдээлэл;

51.2.8 мэдээллийг задруулж буй талд нөгөө талын зүгээс тусгайлан нууцлалын бус хэлбэрээр анх задруулсан мэдээлэл;

51.2.9 Хууль тогтоомж, нийтэд хүлээн зөвшөөрөгдсөн хөрөнгийн бирж, зохицуулах эрх бүхий байгууллагын дүрэм, журам эсхүл татварын эрх бүхий байгууллагын бичгээр гаргасан шаардлагын дагуу задруулсан мэдээлэл; эсхүл

51.2.10 Гэрээгээр илэрхий зөвшөөрсний дагуу задруулсан мэдээлэл.

Дээрхи 51.2.1, 51.2.2, 51.2.6 болон 51.2.7 дах хэсгүүд (Гэрээний нууцлалын үүрэгт үл хамаарах зүйлс)–ийн хувьд мэдээлэл задруулахаас

өмнө тухайн мэдээлэл хүлээн авч буй гуравдагч тал нь мэдээлэл задруулж буй талд энэ зүйлийн 51.1 дэх хэсэг (Гэрээний нууцлалын талаарх үүрэг) болон 51.2 дах хэсэг (Гэрээний нууцлалын үүрэгт үл хамаарах зүйлс)—т заасантай ижил нөхцөлөөр мэдээллийн нууцлалыг хадгалах баталгаа өгсөн байна.

52. ГЭРЭЭНИЙ НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ БОЛОН ТАТГАЛЗАЛ ХҮЧИН ТӨГӨЛДӨР БОЛОХ

52.1 Энэхүү Гэрээнд оруулах аливаа нэмэлт, өөрчлөлт зөвхөн Талууд бичгээр харилцан тохиролцож, Талуудын эрх бүхий этгээд гарын үсэг зурж, тамга дарснаар хүчин төгөлдөр болно.

52.2 Энэхүү Гэрээний аль нэг зүйл, заалтаас татгалзсан нь зөвхөн Талууд бичгээр тохиролцож, Талуудын эрх бүхий этгээд гарын үсэг зурж, тамга дарснаар хүчин төгөлдөр болно. Уг татгалзал нь зөвхөн тухайн тохиолдлын хувьд, түүнийг үйлдэх болсон зорилгын хэмжээнд хүчин төгөлдөр үйлчлэх ба ижил эсхүл өөр төрлийн бусад буюу дараа дараагийн зөрчилтэй холбоотой үйлчлэхгүй, тайлбарлагдахгүй.

52.3 Энэхүү Гэрээнд заасан эрх болон эрх хамгаалах арга хэмжээг хэрэгжүүлж чадаагүй эсхүл хэрэгжүүлэхийг хойшлуулсан нь тухайн эрх, эрх хамгаалах арга хэрэгслийг хэрэгжүүлэхээс татгалзсан гэх агуулгыг илэрхийлэхгүй бөгөөд эрх буюу эрх хамгаалах арга хэрэгслийг дангаар эсхүл хэсэгчлэн хэрэгжүүлсэн нь цаашид тухайн болон бусад эрх болон эрх хамгаалах арга хэрэгслийг хэрэгжүүлэхэд саад болохгүй.

53. ГЭРЭЭНИЙ ЦОГЦ БАЙДАЛ

53.1 Энэхүү Гэрээ, түүний хавсралтууд нь хамтдаа Гэрээний салшгүй хэсэг болох ба Талуудын хувьд заавал биелэгдэх хүчин чадалтай байна.

53.2 Энэхүү Гэрээг байгуулснаар Талуудын хооронд өмнө нь энд заасан асуудлаар аман болон бичгийн хэлбэрээр хийгдсэн бүх тохиролцоо, баталгаа, захидал харилцаа, яриа хэлэлцээ, санамж бичиг, хэлэлцээ хийх үеийн баримт бичиг, Талуудын ирүүлсэн төслийн саналыг хүчингүйд тооцно.

53.3 Энэхүү Гэрээний аль нэг заалт хүчин төгөлдөр бус эсхүл шүүхийн шийдвэрийн дагуу хэрэгжих боломжгүй болсон нь Гэрээний бусад заалтуудын хүчин төгөлдөр, хэрэгжих боломжтой байдалд нөлөөлөхгүй, түүнийг дордуулахгүй.

54. ГЭРЭЭНИЙ ХУВЬ

- 54.1 Энэхүү Гэрээг хэдэн ч хувь үйлдэж болох ба эдгээр нь хамтдаа нэг (1) бөгөөд ижил гэрээнд тооцогдоно. Аль ч Тал нь энэхүү Гэрээний аль нэг хувьд гарын үсэг зурах байдлаар энэхүү Гэрээг байгуулж болох ба Гэрээний Талуудын аль аль нь ийнхүү гарын үсэг зурснаар Гэрээ хүчин төгөлдөр болно.

55. ГУРАВДАГЧ ТАЛ ЭРХ ЭДЛЭХГҮЙ БАЙХ

Гэрээний аль ч зүйл, заалтыг Гэрээний Талуудаас бусад этгээд хэрэгжүүлэх эрхгүй.

56. ХАРИЛЦАХ ХАЯГ

- 56.1 Энэхүү Гэрээний дагуу Талуудын өдөр тутмын харилцаатай холбоотой аливаа заавар, харилцаа Монгол эсхүл Англи хэлээр бичгээр үйлдэгдэх ба Талуудын дор дурдсан хаягаар харилцана.

56.1.1 Эрх бүхий этгээдийн хувьд:

Хаяг: Улаанбаатар хот 15160, Нэгдсэн Үндэстний гудамж 5/1, Засгийн газрын 2-р байр

Цахим хаяг: info@nda.gov.mn

56.1.2 Концесс эзэмшигчийн хувьд:

Хаяг: Монгол Улс, Төв аймаг 41090, Сэргэлэн сум, 4-р баг, Тахилт толгой

Цахим хаяг: takeo.kato@mitsubishicorp.com

- 56.2 Дээрх 56.1 дэх хэсэг (Харилцах хаяг)-т заасан хаяг өөрчлөгдсөн тохиолдолд Талууд өөрчлөгдсөн өдрөөс хойш 5 (таван) Ажлын өдрийн дотор нөгөө талдаа бичгээр мэдэгдэнэ.

- 56.3 Дараах тохиолдолд мэдэгдлийг зохих ёсоор хүргүүлсэнд тооцно. Үүнд:

56.3.1 Шуудан зөөгчөөр эсхүл гарт нь хүргүүлсэн бол, заасан хаягаар хүргүүлсний дараа хүлээн авагч тал эсхүл түүний төлөөлөл хүлээн авч гарын үсэг зурж баталгаажуулснаар;

56.3.2 урьдчилан төлсөн шуудангаар илгээсэн бол, заасан хаягаар хүргүүлсний дараа хүлээн авагч тал эсхүл түүний төлөөлөл хүлээн авч гарын үсэг зурж баталгаажуулснаар;

56.3.3 имэйлээр хүргүүлсэн бол, хаяглагдсан этгээд уншиж болохуйц хэлбэрээр бодитоор хүлээн авснаар.

57. ГЭРЭЭНИЙ ХЭЛ

57.1 Энэхүү Гэрээг Монгол, Англи хэлээр үйлдэх бөгөөд хувь тус бүр ижил эх хувь байна. Гэрээний Монгол, Англи хэл дээрх хувилбаруудын хооронд зөрүү үүссэн тохиолдолд холбогдох зүйл заалтын зөрүүтэй байдлын хувьд Англи хэл дээрх хувилбарыг баримтална.

57.2 Гэрээг Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу Улсын бүртгэлийн байгууллагад бүртгүүлнэ.

57.3 Энэхүү Гэрээтэй холбоотой Талууд хоорондоо эсхүл Төрийн эрх бүхий байгууллага эсхүл ЧХОУНБ-тай солилцох аливаа албан захидал, мэдэгдэл, захидал харилцаа, бусад бичиг баримтыг Монгол хэлний тухай хуулийн дагуу Монгол болон Англи хэлээр үйлдэнэ.

Энэхүү Гэрээг Талууд 2019 оны 7 дугаар сарын 5-ны өдөр Улаанбаатар хотод байгуулав.

ЭРХ БҮХИЙ ЭТГЭЭДИЙГ ТӨЛӨӨЛЖ:

КОНЦЕСС ЭЗЭМШИГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

Гарын үсэг:

Гарын үсэг:

Нэр: БАНЗРАГЧИЙН БАЯРСАЙХАН

Name: ТАКЭО КАТО

Албан тушаал: Үндэсний Хөгжлийн газрын дарга

Албан тушаал: Нью Улаанбаатар Интернэй Эйрпорт ХХК-ийн Гүйцэтгэх захирал



Тамга:

Тамга:



Handwritten signature and mark at the bottom right corner.